



Нээлттэй
Нийгэм
Форум



МУИС-ийн
Эдийн Засгийн
Сургууль

Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тойм - 2006

Институцийн хөгжил - эдийн засгийн өсөлтийг
түргэтгэх шинэтгэлийн дараагийн үе шат

Улаанбаатар, 2006 он

DDC
330,9'517
X-299

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-48, Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>

Уг судалгаанд хийсэн дүгнэлт, гаргасан саналууд нь зөвхөн судалгааны багийн дүгнэлт, үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

Тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст номын арын хавтсан дээр бичсэн хямдралтай үнээр борлуулна.

ISBN 99929-0-125-X

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ч.ХАШЧУЛУУН	Ph.D (Багийн ахлагч)
С.ДӨЛБАДРАХ	Эдийн засгийн ухааны магистр
Т.ОЮУНБААТАР	Эдийн засгийн ухааны магистр
Г.БОЛОРМАА	Эдийн засгийн ухааны магистр
Б.МӨНХСОЁЛ	Нээлттэй Нийгэм Форумын менежер
Д.ЖАРГАЛСАЙХАН	(Багийн зөвлөх)

ГАРЧИГ

1. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ	9		
1.1 Танилцуулга	10		
1.1.1 Эдийн засгийн эрх чөлөө, эдийн засгийн өсөлт	11		
1.1.2 Эдийн засгийн эрх чөлөө, хөрөнгө оруулалтын үр өгөөж	13		
1.1.3 Эдийн засгийн эрх чөлөө, нийгмийн сайн сайхан байдал, хүний хөгжил	14		
1.1.4 Эдийн засгийн эрх чөлөө, орлогын хуваарилалт, ядуурлыг бууруулах бодлого	16		
1.2 Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний судалгаа	17		
1.3 Энэ жилийн Эдийн засгийн эрх чөлөөний тоймын гол асуудал	19		
2. МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН СУДАЛГАА	21		
2.1 Монголын эдийн засгийн өсөлтийн өнөөгийн байдал	22		
2.2 Эдийн засгийн өсөлтийн үзэл баримтлалууд	25		
2.3 Эдийн засгийн эрх чөлөө, байгалийн баялаг	26		
2.4 Эдийн засгийн эрх чөлөөг хэмжих	27		
2.4.1 Фрейзер Институтын Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс	27		
2.4.2 Херитэж Сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекс	28		
2.4.3 Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний байдал: Дэлхийн Эдийн Засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүд	30		
		2.4.4 Херитэж Сангийн «Эдийн засгийн чөлөөт байдлын индекс»: Монгол Улсын байдал, 2004-2005	34
		2.4.5 Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний өнөөгийн байдлын талаарх дүгнэлт	36
		2.5 Монголын ДНБ-ий боломжит түвшин	37
		2.6 Эдийн засгийн өсөлтийн дутуу ашиглагдаж байгаа боломжууд	38
		2.7 Эдийн засгийн эрх чөлөөний тоймын дэвшүүлж буй санал	41
		3. ИНСТИТУЦИЙН ХӨГЖИЛ	43
		3.1 Институцийн тухай	44
		3.2 Институци ба эдийн засгийн эрх чөлөө эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нь	44
		3.2.1 Монгол Улсын институцийн хөгжлийн загварчилсан судалгаа	47
		3.2.2 Онолын судалгааны дүн	49
		3.3 Институцийн үйл ажиллагаа	53
		3.3.1 Дүрэм, журам бий болгож, хэрэгжүүлэх	53
		3.3.2 Мэдээлэл болон таашаалыг нэгтгэх	53
		3.3.3 Эрсдлийг хуваарилах ба тодорхой бус байдлыг бууруулах	53
		3.3.4 Хүчин зүйлсийн ашиглалтыг оновчтой болгох	53
		3.3.5 Нөөцийг дахин хуваарилах	53

4. МОНГОЛ ДАХЬ ИНСТИТУЦИЙН ХӨГЖИЛ	55
4.1 Төрийн засаглал	56
4.2 Монголын өрсөлдөх чадвар	61
4.3 Авилга	65
5. МОНГОЛ ДАХЬ ТРАНСАКЦИЙН ЗАРДАЛ, ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, ӨМЧИЙН ЭРХ ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ	67
5.1 Трансакцийн зардал - ерөнхий ойлголт	68
5.2 Монгол дахь трансакцийн зардал	73
5.3 Монгол дахь өмчийн эрх	78
5.4 Гэрээний биелэлт	83
5.5 Монгол дахь институцийн хөгжлийн судалгаа: компаниудын жишээ	87
6. ДҮГНЭЛТ	95
7. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	99
8. ХАВСРАЛТ	103
1. Хавсралт: «Transparency International» байгууллагын «Corruption Perception Index - CPI» индексийг тооцох аргачлал	104
2. Хүснэгт 3. Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний утга	105
3. Хавсралт: Монгол Улсын институцийн хөгжлийн онолын шинжилгээ	106
4. Хавсралт: Монголын эдийн засгийн өсөлтийн эх үүсвэрүүд: салбар ба хэвслээр	108
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	117

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1.	Эрх чөлөө болон нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтүүдийн хамаарал	15
Хүснэгт 2.1.	1997-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлтийг бий болгосон гол салбарууд	24
Хүснэгт 2.2.	МУ-ын эдийн засгийн эрх чөлөөний индексийн нэгдсэн дүн	31
Хүснэгт 2.3.	«Засгийн газрын хэмжээ: Зарлага, татвар, үйлдвэрлэл» бүлгийн индекс	32
Хүснэгт 2.4.	«Эрүүл мөнгө хүртэх боломж» бүлгийн индекс	32
Хүснэгт 2.5.	«Гадаад худалдааны эрх чөлөө» бүлгийн индекс	33
Хүснэгт 2.6.	«Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт» бүлгийн индекс	33
Хүснэгт 2.7.	Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийн харьцуулалт	36
Хүснэгт 2.8.	Хувийн хэвшлийн тухайн салбарын ДНБ-д эзлэх хувь	39
Хүснэгт 2.9.	Хувийн хэвшлийн нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн нөлөө, салбараар	40
Хүснэгт 2.10.	Хувийн хэвшил 1999-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр	41
Хүснэгт 3.1.	Эдийн засгийн эрх чөлөө ба эрх зүйн орчны хамаарал	51
Хүснэгт 4.1.	Монгол Улс: Засаглалын үзүүлэлт	59
Хүснэгт 4.2.	Монгол Улсын авилгын индекс (CPI)	65
Хүснэгт 5.1.	Трансакцийн салбарын бүтэц: ДНБ-д эзлэх хувиар, 1990-2004	73
Хүснэгт 5.2.	Трансакцийн салбар дахь ажил эрхлэлт, 2001-2004	75
Хүснэгт 5.3.	Зарим шилжилтийн улс орнуудын трансакцийн салбарын ДНБ-д эзлэх хувь	75
Хүснэгт 5.4.	Дэлхийн улс орнуудын бизнесийн орчны үнэлгээ	77
Хүснэгт 5.5.	Монгол Улс дахь гэмт хэргийн төрөл, 2002-2004	84

ЗУРАГ

Зураг 1.1. Эдийн засгийн эрх чөлөө ба эдийн засгийн өсөлт, 1980-2000	11
Зураг 1.2. Эдийн засгийн эрх чөлөө ба нэг ажилчинд ногдох хөрөнгө оруулалт, 1980-2000	12
Зураг 1.3. Эдийн засгийн эрх чөлөө ба ДНБ дэх нийт, хувийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь, 1980-2000	13
Зураг 1.4. Эдийн засгийн эрх чөлөө ба хөрөнгө оруулалтын бүтээмж 1980-2000	14
Зураг 1.5. Эдийн засгийн эрх чөлөө ба ядуучуудын орлого	16
Зураг 1.6. Ядуучуудын орлогын хувь нийт орлогод, 2002	17
Зураг 2.1. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт, 1990-2004	22
Зураг 2.2. Монгол Улсын макро эдийн засгийн өсөлт, ДНБ-ий хувиар, 1993-2005	23
Зураг 2.3. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс	34
Зураг 2.4. Херитэж Сангийн индексийн үзүүлэлтийн өөрчлөлт, 1997-2006	35
Зураг 3.1. Эдийн засгийн өсөлт дэх институцийн нөлөө	54
Зураг 4.1. Монгол Улсын засаглал ба хүн амын амьжиргаа	57
Зураг 4.2. Монгол Улсын Засаглалын чанарын өөрчлөлт, 1996-2004	60
Зураг 5.1. Трансакцийн зардлын ангилал	68
Зураг 5.2. Эдийн засгийн хүчин чадал, төрөлжилт болон арилжааны эдийн засаг	70
Зураг 5.3. Трансакцийн салбарын ДНБ-д эзлэх хувь, 1990-2004	74
Зураг 5.4. Трансакцийн зардал, ДНБ-д эзлэх хувиар	76
Зураг 5.5. Трансакцийн зардал ДНБ-д эзлэх хувь ба нэг хүнд ногдох ДНБ	76
Зураг 5.6. Монгол Улс дахь компаний хэмжээ ба трансакцийн зардал	93

ТОВЧИЛСОН ҮГС

ДЭЗЭЧИ	Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс
ЭЗЭЧИ	Эдийн засгийн эрх чөлөөний индекс
ДЭЗЭЧТ	Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ФИ	Фрейзер Институт
ХС	Херитэж Сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ХАА	Хөдөө аж ахуй
ХБО	Хөгжиж буй орон
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ДБ	Дэлхийн Банк
ОУВС	Олон Улсын Валютын Сан
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ДДӨЧИ	Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс
ӨӨЧИ	Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс
БӨЧИ	Бизнесийн өрсөлдөх чадварын индекс
ДДӨЧТ	Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан
TI	Transparency International
CPI	Corruption Perception Index

1. Эдийн засгийн эрх чөлөө

1.1 ТАНИЛЦУУЛГА

Сонгодог эдийн засгийн онолыг үндэслэгч, Их Британий алдартай эдийн засагч Адам Смит хувийн өмчийг төрөөс удирдаж зохицуулах буюу эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах зорилготой аливаа төрийн зөвлөл, байгууллага эсвэл төрийн зүтгэлтний оролдлого эдийн засагт аюул учруулж болзошгүйг 230 жилийн өмнө анхааруулсан байна. Тэрээр “Үндэстний баялгийн мөн чанар, учир шалтгааны лавлагаа” хэмээх эдүгээ ч ач холбогдлоо алдаагүй суут бүтээлдээ “Хүмүүст эдийн засгийн эрх чөлөөг өг!” хэмээн уриалаад номынхоо эхнээс эцэс хүртэл “жам ёсны эрх чөлөө” буюу хувь хүн төрийн оролцоогүйгээр юу хүссэнээ хийх эрх чөлөөний зарчмыг өмгөөлсөн байдаг.

Хүн төрөлхтний түүхээс үзэхэд эдийн засгийн эрх чөлөө, улс үндэстний хөгжил цэцэглэл хоёр хоорондоо нягт холбоотой байжээ. Энэ холбоог Жеймс Гвартней, Роберт Лоусон, Вольтэр Блок нар өөрсдийн судалгаагаар (1996) баталжээ. Эдийн засгийн эрх чөлөө нь хүмүүсийг эд хөрөнгийн хувьд илүү баян амьдрал руу хөтлөөд зогсохгүй, тэдний эдлэх ёстой хамгийн суурь эрхийг хамгаалж байдаг.

Эдийн засгийн эрх чөлөө хувь хүний сонгох, солилцох, өрсөлдөх эрх чөлөө болон эд хөрөнгийн халдашгүй эрх зэрэг тулгуур ухагдахуунуудыг агуулдаг. Эдийн засгийн эрх чөлөөг “чөлөөт байдлыг хадгалан хамгаалахад шаардагдах хэмжээнээс хэтрэхгүй бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээний хүрээн дэх төрийн нөлөөлөл эсвэл хязгаарлалт юм¹ гэж тодорхойлжээ /онлайн: Википедиа энциклопеди, Херитэж Сан/. Өөрөөр хэлбэл зах зээлийн шаардлагаас

¹ Economic freedom is defined as “the absence of government coercion or constraint on the production, distribution, or consumption of goods and services beyond the extent necessary for citizens to protect and maintain liberty itself” [1], http://en.wikipedia.org/wiki/Index_of_Economic_Freedom

хэтэрсэн төрийн зохицуулалт байх ёсгүй гэсэн үг. Сүүлийн хориод жилийн дэлхий дахины олон судалгаанаас харахад эдийн засгийн эрх чөлөөг дээдэлсэн нийгмийн тогтолцоо ба бодлого нь хувь хүмүүсийн эд баялгийг хамгаалж, аливаа сонголтыг чөлөөтэй хийх, бараа бүтээгдэхүүн, баялгийг чөлөөтэй солилцох боломжийг олгож байжээ. Гвартней, Лоусон (“Эдийн засгийн эрх чөлөөний 10 үр дүн”, 2004)² нар 100 гаруй улсын 1980-2000 оны тоо баримтад тулгуурлан шинжилгээ хийгээд эдийн засгийн эрх чөлөө дараахь 10 үр дүнг авчирдгийг тогтоожээ:

1. *Эдийн засгийн өндөр өсөлт: 1993-2002 онд эрх чөлөө өндөр орнуудад эдийн засгийн өсөлт дунджаар 2.4% байсан бол эрх чөлөө доогуур орнуудынх дунджаар -0.5% байжээ.*

2. *Хөрөнгө оруулалт их: 1980-2000 онд эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад нэг хүнд ногдох гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрх чөлөө доогуур орнуудынхаас 45 дахин их байжээ.*

3. *Хөрөнгө оруулалтын өгөөж их: Эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудын хөрөнгө оруулалтын өгөөж нь эрх чөлөө доогуур орнуудынхаас 70%-иар давж байсан.*

4. *Ядуурлыг бууруулдаг: Эдийн засгийн эрх чөлөө доогуур орнуудын ядуусын орлого 2002 онд дунджаар 823 доллар байсан бол эрх чөлөө өндөр орнуудад хүн амын хамгийн ядуу 10% нь дунджаар 6877 долларын орлоготой байсан байна.*

5. *Орлогын хуваарилалт илүү тэгш хийгддэг: Эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад хүн амын хамгийн ядуу 10%-ийн орлогын нийт орлогод эзлэх хувь эрх чөлөө доогуур орнуудынхаас 20%-иар өндөр байна.*

6. *Хүн амын дундаж наслалт өндөр: Эдийн засгийн эрх чөлөө хамгийн өндөр орнуудад хүн*

² J. Gwartney, R. Lawson, NCPA Policy Report No. 268, July 2004, ISBN #1-56808-137-5, National Center for Policy Analysis

амын дундаж наслалт 76 байхад эрх чөлөө доогуур орнуудад 54 байна.

7. Эх нялхсын эндэгдэл бага: Энэ үзүүлэлт эдийн засгийн эрх чөлөө доогуур орнуудад эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудынхаас 9 дахин өндөр байна.

8. Хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, бусад сайн сайхан байдлын үзүүлэлтүүд эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад илүү өндөр байна.

9. Эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад институци нь илүү нээлттэй, авилга бага байдаг байна.

10. Эдийн засгийн эрх чөлөө нь улс төрийн эрх чөлөө болон ардчиллыг дэмждэг бөгөөд эдгээр нь хоорондоо нягт холбоотой.

Үүнээс харахад хуулийг дээдэлсэн эдийн засгийн эрх чөлөө нь шинээр ажлын байр бий болгож, хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулан хүмүүсийн амьжиргааг дээшлүүлдэг байна. Харин эдийн засгийн

эрх чөлөөг хязгаарлах оролдлогууд нь эдийн засгийн үйл ажиллагаанд саад тотгор учруулж, өсөлтийг бууруулж, улмаар ядуурлыг бий болгож байдгийг олон зуун жилийн дэлхийн түүх, улс орнуудын жишээ харуулдаг. Эдийн засгийн эрх чөлөөний энэ нөлөөг бид дараахь бүлгүүдэд нарийвчлан судлах болно.

1.1.1 Эдийн засгийн эрх чөлөө, эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн эрх чөлөө нь эдийн засгийн өсөлтийг хэд хэдэн сувгаар идэвхжүүлдэг. Газар зүйн байршил, капитал багтаамж (нэг хүнд ногдох капиталын хэмжээ), технологи, хөдөлмөрийн чадвар зэрэг үзүүлэлт бүгд ижилхэн байхад эрх чөлөө өндөр эдийн засаг илүү хурдацтай хөгждөг нь дараахь тоо, баримтаас харагдаж байна. Эдийн засгийн эрх чөлөө өндөр, институци нь эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж, саад болдоггүй улсууд илүү өндөр өсөлттэй байна. (Зураг 1.1.)

Зураг 1.1. Эдийн засгийн эрх чөлөө ба эдийн засгийн өсөлт: нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн дундаж өсөлт ба эдийн засгийн эрх чөлөөний индекс, 1980-2000



Эх сурвалж: Фрейзер Институтийн Эдийн Засгийн Эрх Чөлөөний Тайлан-2004, ЭЗЭЧИ – Эдийн засгийн эрх чөлөөний индекс – индексийн утга өндөр байх тусмаа эдийн засгийн эрх чөлөө өндөр байна.

Дэлхийн 94 улсыг эдийн засгийн эрх чөлөөний ерөнхий индексээр^a нь 7-оос дээш нь дээд бүлэг, 5-7 нь дунд бүлэг, 5-аас бага нь доод бүлэг гэсэн гурван үндсэн бүлэг болгон хуваан авч үзэхэд 1980-2000 онуудад нэг хүнд ногдох бодит ДНБ-ий жилийн дундаж өсөлт дээд бүлэгт 2.81%, дунд бүлэгт 1.41%, доод бүлэгт 0.1% байжээ. Орлогын түвшний ялгаатай байдал, газарзүйн байршлын үзүүлэлтүүд болон хүмүүн капиталыг нь харгалзан регрессийн загвараар үнэлэхэд дээрх өсөлтийн түвшнүүд харгалзан 3.44%, 1.67%, 0.37% байна. **Өөрөөр хэлбэл дээрх хүчин зүйлс тогтмол байхад ч эдийн засгийн эрх чөлөөний ялгаатай байдал нь урт хугацаанд дээрх өсөлтийн харьцангуй зөрүүтэй, дундаж түвшинг хадгалж байна.**


Эдийн засгийн эрх чөлөө өндөр орны эдийн засаг яагаад өндөр өсөлттэй байдаг вэ гэсэн асуултын нэг хариулт нь эдгээр оронд **хөрөнгө оруулалт их хэмжээгээр төвлөрсөн байдаг явдал** гэж хэлж болно.

1980-2000 оны хооронд нэг ажилчинд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ дээд

бүлэгт 10871 ам.доллар, дунд бүлэгт 3319 ам.доллар байсан бол доод бүлэгт энэ нь дөнгөж 845 ам.доллар буюу дээд бүлгийнхээс 12 дахин бага байсан нь хөрөнгө оруулалт нь институцийн орчинг илүү мэдэрдэг учир институцийг дэмжсэн, хөгжүүлсэн, эдийн засгийн эрх чөлөөтэй илүү нийцтэй бодлого баримталсан улс орнуудад хөрөнгө оруулалтын түвшин харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна. (Зураг 1.2.)

Эдийн засаг дахь нийт хөрөнгө оруулалт нь улсын болон хувийн хөрөнгө оруулалтаас бүрддэг ба хөрөнгө оруулалтын нэг хэлбэр болох гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх нь хувийн хөрөнгө оруулалт байдаг. Ер нь эдийн засгийн эрх чөлөө доогуур орнуудад улсын хөрөнгө оруулалтын эзлэх хувь нь хувийн хөрөнгө оруулалтаас өндөр байх хандлагатай. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргагчдын сонголтод институцийн чанар хэрхэн нөлөөлж байгааг илэрхийлэх хамгийн тод үзүүлэлт нь гадаадын хөрөнгө оруулалт болж өгдөг. Үүний баталгаа нь 1980-2000 онд нэг ажилчинд ногдох

Зураг 1.2. Эдийн засгийн эрх чөлөө ба нэг ажилчинд ногдох хөрөнгө оруулалт, 1980-2000



Эх сурвалж: Фрейзер Институтийн Эдийн Засгийн Эрх Чөлөөний Тайлан-2004, ЭЗЭЧИ – Эдийн засгийн эрх чөлөөний индекс – индексийн утга өндөр байх тусмаа илүү нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байна.

гадаадын шууд хөрөнгө оруулалтын түвшин дээд бүлэгт 3117 ам.доллар, дунд бүлэгт 444 ам.доллар, доод бүлэгт 68 ам.доллар байснаас харагдаж байна. Энэ бүгд нь *нэгдүгээрт*, эдийн засгийн эрх чөлөө сайжрах тусам гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс нэмэгддэг, *хоёрдугаарт*, институци болон эдийн засгийн эрх чөлөө харилцан шууд хамааралтай, бие биенээ нөхцөлдүүлдэг гэдгийг харуулж байна.

Хөрөнгө оруулалтын өөр нэг тодорхойлолт нь түүний ДНБ-д эзлэх хувийн жин юм. 1980-2000 оны хооронд дээд бүлгийн хувьд хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх дундаж хувь 22.78% байсан бол доод бүлэгт энэ нь 18.63% байжээ. Зөвхөн хувийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувийг авч үзэхэд дээд бүлэгт 18.02%, дунд бүлэгт 14.23%, доод бүлэгт 9.57% байгаа нь дээд, доод бүлгийн үзүүлэлтүүд хоорондоо бараг 2 дахин ялгаатай байгааг харуулж байна.

Регрессийн загварын үнэлгээгээр эдийн засгийн эрх чөлөөний түвшний хөрөнгө

оруулалтын ДНБ-д эзлэх хувиас хамаарсан хамаарал нь эерэг ба статистикийн хувьд найдвартай гарсан.


1.1.2 Эдийн засгийн эрх чөлөө, хөрөнгө оруулалтын үр өгөөж

Эдийн засгийн эрх чөлөө өндөртэй оронд хөрөнгө оруулалт илүү ихээр хийгддэгийн гол шалтгаан нь эдийн засгийн эрх чөлөө хөрөнгө оруулалтын өгөөжид бас нөлөөдөгт байгаа юм.

Хувийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувийн жингийн нэг пунктын өсөлт нь нэг хүнд ногдох ДНБ, газарзүйн байршлын үзүүлэлтүүд, хүмүүний капитал дахь өөрчлөлт болон улсын хөрөнгө оруулалтууд өөрчлөлтгүй буюу тогтмол байхад урт хугацаанд нэг хүнд ногдох ДНБ өсөлтийн түвшинг дээд бүлэгт 0.33, дунд бүлэгт 0.27, доод бүлэгт 0.19 пунктээр тус тус нэмэгдүүлж байна. (Зураг 1.3.)

Дээд бүлгийн хөрөнгө оруулалтын өгөөж доод бүлгийнхээс 70%-иар илүү

Зураг 1.3. Эдийн засгийн эрх чөлөө ба ДНБ дэх нийт, хувийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь, 1980-2000



Эх сурвалж: Фрейзер Институтийн Эдийн Засгийн Эрх Чөлөөний Тайлан-2004, ЭЗЭЧИ – Эдийн засгийн эрх чөлөөний индекс – индексийн утга өндөр байх тусмаа илүү эдийн засгийн эрх чөлөөтэй байна.

байна. Зөвхөн буурай хөгжилтэй орнуудын өгөгдлийг ашиглан дээрх шинжилгээг хийхэд ерөнхий хандлага адилхан, харгалзан 0.35, 0.27, 0.21 пункт байна. (Зураг 1.4.)

Өөр нэг чухал үр дүн нь, улсын хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь нэг пунктээр нэмэгдэхэд урт хугацааны нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт буурай хөгжилтэй орнууд \БХО\ болон бусад бүх улсын хувьд ижил 0.17 пунктээр нэмэгдэж байгаа нь улсын хөрөнгө оруулалтын үнэлэгдсэн өгөөж нь маш бага, эдийн засгийн эрх чөлөө доогуур улсуудын хувийн хөрөнгө оруулалтын өгөөжөөс ч бага байна.

1.1.3 Эдийн засгийн эрх чөлөө, нийгмийн сайн сайхан байдал, хүний хөгжил


Аливаа төрийн зүгээс эдийн засагт оролцож, түүнд нөлөөлж байгаа нэг том шалтгаан, шаардлага нь нийт хүн амынхаа буюу нийгмийнхээ сайн сайхан байдлыг хангах, түүнийг үргэлж сайжруулж, чанаржуулахад оршдог. Нөгөө талаас нийгмийн сайн

сайхан байдал нь тухайн улс орны эдийн засгийн хөгжил, нийгмийн хүч чадлын нэг хэмжүүр, гол үзүүлэлт нь болдог. Нийгмийн сайн сайхан байдал болон хүний хөгжлийг хангах нь тэнцвэржсэн, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгохоос ихээхэн хамаардаг. Тэнцвэржсэн гэдэг нь эдийн засгийн өсөлтийн үр ашгийг хүн бүхэнд харьцангуй тэгш хуваарилах ёстой гэсэн утгыг илэрхийлнэ.

Тухайн нийгмийн сайн сайхан байдал хэр зэрэг хангагдсан байна вэ гэдгийг тодорхойлж, хэмждэг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үзүүлэлтүүд байдаг. Тухайлбал, хүний хөгжлийн индекс; нэг хүнд ногдох орлого; орлогын өсөлт; боловсрол; эрүүл мэнд; нийгмийн халамжийн үйлчилгээний үзүүлэлтүүд болох бичиг үсэгт тайлагдсан байдал; ахуйн хэрэглээний хангамж; нялхсын эндэгдлийн түвшин зэрэг нь хамгийн суурь хэмжилт, үзүүлэлт болдог.

Иймээс нийгмийн сайн сайхан байдал хангагдаж буй байдалд эдийн засгийн эрх чөлөө ямар нөлөөтэй байгааг тодорхойлох

Зураг 1.4. Эдийн засгийн эрх чөлөө ба хөрөнгө оруулалтын бүтээмж, 1980-2000



Эх сурвалж: Фрейзер Институтийн Эдийн Засгийн Эрх Чөлөөний Тайлан-2004, ЭЗЭЧИ – Эдийн засгийн эрх чөлөөний индекс – индексийн утга өндөр байх тусмаа илүү эдийн засгийн эрх чөлөөтэй байна.

Хүснэгт 1.1. Эдийн засгийн эрх чөлөө ба нийгмийн сайн сайхан байдлын хамаарал

	Үзүүлэлтүүд	Хамаарал	Тайлбар
Эдийн засгийн эрх чөлөө	Нэг хүнд ногдох орлого	Эерэг	Эдийн засгийн эрх чөлөө өндөр улс орнуудын нэг хүнд ногдох орлого харьцангуй өндөр байна.
	Эдийн засгийн өсөлт	Эерэг	Эдийн засгийн эрх чөлөө өндөр улс орнуудын эдийн засгийн өсөлт өндөр байна.
	Дундаж наслалт	Эерэг	Хамгийн өндөр эдийн засгийн эрх чөлөөтэй улсуудын дундаж наслалт хамгийн доогуур улс орныхоос 20 насаар илүү байна.
	Хамгийн ядуу 10%-ийн орлогын түвшин	Эерэг	Эдийн засгийн эрх чөлөө өндөр улс орнуудын хамгийн ядуу 10%-ийн орлогын түвшин харьцангуй их байна.
	Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт	Эерэг	Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт эдийн засгийн эрх чөлөөтэй хамтдаа өсөж байна.
	Нялхсын эндэгдэл	Сөрөг	Эдийн засгийн эрх чөлөө өндөртэй улсуудад нялхсын эндэгдэл харьцангуй бага байна.
	Ажиллах хүчин дэх хүүхдийн эзлэх хувь	Сөрөг	Хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ эдийн засгийн эрх чөлөө нэмэгдэхэд буурч байна.
	Сайжруулсан усан хангамжид холбогдсон байдал	Эерэг	Сайжруулсан усан хангамжид холбогдсон байдал эдийн засгийн эрх чөлөө нэмэгдэхийн хэрээр сайжирна.
Хүний хөгжил	Эерэг	Эдийн засгийн эрх чөлөөний өндөр түвшин НҮБ-ээс тооцдог “Хүний хөгжил”-ийн индексийн өндөр утгатай холбогдож байна.	

нь сонирхолтой асуудал юм. Учир нь төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хангаснаар, өөрөөр хэлбэл эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж, түүнд чиглэгдсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлснээр төрийн зүгээс эдийн засгийн харилцаанд оролцох үйл ажиллагаа, хэрэгжүүлэх бодлого нь тодорхой болно.

Энэ асуудалд тодорхой хэмжээгээр хариулт өгөх нэгэн судалгааны үр дүнг “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан-2004”-өөс товчлон танилцуулъя. Уг тайлан 2002 оны тоон өгөгдөл, мэдээ мэдээллийг ашиглан Фрейзер Институтын аргачлалаар дэлхийн 123 орны эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлыг индексээр тодорхойлсон. Индексээ хамгийн бага, дөрөвдүгээр, гуравдугаар, хоёрдугаар, хамгийн дээд гэсэн 5 бүлэг болгон хувааж дээр тодорхойлсон нийгмийн сайн сайн сайхан байдлын үзүүлэлтүүдтэй ямар

энгийн хамааралтай байгааг тодорхойлжээ (Хүснэгт 1.1.).

Дээрхээс харахад зах зээлийн эдийн засгийн системтэй дэлхийн улс орнуудын хувьд эдийн засгийн эрх чөлөө сайжрахад хүний сайн сайхан байдал, хөгжлийн үзүүлэлт сайжирдаг нийтлэг нэгэн хамаарал, хандлага оршин байна.

1.1.4 Эдийн засгийн эрх чөлөө, орлогын хуваарилалт, ядуурлыг бууруулах бодлого

2004 онд хэвлэгдсэн Эдийн засгийн эрх чөлөөний тайланд ядуурал, орлого хуваарилалтын тухай дараахь дүнг нийтэлсэн байсныг дээр дурдсан. Эдийн засгийн эрх чөлөө доогуур орнуудын ядуус 2002 онд дунджаар 823 долларын орлоготой байсан бол эрх чөлөө өндөр орнуудад хүн амын хамгийн ядуу 10% нь 6877 долларын орлоготой байсан байна.

Энэ нь эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад ядуусын орлого өндөр байдаг гэсэн чухал үр дүнг илтгэж байна. Гэтэл байгалийн баялаг ихтэй зарим оронд (тухайлбал Латин Америк, ОХУ) эдийн засгийн өсөлтийн хурд болон нэг хүнд ногдох ДНБ-ий нэрлэсэн үзүүлэлт өндөр байдаг ч нийгмийн баялгаас орж байгаа бодит орлого нь цөөн олигархуудын гарт төвлөрч, нийт хүн амд хүртээлгүй байдаг. (Зураг 1.5.)

Эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад ядуусын нэрлэсэн орлогын доод

түвшин өндөр байдаг нь орлогын түвшин ерөнхийдөө өндөр байдагтай нь холбоотой.

Үүнтэй холбоотой дараагийн чухал асуудал нь орлогын хуваарилалт юм. Гвартней, Лоусон хоёрын судалгаанаас харахад “Эдийн засгийн эрх чөлөө өсөх тусам орлогын хуваарилалт нь илүү тэгш болдог. Эдийн засгийн эрх чөлөө өндөр орнуудад хүн амын хамгийн ядуу 10%-ийн нийт орлогод эзлэх хувь эрх чөлөө доогуур орнуудтай харьцуулахад 20%-иар өндөр байна” гэсэн дүн гарчээ. Мөн эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлснээр орлого хуваарилалтад сөрөг нөлөө гардаггүй гэдгийг Зураг 1.6 харуулж байна.

Мөн орлого хуваарилалтын энэ байдал нь Николас Берггрений 1975–1985 онд хийсэн 102 орныг хамарсан “Эдийн засгийн эрх чөлөө болон орлого хуваарилалтын хоорондын хамаарал”-ын судалгаагаар батлагдсан ба эдийн засгийн эрх чөлөөний өсөлт, ялангуяа гадаад худалдаа болон санхүүгийн либеральчлал нь орлого хуваарилалтыг сайжруулсан гэсэн дүгнэлт

Зураг 1.5 Эдийн засгийн эрх чөлөө ба ядуучуудын орлого



Эх сурвалж: J. Gwartney, R. Lawson, NCPA Policy Report No. 268, July 2004, ISBN #1-56808-137-5, National Center for Policy Analysis, James Gwartney and Robert Lawson, Economic Freedom of the World: 2004, Annual Report (Vancouver, BC: Fraser Institute, 2004),

Зураг 1.6 Ядуучуудын орлогын хувь нийт орлогод, 2002



Эх: J. Gwartney, R. Lawson, *NCPA Policy Report No. 268, July 2004, ISBN #1-56808-137-5, National Center for Policy Analysis, James Gwartney and Robert Lawson, Economic Freedom of the World: 2004, Annual Report (Vancouver, BC: Fraser Institute, 2004)*,

гаргасан байна³. Энэ бол маш чухал зүйл юм. Үүний талаар бид дараахь бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзэх болно.

1.2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ СУДАЛГАА

Өнөөдөр Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилал, зах зээлийн тогтолцоо, эдийн засгийн эрх чөлөөг эрхэмлэсэн нийгэм рүү буцалтгүй шилжиж эхлээд 15 жил боллоо. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засгийг нээлттэй болгох, хувийн секторыг хөгжүүлэх, төрийн оролцоог багасгах, зах зээлийн эдийн засагт тулгуурласан төрийн эдийн засгийн зохицуулалтыг бий болгох олон чухал алхам хийгдсэн. Хуучин капиталист орнуудын хүрээнд хаалттай байсан эдийн засгаа нээлттэй болгон дэлхийн эдийн засагт нэгдэх, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийг бий болгох чиглэлээр багагүй

амжилт олсон. Өнөөдөр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний дөрөвний гурвыг хувийн хэвшил үйлдвэрлэж байна. Энэ өөрчлөлт шинэчлэлтийн нэг салшгүй хэсэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжиж, түүнийг татах бодлого байсан. Хэдийгээр ийм богино хугацаанд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн нь хөгжиж буй орны хувьд чамлахааргүй үзүүлэлт боловч өнөөдөр Монгол Улсад олон шатны авилга, нийтийг хамарсан ядуурал, эдийн засагт хэрэгжүүлэх төрийн оновчтой бодлогын дутмаг байдал, эдийн засгийн эрх чөлөөг ил ба далд аргаар боогдуулсан олон хэлбэрийн хүнд суртал ажиглагдаж байгаа нь нууц биш. Энэ нь эдийн засгийн хөгжлийг удаашруулж, нөөцийн үр ашиггүй хуваарилалт, алдагдлыг бий болгож байгаа гол шалтгаанууд гэж хэлж болно. Иймээс Монголын эдийн засгийн эрх чөлөөг судалж түүнийг бодитойгоор хэмжих, улс орны хөгжилд учирч байгаа бэрхшээл, асуудлыг ил тод гаргаж нийтээр хэлэлцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

³ Niclas Berggren, "Economic Freedom and Equality: Friends or Foes?" *Public Choice*, Vol. 100, Issue 3, September 1999.

2005 онд Нээлттэй Нийгэм Форум Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөг олон улсын хэмжээнд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тодорхойлох санаачлага гаргаж Фрейзер Институтэд хандсанаар түүний дотоодын түнш байгууллагаар ажиллаж, Монголын эдийн засгийн эрх чөлөөний анхны судалгааг хийсэн билээ. Нээлттэй Нийгэм Форумын санаачлагаар хийгдсэн уг судалгаанд Монголын сургалт судалгаа, академийн олон байгууллага оролцож, 15 судлаач, шинжээчид 4 баг болж дараахь 4 чиглэлээр индексийг тооцсон. *Монгол Улсын хувьд анх удаа уг индексийн зэрэглэлд орж байгаа бөгөөд нийт авч болох 10 онооноос 6.2 оноо авч, 130 орноос 74 дүгээр байранд орсон байна.*

Эдийн засгийн эрх чөлөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдээр Монгол улсын авсан оноог харуулбал:

- *Төр засгийн хэмжээ: 6.5 (47 дугаар байр)*
- *Эрх зүйт төр: 2.2 (123 дугаар байр)*
- *Эрүүл мөнгө хуртэх боломж: 8.8 (56 дугаар байр)*
- *Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө: 7.1 (53 дугаар байр)*
- *Зээл, хөдөлмөрийн ба бизнесийн зохицуулалт: 6.3 (49 дүгээр байр)*

Энэ судалгааг хийснээр Монгол Улсын хувьд аль үзүүлэлт нь эдийн засгийн эрх чөлөөг хааж, боогдуулж байгааг олж харж, тэр чиглэлээр төрөөс ямар бодлого явуулах шаардлагатайг тодорхойлох зорилгоор дараахь зорилтуудыг биелүүлсэн:

- Эдийн засгийн эрх чөлөөгөөр Монгол Улс дэлхийн хамтын нөхөрлөлийн орнуудын хаана явааг үзүүлэлт бүрээр илэрхийлэх,
- Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтийг олон нийтэд ил тод мэдээлэх замаар хэлэлцүүлэг болгох,

- Төрийн байгууллагын шийдвэрийг эдийн засгийн эрх чөлөөг хангахад чиглүүлэхэд түлхэц болох.

Энэ судалгааны үр дүнд үндэслэн, Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөг цаашид тогтмол судлах, шинжлэх, судалгааны үндсэн дээр бодлогын зөвлөмж гаргах үүднээс 2006 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Форум, МУИС-ийн Эдийн Засгийн Сургуультай хамтран Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тайланг гаргахаар боллоо. Жил бүр тус Эдийн Засгийн эрх чөлөөний тоймд Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал, төрийн эдийн засгийн бодлого, эдийн засгийн эрх чөлөөг дүгнэн үнэлэх болно.

Тухайн жилийн Эдийн засгийн эрх чөлөөний тоймын гол сэдвийг тухайн үед Монгол Улсын эдийн засагт хамгийн их анхаарал татаж буй, эдийн засгийн өсөлтөд хамгийн их саад учруулж буй бэрхшээлүүдийг судалж дүгнэсний үндсэн дээр сонгох бөгөөд тайланд тухайн сэдвийн гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээ, дүгнэлт, бодлогын зөвлөмжийг оруулах юм.

Аливаа улсын эдийн засгийн хөгжил, өсөлтийг тайлбарладаг эдийн засгийн олон үзэл баримтлал, хандлага байдаг боловч дэлхий нийтэд сүүлийн жилүүдэд улс орнуудад гарч байгаа эдийн засгийн өсөлт, хөгжлийг шийдвэрлэх олон асуудалд хариулт өгөх чадвартай “эдийн засгийн институцийн онол” голлох байр суурийг эзэлж эхэлсэн юм. Үүнийг 1990 оноос хойш хийгдсэн онолын болон эмпирик судалгаанууд баталж байгаа юм.

Үүнийг харгалзан Нээлттэй Нийгэм Форум, МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль хамтран 2006 оны тоймын сэдвийг “Монгол Улсын институцийн хөгжил, түүний эдийн засгийн өсөлтөд үзүүлж байгаа нөлөө” гэж сонгосон юм.

Энэ сэдвийг сонгосон үндэслэл, судалгааг дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй танилцуулах бөгөөд энэ жилийн тайлангийн гол зорилго нь:

- Эдийн засгийн эрх чөлөөний ач холбогдлыг харуулах,
- Институци ба эдийн засгийн эрх чөлөөний хоорондох холбоосын концепцийн хүрээг боловсруулах, Монгол Улс болон бусад улсын практик жишээн дээр институцийн хөгжлийн ач холбогдлыг танилцуулах,
- Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөө, институцийн хөгжлийн өнөөгийн түвшинг тодорхойлох,
- Монгол Улсын институцийн судалгаа явуулж, түүний Монголын эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлж буй нөлөөг тодорхойлох,
- Институцийг цаашид хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг бууруулах, орлогын хуваарилалтыг оновчтой болгох талаар бодлогын зөвлөмжийг боловсруулахад оршиж байгаа юм.

Энэхүү судалгааг нэгдсэн онол, концепцийн үндэслэлтэй тайлангийн хэлбэрээр Монгол Улсын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагууд болон олон нийтэд толилуулах болно.

1.3 ЭНЭ ЖИЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТОЙМЫН ГОЛ АСУУДАЛ

Энэ жилийн тоймын гол асуудал нь Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй холбоотой юм. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2004 онд Азид хамгийн өндөр болох 10.6%-д хүрсэн, 2005 онд 6.2% байсан нь дэлхийн хэмжээнд ч өндөр үзүүлэлт. Гэтэл яагаад тус тоймд энэ асуудлыг авч үзэх болсон бэ? Энэ асуултын хариуг дараахь бүлгүүдэд дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Товчилж хэлбэл, бидний үзэж байгаагаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, хөгжлийг түргэтгэх гол арга зам нь институцийн хүрээг сайжруулах замаар хувийн хэвшил, бизнесийн бүтээлч үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж урамшуулах орчинг бий болгох, бодлогыг хэрэгжүүлэх явдал мөн. **Тиймээс энэ тоймд Монголын институцийн хөгжил бол Монгол Улсын цаашдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол чиглэл байх ёстой гэдгийг санал болгож байгаа юм.**

Институцийн хөгжил, түүний тогтолцоог боловсронгуй болгох ажлыг төрийн бодлогын анхаарлын төвд оруулснаар, улс орны хөгжил аливаа нэг салбар, дэлхийн үнийн өсөлтөөс хараат бус болох, эдийн засгийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглаж үр өгөөжийг өндөр байлгах нийгэм, эдийн засгийн тогтолцоог бий болгож хөгжүүлэх нь цаашдын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болно. Энэ нь зах зээлийн эдийн засгийн системийг өөрийг нь төгс төгөлдөржүүлэх, зах зээлийн шилжилтийг логик, уялдааны дараагийн шатанд гаргах, Монголын амьжиргааны түвшинг хөгжингүй орнуудынхад ойртуулахын тулд зайлшгүй хийгдэх ёстой эдийн засгийн шинэтгэлийн алхмууд гэж үзэж байна. Үүнийг амжилттай хэрэгжүүлэх нь зах зээлийн шилжилтийн эцсийн шат биш боловч Монголын эдийн засгийн өсөлтийг шинэ шатанд гаргахад нэн чухал алхам болно гэж итгэж байна.

Энэ нь өсөлтийн бусад хүчин зүйлс, тухайлбал уул уурхайн салбарын цаашдын хөгжил, дэлхийн үнийн өөрчлөлт гэсэн энэ тоймын санаа өнөөг хүртэл баримталсан эдийн засгийн өсөлтийг зэс, алтны үнийн өсөлт, экспортоор хангаж, уул уурхайн салбараас улс орны эдийн засгийг хэт хараат болгож буй эдийн засгийн бодлогоос ялгаатай юм.

Хэрэв Монголын институци амжилттай хөгжиж, ялангуяа эдийн засгийн эрх чөлөөг тууштай сайжруулах төрийн бодлогыг хэрэгжүүлбэл дэлхийн зэсийн үнийн өөрчлөлт зэргээс хамааралгүйгээр Монголын эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл болсон хувийн бизнесийн хэвшил эрчимтэй хөгжиж, эдийн засгийн өсөлтийн хурд нэмэгдэж, шинээр ажлын байр олноор бий болж, улмаар нийгэм эдийн засгийн олон асуудал амжилттай шийдэгдэх бололцоо байна гэж хэлж болно. Энэ нь хувийн хэвшлийн өсөлт бүх асуудлыг шийднэ гэсэн үг биш, харин түүнийг эрчимтэй хөгжүүлснээр Монголын өөрийн дотоодын нөөцийг бүрэн ашиглах боломж нэмэгдэнэ гэсэн үг.

Үүний зэрэгцээ хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааны энэхүү хүлээгдэж буй идэвхжилт ба түүнтэй холбоотой эдийн засгийн өсөлт нэмэгдэх явдал нь өөрөө институцийн хөгжлийн үр дүн мөн гэдэг нь хамгийн чухал зүйл боловч цорын ганц эерэг үр дүн биш харин цаашид эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийн институцийн системийн бэхжилт нь Монголын нийгмийг эрүүлжүүлэх, хуулийг дээдлэх ёсыг төлөвшүүлэх, шударга ёс, ил тод байдал нийгэмд зонхилох, ардчилсан төрийн ёс улам эргэлт буцалтгүй бэхжихийн үндэс болно.

2. Монголын эдийн засгийн эрх чөлөө, эдийн засгийн өсөлтийн судалгаа

2.1 МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэ бүлэг Монголын эдийн засгийн өсөлтийн байдал, өнөөгийн өсөлтийн бүтцийг авч үзэж, цаашид эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох судалгаа юм.

1999-2002 онд ган, зуд болж байсан, алт олборлолт 2004 онд эрс нэмэгдсэн, зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ тогтмол өсч байсан, боловсруулах салбарт нэхмэл, оёмол бүтээгдэхүүний хэмжээ өсч бууран тогтворгүй байгаа зэргээс хамаарч ДНБ-ий бүтэц өөрчлөгдөж байна.


2000 онд ХАА-н салбар ДНБ-ий 29.1 хувь, үйлдвэрлэлийн салбар 21.9 хувь, үйлчилгээний салбар 49.0 хувийг бүрдүүлж байсан бол 2005 оны ДНБ-ий 21.7 хувийг хөдөө аж ахуйн салбар, 30.2 хувийг үйлдвэрлэлийн салбар, 48.2 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 7.4 пунктээр буурч, уул уурхай, олборлох салбарын эзлэх хувь 9 пунктээр нэмэгдэж үндсэндээ эдгээр салбарын хооронд шилжилт явагдсан байна. Энэ хугацаанд боловсруулах үйлдвэрлэлийн

болон үйлчилгээний салбарын хувь хэмжээ төдийлөн өсөөгүй байна.

1999 оноос хойш Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт, уул уурхайн салбарын хөгжил, дэлхийн зах зээлд Монголын экспортын гол бараа болох зэс, алт, ноолуурын түүхий эдийн үнийн өсөлт, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт нь макро эдийн засгийн эерэг байдлыг бий болгосон. Зах зээлийн тогтолцоонд шилжиж эхэлснээс хойш гадаадын олон зуун компанийн Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт тэрбум гаруй ам долларт хүрээд байна. (Зураг 2.1.)

Статистикийн үзүүлэлтүүдийг харахад, эдийн засгийн өсөлт 2005 онд 6.2 хувьд хүрсэн. Өмнөх оны үзүүлэлтээс доогуур гарсан нь газар тариалангийн салбарт ургацын хэмжээ өмнөх оныхоос буурсан, нэхмэл, оёмол бүтээгдэхүүнийг АНУ, Европын холбооны зах зээлд нийлүүлж байсан хөнгөлөлтийн нөхцөл байхгүй болсон зэргээс шалтгаалсан. Тухайлбал 2004 оны эдийн засгийн өсөлтийн 3.55 пунктыг бүрдүүлж байсан хөдөө аж ахуйн салбар 2005 оны өсөлтийн 1.61 пункт, 4.36 пунктыг бүрдүүлж байсан уул, уурхайн салбар 2.16 пунктыг бүрдүүлж, боловсруулах салбарын

Зураг 2.1. Гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсад (жилийн хэмжээ, мянган ам. доллалаар)



үйлдвэрлэл эдийн засгийн бууралтын -1.25 пунктыг бий болгосон байна. Эдгээр нь эдийн засгийн өсөлтийн бууралтад нөлөөлсөн гол хүчин зүйлүүд юм.

1990-2006 онуудад Монгол Улсын эдийн засгийг нээлттэй болгох, хувийн секторыг хөгжүүлэх, төрийн оролцоог багасгах, зах зээлийн эдийн засагт тулгуурласан төрийн эдийн засгийн зохицуулалтыг бий болгох олон чухал алхам хийгдэж, сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт хурдасч, тухайлбал 2004 онд 10.6%-д хүрч, гадаад худалдааны баланс, улсын төсөв алдагдалгүй гарч, төгрөгийн ханш, инфляци тогтворжиж, макро түвшинд эдийн засаг үндсэндээ өсөлтийн замд орсон гэж болно. 2005 онд гадаад орчны сөрөг нөлөө байсан боловч макро эдийн засгийн байдал нь үргэлжлэн сайжирч байсан.


2005 онд тээвэр, холбооны салбар, мал аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Байгаль, цаг уурын нөхцөл сайн байсан, төмөр замын тээврээр дамжин өнгөрөх ачаа эргэлт харьцангуй нэмэгдсэн, үүрэн телефоны

салбарт гуравдагч оператор байгуулахаар төлөвлөж байсан зэрэг нь ч нөлөөлсөн. 2005 онд 9.3 сая төл бойжуулж, хүнсний хэрэглээнд 6.3 сая мал хэрэглэж, том малын зүй бус хорогдол 677 мянга байлаа. Оны эцэст малын тоо 30.4 саяд хүрч өмнөх оноос 8.5 хувь өслөө. 2005 онд мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.8 орчим хувиар өссөн. (Зураг 2.2.)

Ийнхүү сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн байдал тогтворжиж, эдийн засгийн өсөлт тогтмол эерэг гарч байгаа ч энэхүү өсөлт нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн олон асуудлыг шийдээгүй байна. Монголын эдийн засгийн өсөлт нийт эдийн засгийг хамарсан өсөлт болж чадахгүй байгаа юм. Эдийн засгийн өсөлтийг салбараар болон хэвшлээр авч үзэхэд энэхүү учир дутагдалтай байдал харагдаж байна. (Хүснэгт 2.1.)

Хүснэгт 2.1 -ээс харахад сүүлийн 8 жилд, 1997-2005 онд уул уурхай, тээвэр болон худалдаа, үйлчилгээний гэсэн 3 салбар л Монголын эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бий болгосон нь харагдаж байна.

Зураг 2.2. Макро эдийн засгийн өсөлт Монгол Улсад, ДНБ-ий хувиар, 1993-2005 (%)



Хүснэгт 2.1. 1997-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлтийг бий болгосон гол салбарууд (хамгийн өндөр өсөлттэй байсан салбаруудыг тодруулсан болно.)

Салбар	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	Дүн (1997- 2005)
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	1,89%	2,29%	1,58%	-5,51%	-5,39%	-2,65%	1,00%	3,55%	1,61%	-1,62%
Уул уурхай, олборлох үйлдвэр	0,59%	0,70%	0,27%	0,57%	1,10%	-0,62%	-0,23%	4,36%	2,16%	8,89%
Боловсруулах үйлдвэр	-0,89%	0,21%	-0,16%	-0,20%	1,95%	1,79%	0,27%	0,08%	-1,25%	1,81%
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0,01%	0,10%	0,19%	0,02%	0,08%	0,12%	0,04%	0,21%	0,13%	0,90%
Барилга	-0,07%	-0,02%	0,04%	-0,36%	0,21%	0,36%	1,03%	0,00%	0,29%	1,47%
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	2,85%	-0,65%	0,27%	5,40%	2,35%	3,55%	1,97%	1,67%	2,28%	19,69%
Зочид буудал, зоогийн газар	0,00%	0,01%	0,10%	0,18%	-0,09%	0,06%	0,01%	0,19%	0,06%	0,52%
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	0,43%	0,57%	0,54%	2,31%	1,64%	2,10%	1,64%	1,47%	1,35%	12,04%
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	-0,47%	-0,54%	0,63%	0,16%	0,56%	0,23%	0,78%	0,74%	0,62%	2,70%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	-0,02%	0,07%	-0,05%	0,13%	0,07%	0,26%	0,25%	0,24%	0,08%	1,03%
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	0,06%	0,05%	0,06%	0,13%	-0,26%	-0,02%	-0,11%	0,17%	0,13%	0,20%
Боловсролын салбарын үйл ажиллагаа	0,14%	0,18%	0,15%	0,12%	0,06%	0,22%	-0,20%	-0,30%	-0,18%	0,20%
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0,08%	0,03%	0,08%	0,00%	0,09%	0,05%	-0,04%	0,10%	0,05%	0,43%
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0,01%	0,01%	0,00%	0,17%	0,04%	0,22%	-0,01%	0,12%	0,02%	0,59%
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-0,61%	0,53%	-0,47%	-2,04%	-1,38%	-1,63%	-0,86%	-1,91%	-1,14%	-9,50%
	4,0%	3,5%	3,2%	1,1%	1,0%	4,0%	5,6%	10,7%	6,2%	39,33%

Эдийн засгийн өсөлт ийнхүү ерөнхий дүнгээрээ өндөр байгаа хэдий ч зарим салбар уналтад орж, цаашилбал эдийн засагт шинэ ажлын байр бий болохгүй, ядуурал буурч чадахгүй байна. Монгол Улсын нэг хүнд ноогдох албан ёсны дотоодын нийт

бүтээгдэхүүн нь 800\$⁴-аас дээш гарч чадахгүй, нийт 2.5 сая хүнээс 250 мянга нь ажилгүй байна. Сүүлийн 15 жилд орлогын тэгш бус хуваарилалт, ядуурал улам гүнзгийрч байна.

⁴ Уг үзүүлэлтийг нэрлэсэн дүнгээр авсан болно. Худалдан авах чадвараар үнэлсэн ДНБ-ий үзүүлэлтүүдийг Дэлхийн Банкны статистикаас авч болно.

Тэгэхээр Монгол Улс ойрын болон алс ирээдүйд ямар замаар, ямар үзэл баримтлалын дагуу хөгжих нь зүйтэй вэ гэсэн асуудлыг авч үзэх шаардлагатай юм.

2.2 ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛУУД

Эхлээд ерөнхий концепцийг авч үзье. Эдийн засгийн өсөлт гэдэг нь тухайн жилд аль нэг улс оронд үйлдвэрлэгдсэн эцсийн бүтээгдэхүүн, үйчилгээний дүн хэрхэн өссөнийг хувиар харуулдаг бөгөөд улс орнуудын эдийн засгийн төлөв байдал, түүний хүчин чадал, засгийн газрын эдийн засгийн бодлого хэр зөв явж байгааг илэрхийлдэг хамгийн түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт юм. Эдийн засгийн өсөлтөд эдийн засаг, байгалийн нөөц баялаг болон хүн амын, технологи бүтээмжийн, мэдлэгийн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Олон улсын жишгээр бол тухайн улсын бодит ДНБ-ий өсөлт болон нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлтөөр эдийн засгийн өсөлтийг ихэвчлэн тодорхойлдог.

Өнөөг хүртэл эдийн засгийн шинжлэх ухаанд эдийн засгийн өсөлтийн талаарх 4 ялгаатай онолын үзэл баримтлал бүрэлдэн тогтсон ба эдгээрийн аль алинд нь уг тоймын гол асуудал болох институцийн хүчин зүйлс чухал байр суурийг эзэлдэг.

- Р.Солоу (1956)-гийн ажилд үндэслэсэн **шинэ сонгодог онол**⁵. Уг онолоор эдийн засгийн өсөлт нь хөдөлмөр, капитал, газар зэрэг бүтээмжит хүчин зүйлсийн орц болон технологийн сайжруулалтын үр дүн гэж баталдаг. Энэ онолд биет болон хүмүүн капитал дахь хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл гэж үздэг ба хамгийн гол хүчин зүйл нь нэг ажилчинд ногдох капиталын хэмжээ буюу капитал зэвсэглэмж байдаг. Шинэ сонгодог

онолд хөдөлмөр, капитал болон бусад үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах зээл төгс өрсөлдөөнт гэж үзэж, хууль, засаглал, хувийн өмч, гэрээний биелэлтийн асуудлыг тусгайлан авч үздэггүй мэт харагдаж байгаа боловч үнэн хэрэг дээр эдийн засаг байгаа бүх нөөцөө бүрэн дүүрэн ашиглаж, аливаа шаардлагагүй зардал гаргахгүй гэдэг нь тухайн улс орны зах зээл төгс ажиллаж байна гэж таамагласантай ижил утгатай юм.

- Шинэ сонгодог өсөлтийн загварын альтернатив үзэл баримтлал нь **дотоод өсөлтийн онол** юм. Энэ онолд үндсэн хүчин зүйл нь технологийн дэвшил байдаг⁶. Технологийн дэвшлийг тайлбарладаг хамгийн гол ухагдахуун нь зах зээлийн хэмжээ байдаг. Зах зээлийн хэмжээ их байх тусам илүү үр ашигтай технологийг шинээр бий болгож, технологийн дэвшлийг хурдасгаж байдаг гэж үздэг.
- Дараачийн өсөлтийн хандлага нь 1990-ээд онуудад Ж.Сакс (Jeffrey Sachs) нарын гаргаж ирсэн **газарзүйн байршлын онол**. Уг онолын дагуу байгаль цаг уурын байдал, томоохон зах зээлүүдтэй ойр байх болон тэдэнтэй холбогдох нөхцөл нь эдийн засгийн өсөлтийн хамгийн гол, үндсэн тодорхойлогчид байдаг. Халуун орны уур амьсгал нь ажилчдын энергийн түвшинг бууруулж, гэмтэл бэртэл болон амь насанд аюултай байдлыг нэмэгдүүлж байдаг. Ингэснээр бизнесийн идэвхтэй үйл ажиллагаа буурч хөрөнгө оруулалт үр ашиггүй болж ирнэ. Эсрэгээр, хэрвээ томоохон зах зээлд ойр оршиж, далайн тээвэрлэлт хийх боломжтой бол тухайн газар нутагт бизнес эрхлэх нь ашигтай байна гэж уг онолд үздэг.

⁵ "A Contribution to the Theory of Economic Growth", 1956, *QJE*.

- Дөрөвдүгээрт, **институцийн хандлага:** ямар нэгэн улсад **институци** буюу аж ахуйн эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийн орчин зэрэг муу байвал хувийн хөрөнгө оруулалт, хувийн бизнесийн үйл ажиллагаа бэрхшээлтэй тулгарч, тухайн улсын эдийн засгийн өсөлт удааширна. Яваандаа энэ улс орны амьжиргааны түвшин бусад ижил улсынхаас хоцрох болно.

Эдийн засгийн өсөлтийн эдгээр тайлбар нь өөр хоорондоо логикийн хувьд нийцгүй ойлголтууд биш, тодорхой хэмжээгээр бие биендээ агуулагдсан байдаг. Дээрх онолуудаас институцийн онолд эдийн засгийн эрх чөлөө нь эдийн засгийн өсөлтийн хамгийн гол хүчин зүйл гэсэн үзэл баримтлал давамгайлж байна. Харин шинэ сонгодог, дотоод өсөлтийн болон газар зүйн байршлын онолуудад ихэвчлэн эдийн засгийн эрх чөлөөг анхнаас нь өндөр түвшинд байна гэж тооцсон нь түүний нөлөөг анхнаасаа хүлээн зөвшөөрсөн гэсэн үг.

2.3 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, БАЙГАЛИЙН БАЯЛАГ

Монголын эдийн засгийн өсөлт, хөгжлийн гол эх үүсвэр нь сүүлийн үед уул уурхайн салбар болоод байгаа юм. Энэ салбарын эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмрийн талаар дээрх бүлэгт дэлгэрэнгүй танилцуулсан билээ. Одоо асуудал бол байгалийн баялаг ихтэй байх нь эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулахад чухал уу, эсвэл эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлэх нь чухал уу гэдэгт анхаарлаа хандуулья.

Судалгаанаас үзэхэд, эдийн засгийн эрх чөлөө (институцийн хөгжил) нь байгалийн баялгаас илүү өндөр орлогод хүргэдэг нь тогтоогдсон. Жишээ нь, Венесуэл болон Хонг-Конг, бусад орны жишээг аваад үзье.

Жишээ 1. Венесуэл болон Хонг-Конгийн харьцуулалт⁶: Хонг-Конг ямар ч байгалийн нөөцгүй орон. Харин Венесуэл улс байгалийн хий, газрын тосны томоохон үйлдвэрлэгч юм. 1960 онд Венесуэлийн нэг хүнд ногдох дундаж орлого 6720\$, Хонг-Конгийнх 3249\$ байсан буюу энэ үед Венесуэлийн орлого Хонг-Конгийнхоос 2 дахин өндөр байжээ. Гэтэл 1975-1980 онууд болон сүүлийн жилүүдэд газрын тосны үнэ тасралтгүй өссөн боловч Венесуэлын орлого 2002 онд 5380\$ болсон ба Хонг-Конгийнхоос 5 дахин бага байсан байна. Энэ оны Хонг-Конгийн нэг хүнд ногдох дундаж орлого 26910\$ болсон байсан. Ийнхүү байгалийн баялаг Венесуэлийг баян орон болгож чадаагүй бөгөөд үүний гол шалтгаан нь Хонг-Конгийн эдийн засгийн эрх чөлөө өссөнд байсан. (1970 онд 8.4, 2001 онд 8.6) Харин Венесуэлийн эдийн засгийн эрх чөлөө улам муудаж, 1970 онд 7.0 байснаа 2001 онд 5.3 болсон байна.

Жишээ 2. Африкийн улсууд: Ботсвана улс 1970 онд Африк тивдээ дундаж орлоготой буюу 1856\$-аас бага орлоготой (1072\$) байсан байна. Гэтэл эдийн засгийн эрх чөлөөг тууштай хөгжүүлж, Япон болон Норвеги улсуудтай ижил түвшний эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтэд хүрсэн (дэлхийд 26) Ботсвана улсын дундаж орлого 2001 онд 7696\$ доллар болж, 7 дахин өссөн байхад Африкийн дундаж орлого нь дөнгөж 2309\$ буюу өнгөрсөн 30 жилд зөвхөн 450 доллараар л өссөн байна.

Жишээ 3. Мөн энд хоёр Солонгосын жишээг авч болно. 1948 онд Хойд Солонгос нь тус хойгийн үндсэн байгалийн баялгийн ордууд бүхий умард хэсэгт байгуулагдсан бөгөөд энэ үед хоёр Солонгосын дундаж орлого ижил түвшинд байсан. Харин 1995 онд Хойд Солонгосын дундаж орлого 950\$ болсон байхад, Өмнөд Солонгосын орлого 13000\$-т хүрсэн байсан.

⁶ Эх сурвалж: J. Gwartney, R. Lawson, NCPA Policy Report No. 268, July 2004, ISBN #1-56808-137-5, National Center for Policy Analysis

Дээрх жишээ болон судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж ирсэн улсууд байгалийн нөөц баялгаас үл хамааран эдийн засгийн эрх чөлөө нь доогуур байгаа улсуудтай харьцуулахад нийгэм эдийн засгийн хөгжлийн илүү өндөр түвшинд хүрч чадсан байна.

Иймээс Монголын хувьд байгалийн баялгийг ашигладаг салбартаа найдахгүйгээр нийгмийн сайн сайхан байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэх үр ашигтай аргуудын нэг нь эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж, түүнд чиглэгдсэн бодлого, зохицуулалт хийж болох юм гэж дүгнэж болно. Мөн энэхүү дүгнэлт нь эдийн засгийн эрх чөлөөний нэгэн ач холбогдлыг тодорхойлж байна. Тэгвэл Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөө өнөөдөр ямар түвшинд байна вэ?

2.4 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭМЖИХ

Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний өнөөгийн байдал, түвшинг тодорхойлохын өмнө эдийн засгийн эрх чөлөөг хэрхэн хэмждэгийг авч үзье. Эдийн засгийн эрх чөлөөг 4 үндсэн үзүүлэлтээр хэмждэг:

- Эдийн засгийн агентын (хувь хүн, аж ахуйн нэгж) сонголтын эрх чөлөө (их байх тусмаа сайн)
- Өмчийн эрх нь баталгаажсан эсэх, бизнесийн аливаа маргааныг өгөөжтэй шийдвэрлэж чадах хууль, эрх зүйн орчин бүрэлдсэн эсэх
- Эдийн засаг дахь засгийн газар, төрийн оролцооны хэмжээ (бага байх тусмаа сайн)
- Эдийн засгийн харилцаан дахь төрийн өмчийн хувь (бага байх тусмаа сайн).⁷

⁷ How to track economic freedom, Business Standard | November 14, 2005

Эдийн засгийн эрх чөлөөний концепцийн үзэл баримтлалыг Адам Смит (1776), Фридрих Хайек (1944) зэрэг алдартай эдийн засагчид тодорхойлсон бөгөөд түүний хэмжил зүйн асуудлыг 1980 оноос эхлэн олон судлаач боловсруулж эхэлсэн. Фридом Хаус байгууллагын эдийн засагч Гастиль⁸ анх 1982 онд улс төрийн эрх чөлөөний индекст эдийн засгийн эрх чөлөөгөөр улс орнуудыг жагсаах зарчмыг нэмж оруулсан⁹. Өнөөгийн нөхцөлд хэд хэдэн байгууллага эдийн засгийн эрх чөлөөний индексийг тооцдог боловч Фрейзер Институтын Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс, Херитэж Сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индексүүд зонхилох судалгаа болж хөгжсөн байна.

2.4.1 Фрейзер Институтын Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс

1986 онд Фрейзер Институтыг үндэслэн байгуулагч, Канадын Вестерн Онтарио Их Сургуулийн эдийн засагч Майкл Уолкер, Нобелийн шагналт эдийн засагч Милтон Фридман нар эдийн засгийн эрх чөлөөний хэмжилтийн талаар хэд хэдэн хурал зохион байгуулсан ба тэдэнтэй хамт Нобелийн шагналт эдийн засагч Гэри Беккер болон Дуглас Норт нар хамтран ажилласан. 1996 оноос хойш Фрейзер Институт Дэлхийн Эдийн засгийн эрх чөлөөний индексийг тооцож эхэлсэн ба зохиогчид нь АНУ-ын Флоридагийн Улсын Их сургуулийн профессор Жеймс Гвартней, Капитал Их Сургуулийн профессор Роберт Лоусон нар юм.

Фрейзер Институтын аргачлалаар эдийн засгийн эрх чөлөөг өнөөгийн байдлаар

⁸ R.D. Gastil and followers. Freedom in the world. Freedom House, New York, 1972-2002.

⁹ Economic Freedom and Political Freedom, Wenbo Wu, National University of Singapore, Otto A. Davis, William W. Cooper University Professor of Economics and Public Policy, Carnegie Mellon University, Encyclopedia of Public Choice

5 бүлэг, 21 үндсэн үзүүлэлт, 38 дэд үзүүлэлт бүхий индексээр тооцдог. Эдгээр бүлэг нь:

- Засгийн газрын хэмжээ: Зарлага, татвар, үйлдвэрлэл /Size of Government: Expenditures, Taxes, and Enterprises/
- Хуулийн бүтэц ба өмчийн эрхийн хамгаалалт /Legal Structure and security of Property Rights /
- Эрүүл мөнгө хүртэх боломж /Access to Sound Money/
- Гадаад худалдааны эрх чөлөө /Freedom to Trade Internationally/
- Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт /Regulation of Credit, Labor, Business/

Фрейзер Институтын эдгээр үзүүлэлтийн тооцоо нь хоёрдогч эх сурвалжийн мэдээлэлд, тухайлбал, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Эдийн Засгийн Форумаас гаргадаг статистикт суурилдаг. Фрейзер Институтын судалгаанд 1980 оноос хойш 100 гаруй орны мэдээлэл орсон ба өнөөгийн байдлаар 123 орон хамрагддаг. Тус индексийн судалгаанд 60 гаруй орны судалгааны байгууллагууд оролцон, дэлхийн эдийн засгийн байгууллагуудаас гаргадаг тоон болон чанарын үзүүлэлтүүдийг ашиглан нэгдсэн аргачлалаар индексийг тооцдог.

Фрейзер Институт эдийн засгийн эрх чөлөөний индексийг:

- 1975-1995 оны Дэлхийн Эдийн засгийн эрх чөлөөний тайлан,
- 1997 оны жилийн Дэлхийн Эдийн засгийн эрх чөлөөний тайлан,
- 1998-1999 оны Дэлхийн Эдийн засгийн эрх чөлөөний тайлан,
- 2000 оны Дэлхийн Эдийн засгийн эрх чөлөөний тайлан: Жилийн тойм

нэртэйгээр хэвлэж байсан бол 2000 оноос хойш жил бүрийн тайланг “Дэлхийн Эдийн

Засгийн эрх чөлөөний тайлан: Жилийн тойм” нэртэйгээр хэвлэж байна.

Анхны тайлангууд 7 бүлгийн үзүүлэлттэй байсан боловч сүүлийн тайлангуудад альтернатив мөнгөн тэмдэгтийг ашиглах эрх чөлөө, эдийн засгийн бүтэц бүлгүүдийг устгаж, Бизнес, Хөдөлмөр, Банкны зээлийн зохицуулалтын эрх чөлөө гэсэн шинэ бүлгийг бий болгон бүлгийн тоог 2002 оноос 5 болгон тогтоосон байна.

Аргачлалын хувьд үзүүлэлт бүрийг ижил жинтэй авсан ба ерөнхий индексийг ердийн арифметик дунджаар тооцох болсон. Фрейзер Институт үзүүлэлтүүдийг 1-ээс 10 хүртэлх тоогоор хэмждэг. Гол зорилго нь судлагдаж буй салбарт эдийн засгийн эрх чөлөөг тоон үзүүлэлтээр харуулахад оршдог ба индексийн утга өндөр байх тусам тус салбар илүү эрх чөлөөтэй байна гэж тооцогдоно.

Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүдийг тогтоохдоо дараахь томъёог ашигладаг. Үүнд:

$$i_F = (V_{\max} - V_i) / (V_{\max} - V_{\min}) * 10$$

Үүнд:

V_i - тухайн улсын үзүүлэлт

V_{\max} - Суурь он болох 1990 оны улс орнуудын

хамгийн их утга

V_{\min} - Суурь он болох 1990 оны улс орнуудын хамгийн бага утга

2.4.2 Херитэж Сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекс

Улс орнуудын эдийн засгийн чөлөөт байдлыг хэмжиж, тайлан гаргадаг нэр бүхий өөр нэг томоохон байгууллага нь Херитэж Сан (The Heritage Foundation) юм. Уг сан нь Уолл Стрит Журналтай (The Wall Street Journal) хамтран 1995 оноос дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг судлан тогтоож, жил бүр тайлан хэвлүүлж байна.

Херитэж Сан/Уолл Стрит Журналаас гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн тайланг гаргагчид анх Фрейзер Институтын эдийн засагчидтай хамтран ажилладаг байсан бөгөөд 1995 оноос бие даан өөрсдийн судалгааг гаргах болсон юм. Анхны тайланг Жонсон, Скалли нар бэлтгэсэн¹⁰. Өнөөдөр зорилго нь өргөжин дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг системтэй, эмпирик судалгаагаар хэмжих хэмжилтийг хөгжүүлэх явдал болсон байна.

Уг индекс нь зөвхөн өгөгдлийн олонлог дээр үндэслэсэн эмпирик судалгаанаас илүү эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлүүдийн онолын шинжилгээ байдаг. Индексийн тайлбар нь тухайн улсын эдийн засгийн эрх чөлөө хэдий чинээ их байна урт хугацааны эдийн засгийн өсөлт нь өндөр байна гэж үздэг. Эдийн засгийн эрх чөлөө өндөр байх тусам хангалуун байдал нэмэгдэж байдаг, даяаршиж байгаа өнөө үед эдийн засгийн эрх чөлөө нь хөгжилд хүрэх, амжилтаа тогтвортой барихад хамгийн чухал үзүүлэлт мөн.

Херитэж Сангийн индекс нь улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг өргөн хүрээтэй хамарсан нийт 10 бүлэг, 50 бие даасан хувьсагчаар судалж, хэмжин тогтоодог¹¹. Үүнд:

- Худалдааны бодлого (Trade policy)
- Засгийн газрын санхүүгийн дарамт (Fiscal burden of government)
- Эдийн засаг дахь засгийн газрын оролцоо (Government intervention in the economy)
- Мөнгөний бодлого (Monetary policy)

- Капиталын урсгал ба гадаадын хөрөнгө оруулалт (Capital flows and foreign investment)
- Банк, санхүү (Banking and finance)
- Цалин ба үнэ (Wages and prices)
- Өмчийн эрх (Property rights)
- Зохицуулалт (Regulation)
- Албан бус зах зээлийн үйл ажиллагаа (Informal market activity)

Тус индекст орсон 10 хүчин зүйл нь эдийн засгийн эрх чөлөөнд ижил нөлөө, ач холбогдолтой ба нөгөө талаас индекс нь хүчин зүйл тус бүрийн нөлөөг хэмжих зориулалттай бус нийт эдийн засгийн төлөв байдлыг илэрхийлэх зорилготой учраас ижил жинтэй байдаг.

Тухайн улсын эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлогч үндсэн 10 хүчин зүйл бүр 1-5 гэсэн түвшнээр үнэлэгдэнэ. “1” гэсэн үнэлгээ нь эдийн засгийн орчин буюу бодлогын цогц нь эдийн засгийн эрх чөлөөнд хамгийн сайнаар нөлөөлж байгаа, түлхэц болж байгааг, харин “5” гэсэн үнэлгээ нь эсрэг байдлыг тэмдэглэнэ. Үүнээс гадна хүчин зүйл тус бүрийн үнэлгээг “илүү сайн” (эрх чөлөөний хүчин зүйл сайжирсан), “муу” (эрх чөлөөний хүчин зүйл муудсан), “тогтвортой” (эрх чөлөөний хүчин зүйл өөрчлөгдөөгүй) гэж тодорхойлж болно.

Эцэст нь 10 хүчин зүйлсийн үнэлгээний энгийн дунжийг тодорхойлсноор тухайн улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс тодорхойлогдоно. Гарч ирсэн индексээр нь улс орнуудыг дараахь 4 ангилалд хувааж болдог.

- Чөлөөтэй – нийт дундаж оноо нь 1.99 болон үүнээс бага улс орнууд
- Бараг чөлөөтэй – нийт дундаж оноо нь 2.00-2.99 улс орнууд
- Бараг чөлөөтэй бус – нийт дундаж оноо нь 3.00-3.99 улс орнууд

¹⁰ B.T. Johnson and T.P. Sheehy. The index of economic freedom. The Heritage Foundation, Washington, DC, 1995.

¹¹ Зарим судлаачдын үздэгээр, Фрейзерийн индекс илүү ил тод, тоо статистикийг баримтласан байдаг ба Херитэжийн индексийн зарим үзүүлэлт нь давхардсан байдаг гэж шүүмжлэлтэй ханддаг. ECONOMIC FREEDOM INDICES: THEIR USE AS TOOLS FOR MONITORING AND EVALUATION by John T. Cummings, SCS/SAE, USAID/Cairo, SCS Working Paper Number 00/01, April 2000

- Боогдмол (repressed) – нийт дундаж оноо нь 4.00 болон түүнээс дээш улс орнууд

Зарчмын хувьд Фрейзер Институтын Дэлхийн Эдийн Засгийн эрх чөлөөний индекс болон Херитэж Сангийн эдийн засгийн эрх чөлөөний индексүүдийн аль аль нь эдийн засгийн эрх чөлөөг ижил төстэй аргачлалаар хэмждэг ба гол ялгаа нь хамрагдсан улсын тоо, зарим үзүүлэлтийн сонголт, бүлэглэлд байдаг. Иймээс эдгээр индексийг судлахдаа гол нь индексийн абсолют хэмжээнд анхаарахаас илүү бусад оронтой харьцуулахад өөрийн орны байдал, жагсаалтанд эзэлж байгаа байр болон энэ үед эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг тоон мэдээлэл, статистикийн үзүүлэлтээр харах боломжтой оршиж байгаа юм.

2.4.3 Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний байдал: Дэлхийн Эдийн Засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүд

2005 онд Нээлттэй Нийгэм Форум Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөг төрийн оролцоо, эрүүл мөнгө хүртэх боломж, олон улсын худалдаа болон банкны зээлийн, бизнесийн болон хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын хүрээнд хэмжиж, дүнг олон нийтэд танилцуулсан билээ. Монгол Улсад анх удаа хийгдсэн энэ судалгаа ихээхэн ач холбогдолтой болсон бөгөөд эдийн засгийн эрх чөлөө ба институцийн хөгжлийн асуудлыг олон нийтийн анхаарлын төвд оруулж хэлэлцүүлсэн.

Нээлтэй Нийгэм Форумас анх удаа хийсэн энэхүү ажлыг эдийн засгийн эрх чөлөөний зэрэглэлийг тодорхойлох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Фрейзер Институтын аргачлалаар 5 үзүүлэлтээс 4-ийг ашиглаж 1990 оноос хойших бэлэн байгаа өгөгдөлд тулгуурлан хийсэн юм. Нээлттэй Нийгэм Форумын санаачлагаар

индексийн тооцоог бие даасан судалгааны багууд хийсэн билээ. Эдгээр судалгааны үр дүнг буюу Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийг Хүснэгт 2.2. байдлаар хүснэгтлэн харуулъя.

Тус судалгааны дүнг товч танилцуулахад 1995 оноос 2006 оны хооронд Монголын эдийн засгийн эрх чөлөөний индекс 6.3-аас 7.0 болж өссөн байна. Үүний дотор төрийн байгууллагын хэмжээ гэсэн үзүүлэлт 2000 онд 5.7 байснаас 6.8 болж, мөнгөний хүрээн дэх эдийн засгийн эрх чөлөө мөн үед 7.3-аас 8.8, банкны зээлийн хүрээнд 1995-2000 онд 5.5-аас 6.9 болж тус тус сайжирчээ. Үүний цаана бодит өөрчлөлтүүд, ахиц дэвшил байгаа юм.

Монгол Улс Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк зэрэг байгууллагатай хамтран макро эдийн засгийн тогтворжилт, хатуу мөнгөний бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ. Өнөөдрийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүд нь үндсэндээ эдгээр тогтворжуулах зорилгод хүрсэн гэдгийг нотолж байна.

Гэвч бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа зүйл нь мөнгө санхүүгийн хүрээн дэх дэвшил 1995 оноос хойш нилээд ахицтай байхад, олон улсын худалдаа, зах зээлийн зохицуулалтын хүрээнд (банкны зээл, хөдөлмөр, бизнес) байдал сайжраагүй буюу үр дүн удаан гарч байна. **Өөрөөр хэлбэл зах зээлд шилжиж эхэлснээс хойш макро эдийн засгийн хүрээнд эдийн засгийн эрх чөлөө сайжирсан байхад, компани, хувь хүмүүсийн хүрээнд буюу бизнест шууд нөлөөлдөг салбарууд дахь төрийн зохицуулалтад төдийлөн ахиц гарахгүй байна.**

Макро эдийн засгийн хүрээнд хийгдсэн шиг шилжилтийн болон тогтворжилтын нэгдсэн, цэгцтэй бодлого Монголын зах зээлийн журам, зохицуулалтын салбарт явагдаагүй. Үүнээс болж бизнес, хөдөлмөр, зээлийн зах зээлүүдийн эдийн засгийн

Хүснэгт 2.2. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийн нэгдсэн дүн

Он	1995	2000	2001	2002	2003	2004
1. Бүлгийн нэгдсэн индекс – Төрийн байгууллагын хэмжээ	5,7	6,4	6,6	6,4	6,8	6,7
А. Улсын байгууллагын хэрэглээ	6.8	6.0	5.9	6.2	6.1	5.7
В. Татаас, урсгал шилжүүлэг	10.0	7.4	7.4	7.3	7.4	7.6
С. Улсын үйлдвэр ба хөрөнгө оруулалт	2.0	6.0	7.0	6.0	6.0	7.0
D. Татварын дээд хэмжээ	2.5	4.5	4.5	4.5	4.5	6.5
2. Бүлгийн нэгдсэн индекс - Эрүүл мөнгө хүртэх боломж		7,3	7,7	8,4	8,7	8,8
А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ний жилийн дундаж бодит өсөлт		5	6,3	6,5	6,5	8
В. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт		5,8	5,9	7,5	9,3	9,2
С. Өнөөгийн инфляцийн түвшин	0	8,4	8,4	9,7	9,1	7,8
D. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх		10	10	10	10	10
3. Бүлгийн нэгдсэн индекс - Олон улсын худалдааны эрх чөлөө	6,9	7	6,6	7	7	6,97
А. Олон Улсын худалдааны татвар	7.8	7.3	6.1	6.6	6.9	7.1
В. Худалдааны саад хоригийн зохицуулалт	-	-	-	-	-	5.45
С. Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний харьцаа	-	7.8	7.4	7.5	7.3	7.3
D. Валютын хар захын ба албан ханшийн хоорондын зөрүү	9.9	10	10	10	10	9.9
E. Олон Улсын хөрөнгийн зах зээлийн хяналт	3	3	3	3.8	3.8	5.08
4. Банкны зээл, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн зохицуулалтын салбарын эдийн засгийн эрх чөлөөний Монгол Улсын ерөнхий үзүүлэлт		5,5	6,26	6,16	6,76	5,8
А. Бүлгийн нэгдсэн индекс-Зээлийн зах зээлийн зохицуулалт		5,5	6,26	6,16	6,76	6,9
В Хөдөлмөрийн зах зээл						5.0
С Бизнесийн зохицуулалт						5.6
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	6,30	6,55	6,79	6,99	7,32	7.0

эрх чөлөөний үзүүлэлтүүд макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс нилээд хоцорч зохицуулалтын хүрээнд эдийн засгийн хөгжил, шинэчлэл удааширж байгааг харуулж байна.

Зарим үзүүлэлт, тухайлбал бизнес дэх төрийн зохицуулалтын өнөөгийн байдал түгшүүртэй байна гэж дүгнэхээр гарчээ. Нэмэлт төлбөр, авилга, хахууль Монголын бизнесийн өсөлтийг ихээхэн хязгаарлаж,

маш их илүү зардал, алдагдлын эх үүсвэр болж байна.

2005 онд хийсэн энэ томоохон судалгааны хамгийн чухал үр дүн нь дараахь дүгнэлт болсон: “зах зээлийн зохицуулалт, түүний дотор бизнесийн зохицуулалтад онцгой анхаарч, энэ салбарын эдийн засгийн эрх чөлөөг дорвитой хөгжүүлэх цаг хугацаа болсон байна, энэ чиглэлийн бодлого боловсруулалт Монголын макро эдийн

Хүснэгт 2.3. «Засгийн газрын хэмжээ: Зарлага, татвар, үйлдвэрлэл» бүлгийн индекс

Он	1995	2000	2001	2002	2003	2004
А. Улсын байгууллагын хэрэглээ	6.8	6.0	5.9	6.2	6.1	5.7
В. Татаас, урсгал шилжүүлэг	10.0	7.4	7.4	7.3	7.4	7.6
С. Улсын үйлдвэр ба хөрөнгө оруулалт	2.0	6.0	7.0	6.0	6.0	7.0
Д. Татварын дээд хэмжээ	2.5	4.5	4.5	4.5	4.5	6.5
Бүлгийн нэгдсэн индекс	5.3	6.0	6.2	6.0	6.0	6.7

Хүснэгт 2.4. «Эрүүл мөнгө хүртэх боломж» бүлгийн индекс

Он	2000	2001	2002	2003	2004
А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ний жилийн дундаж бодит өсөлт	5.0	6.3	6.5	6.5	8.0
В. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт	5.8	5.9	7.5	9.3	9.2
С. Өнөөгийн инфляцийн түвшин	8.4	8.4	9.7	9.1	7.8
Д. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх	10.0	10.0	10.0	10.0	10.0
Бүлгийн нэгдсэн индекс	7.3	7.7	8.4	8.7	8.8

засгийн бодлогоос ихээхэн хоцрогдолтой явж байна.”

Фрейзер Институтын аргачлалаар хийсэн дээрх судалгааны үр дүнг бүлгээр авч үзье.

Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын “Засгийн газрын хэмжээ: Зарлага, татвар, үйлдвэрлэл” бүлгийн индекс (Хүснэгт 2.3.)

Нэгдүгээр бүлэг үзүүлэлтийн хувьд 2004 онд буурсан бүлэг дотроо хамгийн бага үзүүлэлттэй байна. Энэ нь Монгол улсын төр хэтэрхий том, үр ашиг багатай байдгийг харуулж байна. Ийм учраас цаашдаа энэ тал дээр анхаарч, төрийн бодлого үйл ажиллагааг үүнд чиглүүлж чадвал эдийн засгийн эрх чөлөө нэмэгдэх боломжтой юм.

Хоёрдугаар бүлэг: Монгол улсын “Эрүүл мөнгө хүртэх боломж” бүлгийн индекс. Тооцсон индексээс харахад “эрүүл мөнгө

хүртэх боломж” бүлгийн индекс хамгийн өндөр байгаа нь манай улсын хувьд энэ салбарт төр, засгийн шууд оролцоо зохицуулалт хамгийн бага байдгийг харуулж байна. Энэ нь манай улсын мөнгө санхүүгийн салбар зах зээлийн харилцаанд шилжиж, харьцангуй бие даасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэгтэй холбоотой болов уу. Нөгөө талаас сүүлийн жилүүдэд эдийн засаг дахь мөнгөний харилцаа тогтворжиж, банк санхүүгийн салбар амжилттай хөгжиж байна. Динамикаас нь харахад уг бүлгийн эрх чөлөөний индекс сүүлийн жилүүдэд өссөн дүнтэй байна. (Хүснэгт 2.4.)

Гуравдугаар бүлэг: Монгол улсын “Гадаад худалдааны эрх чөлөө” бүлгийн индекс.

Энэ салбарын хувьд эдийн засаг нь эрх чөлөө хангагдаж чадаагүй гэж хэлж

болно. Энэ бүлэг дотроо хамгийн бага нь худалдааны саад хоригийн зохицуулалт, хөрөнгийн зах зээлийн хяналтын индексүүд байна. Харин энэ бүлэг дотор валютын хар захын болон албан ханшны зөрүүний индекс нь 9.9 гарсан байгаа нь мөн л эдийн засгийн мөнгөний тал, мөнгөний бодлогыг эрхэлдэг байгууллагуудын амжилттай холбоотой болов уу. (Хүснэгт 2.5.)

Дөрөвдүгээр бүлэг: Монгол улсын “Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт” бүлгийн индекс. Одоогийн байдлаар тооцсон бүлгүүдийн индексээс харахад хамгийн бага оноотой нь тавдугаар бүлэг буюу “зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт” байна. Энэ нь манай улсын хувьд зээлийн зах зээл, хөдөлмөрийн зах зээл, бизнес дэх төрийн оролцоо, зохицуулалт ихтэй байдаг,

тэр хэмжээгээр эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагдаж байдгийг харуулж байна. (Хүснэгт 2.6.)

Судалгаанаас гарсан дээрх үр дүнг нэгтгэн Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөг дараахь байдлаар тоймлон харуулж болох юм:

Макро эдийн засаг, мөнгө, санхүүгийн салбарт Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөө харьцангуй сайн байгаа боловч аж ахуй эрхлэлт, хувь хүмүүсийн амьдралд шууд нөлөөлж байгаа бизнес, хөдөлмөрийн зах зээл, зээлийн хүүгийн хувьд эдийн засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүд хангалтгүй гарсан байна. Өөрөөр хэлбэл хувь хүний арилжаа солилцоо хийх, ажил хөдөлмөр, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэн өмч хөрөнгө хуримтлуулах боломжуудыг төр

Хүснэгт 2.5. Монгол улсын «Гадаад худалдааны эрх чөлөө» бүлгийн индекс

Он	1995	2000	2001	2002	2003	2004
А. Олон Улсын худалдааны татвар	7.8	7.3	6.1	6.6	6.9	7.1
В. Худалдааны саад хоригийн зохицуулалт	-	-	-	-	-	5.45
С. Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний харьцаа	-	7.8	7.4	7.5	7.3	7.3
Д. Валютын хар захын ба албан ханшны зөрүү	9.9	10	10	10	10	9.9
Е. Олон Улсын хөрөнгийн зах зээлийн хяналт	3	3	3	3.8	3.8	5.08
Бүлгийн нэгдсэн индекс	6.9	7	6.6	7	7	6.97

Хүснэгт 2.6. Монгол улсын «Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт» бүлгийн индекс

Он	2000	2001	2002	2003	2004
А. Зээлийн зах зээлийн зохицуулалт	5.5	6.26	6.16	6.76	6.9
В. Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт	-	-	-	-	5.0
С. Бизнесийн зохицуулалт	-	-	-	-	5.6
Бүлгийн нэгдсэн индекс	5.5	6.26	6.16	6.76	5.8

хязгаарлаж, эдийн засгийн эрх чөлөөний үндсэн агуулгыг алдагдуулж байна гэсэн үг. Ийм улс орон, эдийн засаг хөгждөггүй, хөгжсөн түүх байдаггүй ба эдийн засгийн өсөлтийн хурд өндөр байгаа ч **улс эрчимтэй хөгжихгүй байгаагийн гол шалтгаан нь энэ байж болох юм.**

2.4.4 Херитэж Сангийн «Эдийн засгийн чөлөөт байдлын индекс»: Монгол Улсын байдал, 2004-2005

Манай улс энэ индексийн анхны тайлангаас эхлэн хамрагдаж ирсэн нь, эдийн засгийн эрх чөлөөт байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг энэ байгууллагын аргачлалаар мэдэх боломжийг олгож байдаг. Сүүлийн жилүүдийн үр дүнгээс харахад 2005 оны тайланд дэлхийн 161 орон хамрагдсанаас, манай улсын нэгдсэн индекс 2.75, жагсаалтад 50-р байранд буюу “Бараг чөлөөтэй” гэсэн ангилалд багтсан бол 2006 оны тайланд мөн л дэлхийн 161 орон хамрагдсанаас манай улсын нэгдсэн индекс 2.83, 10 орноор ухарч 60-р байранд орсон ч “Бараг чөлөөтэй” гэсэн ангилалд багтсан байна. Гэвч сүүлийн нэг жилд манай улсын эдийн засгийн эрх чөлөө багасчээ гэсэн дүгнэлт гарсан.


Засгийн газар хувь хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаанд ямар нэгэн хязгаарлалт хийвэл тэдгээрийн сайн сайхан байдал буурдаг. Учир нь албадлага нь хүмүүс чөлөөтэй байхдаа хийх байсан сонголтуудад сөргөөр нөлөөлдөг. Энэ үед эдийн засгийн эрх чөлөө буурч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө.

1995-2006 онд, Херитэж Сангийн аргачлалаарх манай улсын эдийн засгийн эрх чөлөөний нэгдсэн индексийн динамик дараахь байдалтай байна. (Зураг 2.3.)


Эдийн засгийн эрх чөлөөний индексийн тухайн жилийн тайлан нь өмнөх оныхоо тоон мэдээлэл, судалгаа шинжилгээ, төлөв байдал дээр үндэслэдэг учраас дээрх тоон үр дүнг нэг он ухраан үзэх ёстой. Өөрөөр хэлбэл 2006 оны тайлангийн үр дүн нь 2005 онд манай улсад явагдсан эдийн засгийн үйл ажиллагааны үр дүн, энэ оны төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлт юм. Энэ утгаар дээрх үр дүнг харвал, 1999 оноос эхлэн манай улсын эдийн засгийн эрх чөлөөний байдал тасралтгүй сайжирч байснаа 2005 онд эргээд муудсан байна.

Нөгөө талаас өөрчлөлтийн түвшинг аваад үзвэл Зураг 2.4. байдалтай байна.

Зураг 2.3. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс



Зураг 2.4.Херитэж сангийн индексийн үзүүлэлтийн өөрчлөлт, 1997-2006



1999 оноос эхлэн индексийн утга буурч, эдийн засгийн эрх чөлөөний байдал сайжирсан гэж дүгнэж болох ч бууралтын түвшин нь жил бүр багасан, тогтворгүй, буцаад өсөх хандлагатай байгаа нь нэг талаар манай улсын эдийн засгийн эрх чөлөөг хангах бодлого тогтворгүй, тохиолдлын шинжтэй байгааг, нэгдсэн индексийн утга нь индексийн дундаж утга 2.5-тай тэнцүү байна. Үүний утга нь эдийн засгийн эрх чөлөөнд мэдэгдэхүйц ахиц, дэвшил гараагүй, эдийн засгийн эрх чөлөө хангагдаж чадаагүй байгааг илтгэнэ.

Дэд бүлгүүдийн индексийн төлөв байдлаар яг чухам аль үзүүлэлт нь сайжирсан, эсвэл муудсан, цаашлаад нийт индексэд хэрхэн нөлөөлж байгаа нь илүү тодорхой харагдана. Үүний тулд Херитэж Сангийн 2005, 2006 оны эдийн засгийн эрх чөлөөний тайлангийн үр дүнгүүд буюу 2004, 2005 оны манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүдийн индексийн утгуудыг Хүснэгт 2.7. -оор харуулъя.

Эндээс харахад, 2004 оны байдлаар 10 бүлэг үзүүлэлтийн 6 бүлгийнх нь индексийн утга дундаж утга болох 2.5-аас дээш, мөн бүгд өмнөх оныхоос сайжирсан эсвэл тогтвортой байсан бол 2005 онд 4 бүлгийн индексийн

утга дундаж утга болох 2.5-аас дээш утга авч, 3 бүлгийн индекс өмнөх оныхоос муудсан байна.

Эдгээрээс “худалдааны бодлого”-ын индекс муудсан боловч дунджаас хэтрээгүй, “засгийн газрын санхүүгийн дарамт”-ын индекс сайжирч байгаа боловч дунджаас дээгүүр хэвээрээ байгаа нь асуудлын хувьд хөнгөвтөр байж болох юм. Гэтэл “өмчийн эрх” болон “албан бус секторын үйл ажиллагаа”-ны гэсэн хоёр индексийн хувьд анхнаасаа дунджаас дээгүүр буюу муу байснаа улам муудаж индексийн утга нэмэгдсэн, “зохицуулалт”-ын индекс хэвээрээ өндөр байгаа зэрэг нь анхаарал татах асуудал болж байна.

Дунджаас дээгүүр байгаа болон муудсан үзүүлэлт тус бүрийн шалтгаан, нөхцлийг дараахь байдлаар тодорхойлжээ.

Худалдааны бодлого: Дундаж тарифийн хэмжээ 4% хэвээрээ байгаа боловч хамгийн гол нь олон талаас нь авч үзэхэд “гааль нь хамгийн их хээл хахууль, авилгад орсон төрийн байгууллага” болсон учраас тарифийн бус саад хориг нэмэгдсэн гэж үзэн индексийн утгыг нэмэгдүүлсэн.

Засгийн газрын санхүүгийн дарамт: Энэ үзүүлэлт нь Орлогын татвар, Компаний

Хүснэгт 2.7. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийн харьцуулалт

Бүлгүүд	2004		2005	
	Оноо	Тайлбар	Оноо	Тайлбар
Худалдааны бодлого	1	Сайжирсан. (Маш бага хамгаалалттай)	2.5	Муудсан. (Дунд зэргийн хамгаалалттай)
Засгийн газрын санхүүгийн дарамт	3.5	Сайжирсан. (Засгийн газрын зардал өндөр)	3.3	Сайжирсан. (Засгийн газрын зардал дунд зэрэг)
Эдийн засаг дах засгийн газрын оролцоо	2.5	Тогтвортой. (Дундаж зэрэг)	2.5	Тогтвортой. (Дунд зэрэг)
Мөнгөний бодлого	2	Тогтвортой. (Инфляцийн түвшин бага)	2	Тогтвортой. (Инфляцийн түвшин бага)
Капиталын урсгал ба гадаадын хөрөнгө оруулалт	3	Тогтвортой. (Дунд зэргийн саад хоригтой)	2	Сайжирсан. (Бага зэргийн саад хоригтой)
Банк, санхүү	3	Тогтвортой. (Дунд зэргийн хязгаарлалттай)	2	Сайжирсан. (Бага зэргийн хязгаарлалттай)
Цалин ба үнэ	2	Тогтвортой. (Бага зэргийн интервенцтэй)	2	Тогтвортой. (Бага зэргийн интервенцтэй)
Өмчийн эрх	3	Тогтвортой. (Дунд зэргийн хамгаалалттай)	4	Муудсан. (Бага зэргийн хамгаалалттай)
Зохицуулалт	4	Тогтвортой. (Өндөр түвшинтэй)	4	Тогтвортой. (Өндөр түвшинтэй)
Албан бус зах зээлийн үйл ажиллагаа	3	Тогтвортой. (Дунд зэргийн үйл ажиллагаатай)	4	Муудсан. (Их хэмжээний үйл ажиллагаатай)
Нэгдсэн индекс	2.75	Бараг чөлөөтэй	2.83	Бараг чөлөөтэй

Тайлбар: Саарлаар будсан нь дунджаас дээгүүр утга авч байгааг, хар саарлаар будсан нь өмнөх оноосоо муудсаныг илэрхийлнэ.

ашгийн татвар (corporate taxation) болон Засгийн газрын зардлын өөрчлөлт гэсэн гурван үзүүлэлтийн дундаж байдаг. Монгол Улсын хувьд Орлогын татвар-3 (дунд зэргийн татварын түвшинтэй), Компаний ашгийн татвар-4 (өндөр татварын түвшинтэй) байгаа. Херитэж сангийн индексээс дэд бүлгүүд, индексийн талаас аваад үзвэл өнөөгийн байдлаар хамгийн муу утга авч байгаа үзүүлэлтүүд нь өмчийн эрх, зохицуулалт, албан бус секторын үйл ажиллагаа байна. Хамгийн муу дүнтэй гарсан нь:

- *Өмчийн эрх: Хувийн өмчийн хамгаалах хуулийн үйлчлэл, албадлага султай.*

- *Зохицуулалт: Бизнесийн үйл ажиллагаанд их хэмжээний зохицуулалт байдаг.*
- *Албан бус секторын үйл ажиллагаа: “Transparency International” байгууллагын гаргасан Монгол Улсын индекс энэ жил 4 байгаа учраас энэ бүлгийн индекс 1-ээр нэмэгдэн муудсан.*

2.4.5 Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний өнөөгийн байдлын талаарх дүгнэлт

Фрейзер Институтын аргачлалаар тооцсон манай улсын эдийн засгийн эрх чөлөөний индексээс харахад зах зээлийн

зохицуулалт гэсэн хэсэг нь муу дүнтэй гарсан байна. Херитэж Сангийн индекс нь ерөнхийдөө эрх чөлөө муу, цаашид сайжруулах зүйлүүд ихтэй байна гэж дүгнэгдсэн байна. Мөн нэгдсэн индексийн утга тогтворгүй, дунджаас дээгүүр байгаа нь эдийн засгийн эрх чөлөөнд чиглэгдсэн бодлого, үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Хоёр индексийг нэгтгэн дүгнэвэл эдийн засгийн эрх чөлөөг хангахад хамгийн том саад хориг болж байгаа нь бизнесийн зохицуулалт болон түүнтэй холбоотой өмчийн эрхийн хамгаалалт муу, төрийн оролцоо хэт их байгаагаас нэмэгддэг албан бус секторын үйл ажиллагаа юм. Тэгвэл манай улсын хувьд цаашид эдийн засгийн эрх чөлөөг хангах, одоо байгаа нөхцөл байдлаа сайжруулахад дээр дурдсан бүлгүүдэд хамаарах үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийн оновчтой, эдийн засгийн эрх чөлөөг хангах түвшинг тодорхойлон, түүнд чиглэгдсэн бодлого явуулах нь үр ашигтай, зөв үйл ажиллагаа байх болно.

Аливаа улсын эдийн засгийн эрх чөлөөг засгийн газрын зохицуулалт, институцийн бүтэц тодорхойлдог учраас Нээлттэй Нийгэм Форумын судалгааны болон Херитэж Сангаас нийтлэгдсэн Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний талаарх үр дүн манай улсын хувьд институцийн хөгжил асар чухал байгааг нотолсон баримт болсон гэж үзэж болно.

Дараачийн бүлгүүдэд бид институци ба түүний Монгол дахь өнөөгийн хөгжлийн байдал, өсөлтийн нөөцийг дэлгэрэнгүй авч үзнэ.

2.5 МОНГОЛЫН ДНБ-ИЙ БОЛОМЖИТ ТҮВШИН

1998, 2003 онуудад Гарвард болон Колумбийн Их Сургуульд ажилладаг алдартай эдийн засагч Жеффри Сакс байгаль, газар зүйн ялгаатай тогтоцтой улс орнуудын ДНБ-ий боломжит хэмжээ ямар байх вэ гэсэн тооцоог хийсэн. Түүний хийсэн тооцоогоор 1995 онд хамгийн ашигтай газар зүйн байршил, байгалийн нөхцөл, төр, нийгмийн тогтолцоотой орнууд нэг хүнд ногдох ДНБ нь дунджаар 18000 ам. доллар байсан байна¹².

Хэрэв эдгээр нөхцлүүд өөрчлөгдвөл дундаж орлого нь буурах хандлагатай. Эдгээр үзүүлэлтүүд байгалийн, газар зүйн болон нийгмийн тогтолцооны нөлөөг харуулж байгаа юм. Жишээ нь, аливаа улс далайд гарцгүй нь тухайн улсын эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг тул нэг хүнд ногдох ДНБ нь дунджаар 5190 ам. доллараар, газар зүйн болон байгалийн таатай бус нөхцөлд буюу хагас халуун газар зүйн бүсэд оршдог орнуудын тоонд орсон байвал тухайн бүс нутгийн онцлогтой өвчин (хумхаа, чичрэг өвчин г.м.) болон бусад байгалийн шалтгаанаас хамааран хөгжил ихээхэн удааширдаг тул эдгээр орны дундаж орлого 4785 ам. доллараар буурдаг гэсэн тооцоо гарчээ. Харин социалист (төлөвлөгөөт) тогтолцоотой улсуудад дундаж орлого 10053 ам. доллараар бага байдаг гэсэн дүн гарчээ. Энэ нь байгалийн онцлогоос хамаарсан эдийн засгийн хөгжил, өсөлтийн хүчин зүйлүүд байдгийн зэрэгцээ тухайн улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоо хэрхэн шийдвэрлэх үүрэгтэй байгааг нотлож байгаа нэг үзүүлэлт юм.

Дээрхи Ж.Саксын тооцооноос үзэхэд, хэрэв Монгол Улс төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо хэвээрээ байгаа гэж

¹² Geography and Economic Development, J.Sachs, J. Gallup, A. Mellinger, NBER Working paper, 1998. Бүх тоо худалдан авах чадварын индексээр хэмжсэн үзүүлэлтүүд.

таамаглахад Монголын нэг хүнд ногдох ДНБ хамгийн дээд хязгаарт 18000-5190-10053 буюу 2757 ам. доллар байх боломжтой байсан байна гэсэн тооцоо гарч байгаа. Энэ нь олон улс орны дундаж тоо учраас бодит тоо нь үүнээс их эсвэл бага байх болно. Харин төлөвлөгөөт эдийн засгийн системээс татгалзаж, зах зээлийн эдийн засагт бүрэн шилжиж чадвал Саксын тооцоогоор далайд гарцгүй боловч социалист бус эдийн засагтай орнуудын тоонд орж онолын хувьд дээд тал нь нэг хүнд ногдох ДНБ 12810 ам. долларт хүрч болох юм.¹³

Хамгийн сүүлийн статистикийн тоог харахад, 2005 оны байдлаар Олон Улсын Валютын Сангаас 181 гишүүн орныг жагсаахад Монголын нэг хүнд ногдох ДНБ худалдан авах чадвараар 2175 ам доллар ба дэлхийд 138-р байранд, харин худалдан авах чадвараар хөрвүүлээгүй тохиолдолд 133-р байранд буюу нэг хүнд ногдох ДНБ 735 ам доллар байсан.¹⁴ Тус жагсаалтад худалдан авах чадвараар хөрвүүлсэн ДНБ-ий үзүүлэлтээр хамгийн өндөр нь Люксембург 69800, хоёрт Норвеги 42364, гуравдугаар байранд АНУ 41399 ам доллар байна. Үүнд хоёр зүйлийг тэмдэглэх нь зүйтэй. Нэгдүгээрт, Монгол Улсад далд эдийн засгийн хувь нь нилээд өндөр байдгийг сүүлийн үеийн судалгаанууд нотолдог билээ. Хэд хэдэн аргаар үнэлсэн судалгааны дүнг харахад, Монголын эдийн засагт далд эдийн засаг 15-30%, зарим судлаачийн үзэж байгаагаар 50%-ийг эзлэж байна. Гэхдээ ийнхүү далд эдийн засгийн хэмжээг эцэслэн тогтоож чадахгүй байгаа ч гэсэн Монголын албан ёсны статистикийн тоог харахад, Монгол Улсад ДНБ-ийг өсгөх боллоцоо, нөөц нилээд их байгаа юм.

Монголын газар зүйн болон байгалийн онцлогийг харгалзан худалдан авах

чадвараар хөрвүүлсэн нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцоход одоогийн түвшнээс 6 дахин өсөх боломжтой гэсэн онолын дүгнэлт гарч байна. Энэ цэвэр онолын дүн болохоос ДНБ зайлшгүй ийм түвшинд хүрэх ёстой гэсэн үг биш, мөн нөгөө талаар Монголын хүн ам цөөн, нягтрал багатай, байгалийн сэрүүн бүсэд оршдог гэсэн сөрөг хүчин зүйлс байгаа зэрэг нь дээрх дүнг бууруулж болзошгүй юм.

Гэвч үүний зэрэгцээ байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ордууд ихтэй, Хятад, Орос гэсэн асар том хоёр зах зээлийн дунд оршиж байгаа зэрэг нь ДНБ-ийг байгаа түвшнээс илүү ихээр өсгөх нөөц, боломж байгааг илэрхийлж байна.

2.6 ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ДУТУУ АШИГЛАГДАЖ БАЙГАА БОЛОМЖУУД

Монголын эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх олон нөөц боломжийн нэг нь бизнесийн салбарын хөгжил. Үүнд хувьчлагдсан улсын болон хувийн компаниуд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа хүмүүс, төрийн эзэмшлийн аж ахуйн нэгжүүдийг оруулж байгаа юм.

1990 оноос хувьчлал идэвхтэй явагдсаны үр дүнд шинээр олон хувийн үйлдвэр, компаниуд байгуулагдан хөгжсөнөөр хувийн сектор манай улсын ДНБ-ий дийлэнхийг үйлдвэрлэгч, гол ажил олгогч, хөрөнгө оруулагч, бүтээгч хүчин нь болсон. Хувийн хэвшил Монгол Улсын нийт ДНБ-ий 3/4-ийг бүтээж, зарим салбарт 100%-ийг эзэлж байна. Тиймээс энэ хэвшлийн үйл ажиллагаа, үр өгөөж Монголын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдлыг тодорхойлж байна гэж хэлж болно. (Хүснэгт 2.8.)

Хувийн хэвшлийнхэн Монголын эдийн засгийн өсөлтөд өндөр хувь нэмэр оруулсныг Хүснэгт 2.9 өөс харж болно.

Үр дүнг харвал 2005 онд нийт эдийн засаг 6.2 хувиар өссөний 2.93 пунктыг нь

¹³ Тус тооцоонд хүн амын нягтрал зэрэг үзүүлэлтүүдийн нөлөөг орхисон болно.

¹⁴ [http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_\(PPP\)_per_capita](http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_(PPP)_per_capita)

Хүснэгт 2.8. Хувийн хэвшлийн тухайн салбарын ДНБ-д эзлэх хувь

ДНБ-д хувийн секторын эзлэх хувь	хувиар percentage					
	1999	2000	2001	2002	2003	2004*
Нийт ДНБ	70,3	72,2	75,0	74,5	73,0	76,0
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	96,4	98,0	98,3	98,4	91,1	95,9
Уул уурхай, олборлох үйлдвэр	56,0	56,6	74,9	64,2	61,7	69,0
Боловсруулах үйлдвэр	75,0	78,7	94,9	87,8	86,2	86,4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж				3,1	3,2	3,2
Барилга	89,1	89,2	89,5	93,1	94,2	94,0
Бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээ	80,3	88,8	90,0	98,2	99,9	99,9
Зочид буудал, зоогийн газар	84,3	91,7	94,6	100,0	100,0	100,0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	41,1	57,7	58,0	60,1	59,7	62,9
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	28,0	31,4	30,6	59,9	77,7	77,8
Үл хөдлөх хөрөнгө, түрээс	77,6	82,6	78,5	86,0	91,0	91,4
Боловсролын салбарын үйл ажиллагаа	12,9	11,0	8,2	9,5	11,9	14,5
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	5,5	6,3	6,5	9,0	11,4	12,1
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	41,1	45,9	48,4	48,5	40,7	40,6

бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээний салбарын, 1.64 пунктыг нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын, 1.22 пунктыг нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийнхэн бий болгожээ. Уг гурав нь хамгийн их эерэг нөлөө үзүүлсэн салбар байсан бол үүний эсрэг нийт эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлсэн салбар нь боловсруулах салбар байжээ. Энэ салбарын уналт нь нийт эдийн засгийн өсөлтийг 1.8 пунктээр бууруулжээ.

Дүгнэж хэлэхэд 1999-2005 оны хооронд Монголын эдийн засаг нийтдээ 31.81 хувь буюу 1.3181 дахин өссөний дийлэнх хэсгийг хувийн хэвшлийнхэн бий болгожээ. Салбар бүрт хувийн хэвшил яг ямар хэмжээг нь

бий болгосныг өмнөх хэсэгт хэрэглэсэн пропорцын аргаар тодорхойлъё. (Хүснэгт 2.10.)

Эндээс харахад дээрх онуудад эдийн засаг 31.81%-иар өссөний 27.1 пунктыг нь хувийн хэвшил түүний дотор 9.61-ыг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээний салбар, 7.22-ыг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар, 3.24-ыг тээвэр, агуулахын аж ахуй, тээврийн салбар, 2.14-ыг нь уул уурхай, олборлох салбарын хувийн хэвшил бий болгосон.

Хувийн хэвшлийнхний эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөр байгаа хэдий ч зээлийн хүүгийн болон татварын дарамт, авилга, хээл хахууль болон албан бус төлбөрийн дарамт төдийлөн багасахгүй, зарим тохиолдолд улам өсч байгааг олон

Хүснэгт 2.9 Хувийн хэвшлийн нийт эдийн засгийн өсөлтөнд үзүүлсэн нөлөөлөл, салбараар (хувиар)

№	Салбар	2000	2001	2002	2003	2004	2005*
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	-4.80	-5.21	-2.60	-0.93	5.72	1.22
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	0.37	2.93	-1.37	-0.57	3.15	1.64
3	Боловсруулах үйлдвэр	0.07	2.85	1.00	0.14	-0.12	-1.08
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Барилга	-0.32	0.19	0.41	0.95	0.03	0.26
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	6.56	2.40	5.68	1.99	1.03	2.93
7	Зочид буудал, зоогийн газар	0.26	-0.05	0.13	0.00	0.08	0.16
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2.85	0.99	1.53	0.73	1.79	0.95
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.13	0.15	1.06	1.12	1.03	0.55
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	0.16	0.02	0.30	0.25	0.19	0.23
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	-0.06	-0.12	0.08	0.08	-0.09	0.06
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.02	0.01	0.05	0.03	-0.04	0.09
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.09	0.03	0.11	-0.06	0.05	0.06
	Хувийн хэвшлийн нийт өсөлтийн пункт	5.32	4.18	6.37	3.73	12.83	7.08
	Нийт өсөлт хувь	1.1	1.0	4.0	5.6	10.6	6.2
	Зөрүү	-4.22	-3.18	-2.37	1.87	-2.23	-0.88

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн,

- Урьдчилсан тооцсон тоон өгөгдөл ашигласан
- Тодруулсан салбарууд 2005 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байв

судалгаа нотолж байна. Үүний нэг жишээ нь 2004 онд бизнес эрхлэгчид өөрийн үйл ажиллагаанд хамгийн саад бэрхшээл болж байгаа зүйлийг төрийн уян хатан бус бодлого, авилга, хүнд суртал гэж тодорхойлсон нь юм. Сүүлийн үед эрх зүйн орчны дутагдал, төрийн хяналтын үүрэг сул байгаагаас хувиараа бизнес эрхлэгчид, хувийн хөрөнгө оруулагчид хохирох явдал их гарч байна. Иймд сүүлийн жилүүдийн Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн

эерэг үр дүн нь цөөхөн хэдэн салбарын үйл ажиллагааны дүнд л бий болж, бусад салбар ерөөсөө өсч чадахгүй байна гэж хэлж болно.

Хувийн хэвшил Монголын эдийн засагт манлайлах хэмжээнд хүрсэн боловч түүний өсөлт олонх салбарт маш их хязгаарлагдмал байна. Үүний шалтгаан нь институцийн хөгжил гэж нэрлэгдэх хууль, эрх зүй, бизнесийн орчны асуудлууд, бизнесийн талаар явуулж байгаа төрийн бодлогын дутагдалтай талууд гэж тогтоогдсон.

Хүснэгт 2.10. Хувийн хэвшил 1999-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр

№	Хувийн хэвшил 1999-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлт оруулсан хувь нэмэр, салбараар	Цэвэр өсөлтийн хувь
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	0.0722
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	0.0214
3	Боловсруулах үйлдвэр	0.0149
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.0000
5	Барилга	0.0101
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	0.0961
7	Зочид буудал, зоогийн газар	0.0044
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	0.0324
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.0112
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	0.0053
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	0.0000
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	0.0011
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.0008
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.0011
	НИЙТ	0.2710

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн

2.7 ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМЫН ТУХАЙ

Дээрх байдал 2005 онд Нээлттэй Нийгэм Форумас зохион байгуулсан Эдийн засгийн эрх чөлөөний судалгаанд манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт тийм муу гараагүй ч (134 орноос 74-р байранд орсон) бизнесийн үйл ажиллагааг төрийн зүгээс хэт их зохицуулах явдал одоо ч ажиглагдаж, бизнесийн эрх зүйн орчин, хуулийн хамгаалалт нь боловсронгуй бус байгаагаас болж бизнесийн үйл ажиллагаанд цаг хугацаа, хөрөнгийн ихээхэн алдагдал, зардал гарч улмаар бизнесийн хэвшлийн хөгжил нь удааширснаас Монгол Улсын эдийн засгийн хөгжил, өсөлт нийтдээ саарч байна. Сүүлийн

жилүүдэд макро эдийн засгийн талаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт нийт дүнгээрээ өндөр мэт харагдаж байгаа боловч өсөлтийн бүтэц нь жигд бус, Монголын эдийн засгийн гол хөдөлгүүр болсон хувийн хэвшил хөгжихөд ихээхэн саад бэрхшээл учирч байгаагаас улс орны хөгжилд оруулах хувь нэмрээ бүрэн дүүрэн оруулж чадахгүй байна.

Монгол Улсын стратегийн хөгжлийн хувьд ч хувийн хэвшлийг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх асуудал иж бүрнээр шийдэгдээгүй, төрийн болон хувийн аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн ажиллагааны орчин, эрх зүйн тогтолцоо нь хөгжлийн нэгдсэн үзэл баримтлалд үндэслэгдээгүй, цэгцрээгүй

зарим талаар хоцрогдонгүй байна. Үүний улмаас улсын хэмжээгээр эдийн засгийн өсөлт саарч, шинэ ажлын байр бий болохгүй, ядуурлын асуудал шийдэгдэхгүй, хөрөнгө оруулалт хийгдэхгүй зэрэг сөрөг үзэгдэл байсаар байна. Энэ нь байгаль орчин, түүхий эд, байгалийн баялаг зэрэг нөөцтэй огт холбоогүй, харин цэвэр нийгэм, түүний албан ба албан бус журам, эрх зүйн орчны сахилга бат, хуулийн хэрэгжилт зэрэг асуудлаас үүдэлтэй бөгөөд үүнийг эдийн засгийн хэллэгээр “институцийн” асуудал гэж нэрлэдэг.

Энэ бол Монголын эдийн засгийн хөгжлийн суурь асуудал ба аль нэг салбарын өсөлт эсвэл ямар нэг экспортын барааны үнийн асуудлаас ч илүү өргөн хүрээтэй, Монголын хөгжлийн тулгуур болон концепцийн асуудал гэж үзэж байна.

Энэ жилийн Монгол Улсын Эдийн Засгийн Эрх Чөлөөний тоймд бид Монголын институцийн хөгжлийн асуудлыг судалж, түүний өнөөгийн байдал, дутагдлууд, эдийн засгийн өсөлт, хөгжилд энэ нь хэрхэн сөргөөр нөлөөлж, өсөлтийг сааруулж байгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотлохыг эрмэлзэж байгаа юм.

Өнөөгийн Монголын эдийн засгийн өсөлтийг дэлхийн зах зээл дэх түүхий эдийн өндөр үнэ, уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт хоёр ихээхэн дэмжиж байгааг дээр дурдсан. Гэтэл дэлхийн зах зээлийн үнэ, уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт нь тогтвортой хүчин зүйлс биш. 1998 онд дэлхийн зэсийн үнэ ихээхэн хэмжээгээр буурч, Монголын эдийн засаг, санхүүгийн байдлыг гүн хямралд оруулж байсан билээ.

Гадаадын хөрөнгө оруулагчид ч мөн Монголын байдлыг сайтар ажиглаж, өөртөө ашиггүй боллоо гэж үзсэн тохиолдолд тэр дор нь хөрөнгө оруулалтаа татаж гаргаад үлэмж хэмжээний байгаль орчин, нийгмийн

хохирлыг учруулдаг нь 2006 онд шинээр батлагдсан алт, зэсний дэлхийн үнийн өсөлтийн татварын дараахь байдал, мөн 1998-1999 онд алтны татвар нэмэгдсэний дараа болон 2004-2006 онд Монгол АНУ-ын зах зээлд оёмол бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлтэй экспортлох эрхээ алдсаны дараа гадаадын маш олон компани Монголыг орхисон байдлууд харуулж байна. Тэгэхээр дэлхийн зах зээлийн алт, ноолуур, зэсийн үнэ болоод гадаадын хөрөнгө оруулалт нь Монголын эдийн засгийн тогтвортой өсөлтийг бататгаж чадахгүй. Харин ч Монголын эдийн засаг эдгээр хүчин зүйлсийн нөлөөнөөс болж маш их эрсдэлтэй учирч цөөхөн барааны дэлхийн зах зээлийн үнээс эдийн засаг улам хараат болж байгаа нь улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Энэ тоймд дэвшүүлж буй гол санал нь **Монголын эдийн засгийн эрх чөлөөг сайжруулснаар хувийн хэвшлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Монголын эдийн засгийн өсөлт дотоодын нөөц бололцоог ашиглан одоогийн түвшнээс илүү өндөр байх бололцоо байгаа бөгөөд энэ бололцоог ашиглах нь байгалийн нөөц баялаг, дэлхийн зах зээлийн үнээс бус, зөвхөн Монголын нийгмийн байдлаас, бодлого боловсруулагчдаас л шалтгаална гэдэгт оршиж байгаа юм.**

Нийгмийг эрүүлжүүлж, хуулийн биелэлт, эрх зүйн орчинг сайжруулан хувийн хэвшил хөгжих нөхцлийг тавьснаар Монголын эдийн засаг улам эрчимтэй өсөх, ашиглагдаагүй нөөцөө бүрэн дүрэн ашиглаж, хүмүүсийн амьжиргааг сайжруулах асар их нөөц боломж бий. Энэ зорилгод эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах бодлого болон Монголын институцийн хөгжлийг эрчимжүүлэх замаар хүрэх бололцоотой.

3. Институцийн хөгжил

3.1 ИНСТИТУЦИЙН ТУХАЙ

Институци гэдэг үг нилээд их хэрэглэгддэг ухагдахуун бөгөөд түүнийг заримдаа байгууллага гэсэн утгаар ойлгодог боловч түүний шинжлэх ухааны тодорхойлолт нь үүнээс ялгаатай, илүү өргөн утгатай юм. Тус бүлэгт институцийн тухай ойлголт, тодорхойлолтыг дэлгэрэнгүй танилцуулна.

Институци бол хүмүүсийн хоорондох аливаа харилцаа, солилцоог журамласан нийгмийн журмууд бөгөөд эдгээр нь:

- албан журмууд (хууль, хуулийн зохицуулалт, эрх зүйн орчин),
- албан бус нийгмийн журмууд (нийгмийн ёс, дэг, уламжлал)
- тэдгээрийн биелэлт, хэрэгжүүлэгч зүйлсээс бүрддэг^d.

Өөрөөр хэлбэл институци нь хүмүүсийн хооронд үүсч буй харилцаа, үйлдлийг (трансакци-transaction) зохицуулдаг журмууд ба тэдгээрийг хэрэгжүүлэх орчин ба хэрэгслүүд юм. Жишээ нь, хөдөлмөрийн гэрээ хуулинд үндэслэсэн байдаг гэвэл уг гэрээ, гэрээг зохицуулах хууль, гэрээний болон хуулийн биелэлтийг хянагч, хэрэгжүүлэгч байгууллагууд, аргууд, тэдгээрийг тойрсон эрх зүйн орчин, нийгмийн ёс зүй, уламжлал бүгд нийлээд институци гэж тодорхойлж болно. Зах зээлийн эдийн засаг дахь бизнес, эдийн засгийн үйл ажиллагаа бүхэлдээ төрөл бүрийн гэрээнд үндэслэдэг болохоор институци нь бизнес эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөтэй байх нь ойлгомжтой.

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг эдийн засгийн агентууд гэж нэрлэдэг бөгөөд эдгээр нь төр засаг, хувь хүмүүс болон байгууллагууд байдаг. Эндээс байгууллагууд нь дээр дурдсан журмуудыг хэрэгжүүлэх эсвэл нэгдсэн зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагаагаар нэгдэн байгуулагдсан бүлгүүд мөн бөгөөд тэдгээрийг улс төр (намууд, парламент,

яам, агентлаг г.м.), эдийн засаг (компани, үйлдвэрчний эвлэл, хоршоо г.м.), нийгмийн сонирхлын (шашин, клуб, спортын холбоод г.м), боловсролын бүлгүүд (сургуулиуд, боловсролын төвүүд г.м.) гэж ангилдаг. **Ийнхүү институци гэдэг нь байгууллагаас илүү өргөн хүрээтэй ойлголт байдаг байна.**

3.2 ИНСТИТУЦИ БА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ

Институци нь эдийн засгийн эрх чөлөөтэй шууд холбоотой ойлголт бөгөөд тухайн улсын эдийн засгийн эрх чөлөөг нийгмийн институци тодорхойлдог юм. Зарим нөхцөлд эдийн засгийн эрх чөлөө болон институци бол ижил утгыг агуулдаг.

Жил болгоны Фрейзер Институтээс гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайланд институци болон эдийн засгийн эрх чөлөөний хоорондох холбоог дараахь байдлаар тодорхойлсон байдаг: *“Эдийн засгийн эрх чөлөөний тулгуур хэсгүүд бол хувийн сонголт, сайн дураар солилцоонд оролцох эрх, өрсөлдөх эрх ба хувь хүмүүс болон тэдгээрийн өмчийн хамгаалал юм. Институци ба бодлого сайн дурын солилцооны дэд бүтцийг ханган өгч, хувь хүмүүс болон тэдгээрийн өмчийг аливаа дайралтаас хамгаалдаг бол эдийн засгийн эрх чөлөөтэй нийцэж байдаг... Үүнд, ялангуяа хуулийн болон мөнгөний зохицуулалт чухал байр суурийг эзэлдэг: өмчийн эрхийг хамгаалах, гэрээ хэлцлийн тэгш хэрэгжилтийн хууль зүйн орчин, хууль хэрэгжүүлэх системийг бий болгож өгснөөр засгийн газрууд эдийн засгийн эрх чөлөөг дэмждэг”^e.*

Институци нь өмчийн эрхийг бататгаж, гэрээ, хуулийг хэрэгжүүлэх орчинг бүрдүүлснээр эдийн засгийн эрх чөлөөг дэмждэг бол нөгөө талаас эдийн засгийн эрх чөлөөг хумих явдал бас гарч болно. Институци нь албан ёсны хууль журам

болон албан бус дэг ёс, гэрээ хэлцлийн хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлдэг болохоор эдгээр хууль, журмууд нь төрийн оролцоог хэт их болгосноор эдийн засгийн эрх чөлөөг хумина гэсэн үг. *“Төр засаг хувийн сонголт, сайн дурын солилцоо, хөдөлмөр болон бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэн өрсөлдөх эрх чөлөөг хязгаарлаж, зах зээлийн зохицуулалтыг татвар, засгийн газрын зардал, журам тогтоолоор орлуулах юм бол эдийн засгийн эрх чөлөө боогдмол байдалд ордог”*^f. Иймээс институци бол эдийн засгийн эрх чөлөөг бууруулж ч, нэмэгдүүлж ч чадах ба төрийн бодлого, хууль, эрх зүйн орчны бүрдэлт түүгээр дамжин эдийн засгийн өсөлт, хөгжилд нөлөөлөх боломжтой.

Эдгээр дүгнэлт нь төрөөс институцийн тогтолцоог сайжруулах, эдийн засгийн харилцаан дахь сөрөг үр дагавар бүхий үзэгдлийг бууруулахад эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах арга хэмжээ нь үр нөлөөтэй, чухал байж болох юм гэдгийг илэрхийлж байгаагаараа ач холбогдолтой юм.

Түүхэн хөгжлийн явцад аж ахуйн гэрээ, хэлцлийн биелэлтийн механизм болон өмчийн эрхийн хуулиуд бий болж эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож буй субъектуудын өмчийн эрх ашгийг хамгаалдаг болсон. Жишээ нь, Англи Улсад 17-р зуунд парламент хааныг ялснаар хууль эрх зүйн орчин давамгайлж, гэрээ, хуулийн биелэлт сайжирч, улмаар бизнесийн эрсдэл буурч, Английн хувийн сектор идэвхтэй хөгжиж эхэлсэн гэж үздэг. Нөгөөтэйгүүр, Англи, Голланд улсуудад эдийн засгийн бие даасан байдал, эрх чөлөө сайн хөгжсөн нь нийгэмд эдийн засгийн засаглал идэвхтэй бий болох, хурдан төлөвших нөхцөл болжээ. Эсрэгээр, Испани, Португали зэрэг улсад хэт төвлөрсөн засаглалын механизм байсан учраас нийгмийн аливаа үйл ажиллагаа хэт их хяналтын дор байсан”^g. Энд хууль биш хааны шийдвэр зонхилдог байсан нь эдийн

засгийн эрх чөлөөг багасгах, хөгжлийг удаашруулах шалтгаан болжээ.

Д.Нортын гол санаа нь засаглал хэт их төвлөрсөн үед бүх асуудал, аж ахуйн тоглоомын дүрэм нь хаан, түүний эргэн тойрны хүмүүсээс ихээхэн шалтгаалж, улмаар эдийн засаг, бизнесийн байдал, журам, чиглэлийг дураар өөрчилж, тодорхойгүй болгосноор хөгжилд саад учруулж, бизнесийн эрсдлийг ихээхэн өсгөж байсан бол Англи, Голландад хааны эрхэнд хязгаарлалт тавьж, хуулийг дээдэлдэг, хэт их төвлөрөлгүй бизнесийн орчинг бүрдүүлснээр эдгээр улс эрчимтэй хөгжих суурь нь тавигдаж, улмаар тухайн үеийн хамгийн өндөр хөгжилтэй орнууд болсон юм. Үүнд нөлөөлсөн гол зүйл нь хуулийг дээдлэх орчин, институцийг бүрэлдүүлж, эдийн засгийн эрх чөлөөг бизнесийн салбарт олгосон явдал юм. Ингэснээр бизнесийн явцад үүсдэг аливаа харилцаа, солилцооны зардал буурч, хувийн сектор эрчимтэй хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх нөхцөл бүрдсэн.

Эдгээр улс үүнийг төрийн бодлогоор дамжуулан хуульчилсан байдаг. “Бид эдийн засгийн түүхэнд улс орнуудыг хоёр төрөлд хувааж болно: зарим улс (баялгийн) дахин хуваарилалтыг дэмжиж байсан ба тэдгээр улсад улс төрийн нөлөөлөл болон төрийн оролцоо хэт их болсон; харин нөгөө бүлэгт институциуд нь бүтээлч үйл ажиллагааг дэмжиж, амжилттай хөгжсөн Голланд болон Англи зэрэг улсыг оруулж болно. Эдгээр улсад институци нь улс төрийн хүчнүүдийн нөлөөг хүчтэй хязгаарлаж чадсан юм”. Өөрөөр хэлбэл амжилттай хөгжсөн орнуудад эдийн засгийн бүтээмжийг өсгөх үйл ажиллагааг дэмждэг^h орчин, институци бүрэлдсэн байсан.

Эрх зүйн орчны хөгжил ийнхүү эдийн засгийн үйл ажиллагаа, солилцоог урамшуулах механизм болж үүнд төр онцгой ач холбогдолтой оролцогч болсон. Төр

хуулийн хэрэгжилтийг хариуцаж, хэн нэгний сайн дурын бус, харин журам, хууль дээр үндэслэсэн эдийн засгийн үйл ажиллагааны орчныг бүрэлдүүлснээр эдийн засгийн хөгжил, өсөлтийн суурь тавигджээ.

1996 онд институцийн эдийн засгийн алдартай эдийн засагч Дуглас Норт “Цаг хугацаа ба эдийн засгийн гүйцэтгэл” гэсэн өгүүлэлдээ нийгмийн дүрэм журам, төрийн зохицуулалтын арга, хуулиуд эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлдгийг дараахь байдлаар тодорхойлсон билээ: “Эдийн засгийн өөрчлөлт (өсөлт, хөгжил) нь процесс (үйл явц) бөгөөд уг процессийг бий болгож байгаа хүчин бол нийгмийн институци юм. Хүмүүс өөрсдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн зорилгоо биелүүлэхэд тулгарах тодорхой бус байдал, үүсэх эрсдлийг багасгах зорилгоор тэдний хоорондох харилцааг бүтцэд оруулахын тулд институцийг бий болгодог”.

Институцийн хөгжил нь эдийн засгийн бодлогод тусгалаа олж, эдийн засгийн эрх чөлөөг хувийн секторт олгож, улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө гарч байсныг өөр нэг түүхэн жишээнээс харья.

1776 онд Их Британий алдартай эдийн засагч Адам Смит эдийн засгийн шинжлэх ухааны суурь бүтээлүүдийн нэг болох “Үндэстний баялаг”-аа нийтэлсэн билээ. Энэ номд А.Смит эдийн засгийн хөгжил, бүтээмж, мөнгөний эргэлт зэрэг олон асуудлыг авч үзсэн боловч түүний хамгийн чухал санаа нь *зах зээлийн эдийн засаг нь өөрийгөө зохицуулж чаддаг ба эдийн засаг дахь төрийн оролцоо эдийн засгийн өсөлтийг хангах суурийг бий болгоход л орших ёстой* гэсэн санаа байсан. Энэ бол эдийн засгийн төрийн бодлого, институцийн хөгжил ба эдийн засгийн өсөлт гурвыг холбосон санаа байлаа.

Энэ санааг Адам Смитын шавь, 18-р зуунд 24 настайдаа Их Британий ерөнхий

сайд болж, 17 жил улсаа амжилттай удирдсан Вильям Питт (1783-1801, 1804-1806) төрийн бодлогод анх хэрэгжүүлсэн юм. Вильям Питт төрийн зардлыг багасгах, худалдаа бизнесийг төрийн хэт их дарамтаас чөлөөлөх, татварыг бууруулах замаар далд эдийн засгийг багасгаж төрийн орлогыг нэмэгдүүлэх, импортын татварыг бууруулж чөлөөт худалдааг хөгжүүлэх зэрэг олон арга хэмжээг авч эхэлснээр эдийн засгийн либеральчилсан бодлогын анхны суурь тавигдсан гэж үздэг.

Хэдийгээр Их Британи улс XVIII-XIX зуунд 20 гаруй жил Францын дайнд нэрвэгдэж эдийн засаг нь хямралд орсон боловч дайн дууссаны дараа 1820 оноос хойш Адам Смитийн сургаалийн дагуу Их Британид эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлэх алхмууд үргэлжлэн дэс дараатай хийгдэж, тасралтгүй хурдацтайгаар хөгжиж эхэлсэн. 1860 он⁸ гэхэд Их Британи дэлхийн хамгийн их баялагтай, нийгмийн бүх давхаргын амьжиргаа нь эрс сайжирсан, аж үйлдвэржсэн орон болж чадсан юм.

Британичууд чөлөөт гадаад худалдааны зарчмыг баримталснаар их газраас хямдхан хүнсийг чөлөөтэй худалдан авч, өөрийн орны өрсөлдөх чадвартай аж үйлдвэрийн барааг чөлөөтэй экспортолсноор амьжиргааны өртөг багатай, өндөр орлоготой болж чадсан бөгөөд өнөө хүртэл Их Британи дэлхийн хамгийн өндөр орлоготой, хөгжингүй орнуудын тоонд орсоор байна.

Институци нь яагаад эдийн засгийн өсөлтийн тодорхойлогч хүчин зүйл болдог вэ? Хамгийн эхний илэрхийлэл нь өсөлтийн тооцоолол дахь үйлдвэрлэлийн гарц нь орцууд болох *газар, хөдөлмөр болон капиталын* нэгдлийн үр дүн гэдгээс урган гарна. Гэвч нийт орцын тодорхой хэсэг нь трансакцийн зардалд шаардагддаг ба шууд үйлдвэрлэлд орж чадахгүй байгаа юм. Тэгвэл институци нь трансакцийн зардалд нөлөөлснөөр үйлдвэрлэлийн боломжийн

хязгаарыг өөрчилж улмаар эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг.

Хоёр дахь нь, институци нь мэргэших, төрөлжих процессийг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг. Үйлдвэрлэлийн хүчин зүйлс болон түүнийг хэрэглэгчдийн хооронд мэдээлэл харьцангуй тэгш, трансакцийн зардал багатай байх буюу институци нь сайн ажиллаж байвал хүчин зүйлсийн боломжит солилцооны олонлогийг илүү өргөн болгож, оновчтой, зөв хуваарилалт, улмаар зах зээлийн үр ашигтай хэмжээг нэмэгдүүлж, төрөлжилтийг дэмждэг. Тодруулбал хүчин зүйлс харьцангуй тэгш хуваарилагдан өөрсдийн давуу талаараа дагнан ажиллах, ашиглагдах боломж хангагдана. Адам Смитийн “төрөлжилт нь эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр механизм байдаг” гэсэн тодорхойлолтын дагуу энэ процесс нь эдийн засгийн өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Сүүлийн жилүүдэд эдийн засагчид институцийн эдийн засгийн талаар өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажил хийх болсон ба үүний нэг нь эдийн засгийн өсөлтөд институци хэрхэн нөлөөлдөг талаарх ажил юм. Дээр өгүүлснээр онолын хувьд институци нь эдийн засгийн өсөлт, хөгжилд шууд болон шууд бусаар нөлөөлж түүнийг тодорхойлж байна. Тэгвэл эдийн засгийн өсөлтийн тоон шинжилгээний загвар, холбогдох тоон мэдээллүүд болон эконометрикийн арга аргачлалыг ашиглан институцийн нөлөөг шинжлэн, тодорхойлох зорилго тавья. Энэ үүднээс эхлээд эдийн засгийн загвар, тоон өгөгдөл, үнэлгээний аргыг тодорхойлох хэрэгтэй.

Энэ судалгааны гол зорилго нь эдийн засгийн загварыг ашиглан Монголын эдийн засгийн өсөлт, институцийн хоорондох холбоог үнэлэн тогтоож, институцийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг хичнээн хувиар хурдасгах боломжтойг тооцоолоход оршиж байгаа юм. Үүнд Монголын эдийн засгийн өсөлтийн тоо

баримт, эдийн засгийн эрх чөлөөний он жилүүдийн үзүүлэлтийн хоорондох хамаарлыг тогтооно.

3.2.1 Монгол Улсын институцийн хөгжлийн загварчилсан судалгаа

Загвар. Шинэ сонгодог өсөлтийн загвар, арга аргачлалыг хэрэглэнэ. Энэ загвар нь 1-рт, ойлгоход хялбар, эдийн засгийн өсөлтийн эмпирик судалгаанд өргөн хэрэглэгддэг. 2-рт, дотоод өсөлтийн онолд эмпирик талаасаа шийдэгдээгүй, тодорхой бус зүйл одоо хүртэл байдаг.

Шинэ сонгодог загварыг авч үзэж байгаа учраас үйлдвэрлэлийн функц нь Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функц байна.

$$Y_t = A \cdot e^{\lambda t} \cdot K_t^\alpha \cdot L_t^\beta \quad (7.1)$$

Y_t - үйлдвэрлэлийн хэмжээ

K_t, L_t - харгалзан капитал, хөдөлмөр

λ - технологийн дэвшлийн параметр

α, β - харгалзан үйлдвэрлэлийн капитал, хөдөлмөрөөс хамаарсан мэдрэмж

A - тогтмол коэффициент.

Энэ загварыг үнэлэхийн тулд дээрх үйлдвэрлэлийн функцийг хоёр талаас натурал логарифм авч шугаман загвар болгон, ХБКА болон бусад шугаман үнэлгээний аргыг хэрэглэдэг.

$$\ln Y_t = \ln A + \lambda t + \alpha \ln K_t + \beta \ln L_t + \varepsilon_t \quad (7.2)$$

Энд, ε_t нь санамсаргүй алдаа буюу регрессийн шугаман загварын таамаглалыг хангана. Натурал логарифмаар илэрхийлэгдсэн дээрх тэгшитгэлийн хувьд тайлбарлагч хувьсагчуудын өмнөх параметрууд нь хувьсагч тус бүрийн нэг хувийн өөрчлөлтөд хамаарах хувьсагч буюу $\ln Y_t$ хичнээн хувиар өөрчлөхийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн өсөлтөд хэрхэн нөлөөлөхийг харуулдаг.

Учир нь натурал логарифмийн хувьд дараахь чанар хангагддаг.

$$\Delta \ln Y_t = \ln(Y_t) - \ln(Y_{t-1}) = \ln\left(\frac{Y_t}{Y_{t-1}}\right) \approx \frac{Y_t - Y_{t-1}}{Y_{t-1}} = g \quad (7.3)$$

Тэгвэл эдийн засгийн өсөлтийг тайлбарладаг дээрх тэгшитгэлд институцийн мэдээлэл, өгөгдлийг хэрхэн оруулах вэ гэсэн асуудал гарч ирнэ. Өмнөх онолын хэсэгт үзсэнээр институци нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлүүдийн ашиглалт, боломжит байдал зэрэгт нөлөөлж, улмаар дараагийн шатанд эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг гэж тодорхойлогдсон.

Үүнийг шийдэх нэг хялбар арга нь үйлдвэрлэлийн функцдээ шууд тайлбарлагч хувьсагчаар оруулж болно. Тухайн жилийн капитал, хөдөлмөрийн хэмжээ, ашиглалт нь цаагуураа үйлчилж буй институциудын нэг үр дагавар учраас загварт орчихсон байгаа. Тэгвэл институцийн үзүүлэлтийг шууд нэмэх нь эдгээр хүчин зүйлд нөлөөлснөөс гадна өөрөө шууд өсөлтөд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох боломжтой болно.

$$Y_t = A \cdot e^{\lambda t} \cdot K_t^\alpha \cdot L_t^\beta \cdot Ins_t^\gamma \quad (7.4)$$

Энд, Ins -институцийн төлөв байдлыг илэрхийлэх хувьсагч. Шугаман хэлбэрт оруулбал,

$$\ln Y_t = c + \lambda t + \alpha \ln K_t + \beta \ln L_t + \gamma \ln Ins_t + \varepsilon_t \quad (7.5)$$

Энд, $c = \ln A$. Энэ загвар нь өсөлтөд капитал, хөдөлмөр зөвхөн өөрийнхөө түвшнээр нөлөөлөөд зогсохгүй институцийн төлөв байдал мөн нөлөө үзүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ.

Институцийн эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгааг уг загвараас өөрөөр эмпирик загвараар тодорхойлж болно. Энэ нь дээрхээс хялбар, энгийн таамаглал дээр үндэслэнэ. Тодруулбал, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч бусад хүчин зүйлс тогтмол байхад зөвхөн институцийн төлөв байдлын өөрчлөлт өсөлтөд хэрхэн нөлөөлж

болох вэ? гэсэн энгийн бодлогын шинж чанартай таамаглал дэвшүүлбэл дараахь загвар гарч ирнэ.

$$\ln Y_t = \beta_0 + \beta_1 Ins_t + \varepsilon_t \quad (7.6)$$

Энэ загвараар институцийн хувьсагч өөрчлөгдөхөд эдийн засгийн өсөлт хэрхэн өөрчлөгдөж байна вэ гэдгийг хялбархан харж, үнэлж болно.

Тоон өгөгдөл

Дээрх загваруудыг үнэлэхэд эдийн засгийн өсөлт, капиталын хэмжээ, ажиллагсдын тоо, институцийн төлөв байдлыг илэрхийлэх тоон өгөгдлүүдийн динамик хэрэгтэй.

Олон улсын практикт эдийн засгийн шинжилгээнд өсөлтийг бодит ДНБ-ий өсөлтийн түвшингээр тодорхойлдог. Үүний дагуу авч үзнэ. Ажиллагсдын тоог тухайн жилийн нийт ажиллагсдаар төлөөлүүлнэ. Энэ хоёр өгөгдлийг ҮСГ-аас жил бүр гаргадаг статистикийн эмхтгэлээс авах боломжтой.

Манай улсын хувьд капиталын тоо хэмжээ, бүртгэл тооцоог одоогийн байдлаар хийх боломжгүй байна. Үндсэн хөрөнгийн зарим тоон өгөгдөл байдаг ч албан ёсны статистикийн эмхтгэл, тайлангуудад гардаггүй учраас ашиглах боломжгүй байдаг. Энэ асуудлыг хөрөнгө оруулалт, капиталын хоорондын стандарт хамаарлын ялгаварт тэгшитгэлийг ашиглах замаар шийдэж болдог. Дэлгэрэнгүй гаргалгаа, үйлдэл болон үр дүнг хавсралтаас үзэж болно.

Институцийн төлөв байдлыг илэрхийлэх тоон өгөгдлөөр Херитэж Сан болон Уолл Стрийт Журнал (Heritage Foundation/Wall Street Journal) хамтран 1995 оноос эхлэн жил бүр эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” (Index of Economic Freedom) тайлангийн Монгол Улсын индексийг авч, үнэлгээндээ хэрэглэнэ. Энэ индексийг дараахь шалтгаануудаар сонгож авсан.

- Эдийн засгийн эрх чөлөө гэсэн ойлголт нь өөрөө институцийн

эдийн засгийн ухааны нэг ухагдахуун, судлагдахуун байдаг. Нөгөө талаас, эдийн засгийн эрх чөлөө сайн хангагдсан байна гэдэг нь институцийн хөгжил сайн, институцийг зөв, үр ашигтайгаар хөгжүүлж, дэлгэрүүлбэл эдийн засгийн эрх чөлөө хангагдана гэсэн салшгүй, бие биенийхээ шалтгаан болсон ойлголтууд юм. Иймээс эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлыг илэрхийлэх индекс нь институцийн төлөв байдлыг илэрхийлж чадна.

- Институцийн төлөв байдал гэдэг нь өөрөө чанарын үзүүлэлт учраас түүнийг индексээр илэрхийлэх нь хамгийн тохиромжтой юм.
- Институци нь цаг хугацааны явцад удаан, алгуур өөрчлөгддөг учраас түүний эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөөллийг үнэлж, тооцоход урт хугацааны эдийн засгийн өсөлтийн үзүүлэлттэй хамтад нь судлах, авч үзэх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, эмпирик шинжилгээнд аль болох олон жилийг хамарсан тоон өгөгдөл шаардлагатай. Манай улсын эдийн засгийн эрх чөлөө, институцийн төлөв байдлыг олон улсад даган мөрдөж байгаа арга аргачлал, индексээр тооцсон ажил 1-рт цөөхөн, 2-рт өргөн хүрээг хамарч чадаагүй, 3-рт дөнгөж саяхнаас эхэлж байгаа учраас цаг хугацааны хувьд хамгийн эртнээс эхэлсэн буюу 1995 оноос өнөөг хүртэл тооцсон, хамрах хүрээний хувьд харьцангуй том уг индексийг авч ашиглах нь илүү юм.

Монгол Улсын хувьд уг индексийн үр дүн 1995-2006 онуудын хувьд ямар байгааг хавсралтын Хүснэгт 3-аас харж болно. Индексийг тооцох аргачлал, хэмжээс, илэрхийлэл зэргийг өмнөх бүлэгт тайлбарласнаас мөн харж болно.

Үнэлгээний арга

Загвар нь шугаман загвар учраас стандарт ХБКА-ыг (Ordinary Least Squares Method) хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхэд хамгийн гол нь өгөгдөл хангалттай олон, тайлбарлагч хувьсагчид хоорондоо хамааралгүй, стационар, онолын хувьд тайлбарлагч хувьсагчдаа нөлөөлдөг нь баталгаатай байх ёстой байдаг. Эдгээр таамаглал хангагдаж байхад үнэлгээнээс гарсан үр дүнг ашиглах боломжтой. Нөхцлүүд хангагдаж байгаа эсэхийг шалгадаг олон тест, шалгуурууд байдаг ба тэдгээрээс хамгийн түгээмэл, хүчтэй хэрэглэдэг санамсаргүй алдааны тестүүд, АІС, диагностик шинжүүрүүдийг шалгаж, үр дүнгээ баталгаажуулна.

3.2.2 Онолын судалгааны дүн

$$\ln Y_t = c + \lambda t + \alpha \ln K_t + \beta \ln L_t + \gamma \ln s_t + \varepsilon_t$$

загварыг эхлээд үнэлсэн үр дүнг танилцуулъя. Үнэлгээний сайн шинж чанартай үр дүн авахын тулд дээрх загварын тогтмол параметртай болон тогтмол параметргүй гэх мэт хувилбаруудаар үнэлэхэд дараахь тогтмол параметргүй загвар нь илүү сайн, найдвартай үзүүлэлттэй байна.

	Коэффициент	t - статистик
t	-0.03703	-2.686601*
lnK	0.146357	2.168113**
lnL	1.898711	10.63224*
lns	-0.197986	-1.145946
\bar{R}^2	0.89	
DW	1.74	
Чөлөөний зэрэг	6	

Эх сурвалж: Eviews программын үнэлгээний үр дүн.
*, ** - харгалзан 95%, 90%-ийн итгэх түвшинтэйгээр статистикийн хувьд найдвартай.

Үнэлгээний ерөнхий үр дүнг тайлбарлавал институцийн хувьсагчийн өмнөх

параметрээс бусад хувьсагч буюу шинэ сонгодог загварын стандарт үзүүлэлтүүд бүгд 90%-иас дээш итгэх түвшинтэй байна. Үнэлэгдсэн параметруудын тэмдгийн хувьд дараахь дүгнэлтүүдийг хийж болж байна. Хугацааны өмнөх коэффициент нь цаг хугацаан дахь технологийн дэвшлийн нөлөөг харуулна. Үнэлсэн аль ч хувилбаруудын хувьд энэ коэффициент нь хасах тэмдэгтэй, статистикийн хувьд найдвартай гарч байгаа нь манай улсын хувьд 1995-2004 онуудын хооронд технологийн дэвшил бус бууралт явагдаж байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Капитал, хөдөлмөрийн хувьд онолын таамаглалтай тохирсон, статистикийн хувьд найдвартай байна. Институцийн хувьсагчийн өмнөх коэффициент онолын таамаглалтайгаа таарч байна. Херитэж Сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекс нь 1-ээс 5 хүртэлх тоогоор хэмжигддэг, тоон утга ихсэх нь эрх чөлөө буюу институцийн байдал муудаж байгааг, эсрэг өөрчлөлт нь институцийн байдал сайжирч байгааг илэрхийлнэ. Ийм учраас уг хувьсагчийн өмнөх коэффициент сөрөг байх нь институцийн сайжралт эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө гэдгийг илэрхийлнэ.

Үнэлэгдсэн үр дүн дээрхтэй тохирч байгаа учраас манай улсын хувьд ямар ч байсан институци, эдийн засгийн өсөлтийн хооронд эерэг хамаарал байгаа нь эмпирик судалгаагаар батлагдаж байна. Нөгөө талаас энэ үр дүн нь үнэлсэн хувилбар тус бүр дээр мөн ажиглагдаж, гарч ирж байсан. Ингэж дүгнэж байгаагийн бас нэг баталгаа нь уг загвар нь эконометрикийн хувьд найдвартай загварын шинж чанарыг хангаж чадсан. (Хавсралт 2, Хүснэгт 5)

Үнэлгээнд ашиглагдаж байгаа тоон өгөгдлийн хэмжээ цөөхөн, хамрах хугацаа харьцангуй бага байгаа учраас институцийн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллийн

үнэлэгдсэн тоон утгыг статистикийн хувьд найдвартайгаар тодорхойлох боломжгүй, практик бодлогын дүгнэлт, шинжилгээ хийх боломжгүй байна.

Дараагийн алхамд $\ln Y_t = \beta_0 + \beta_1 \ln s_t + \varepsilon_t$ загварыг үнэлсэн үр дүнг танилцуулъя.

	Коэффициент	t - статистик
Тогтмол	15.1639	71.58*
Ins	-0.4231	-6.30*
\bar{R}^2	0.81	
DW	1.24	
Чөлөөний зэрэг	8	

Эх сурвалж: Eviews программын үнэлгээний үр дүн.
*- 95%-ийн итгэх түвшинтэйгээр статистикийн хувьд найдвартай.

Энэ загвар нь харьцангуй энгийн, хялбар загвар юм. Өсөлтөд нөлөөлөгч бусад хүчин зүйл өөрчлөлтгүй, тогтмол байхад институцийн төлөв байдлын индексийг нэг нэгжээр бууруулах буюу институцийн сайжралт нь эдийн засгийн өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлж байна.

Хэрвээ Херитэж Сангийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн утгыг 1 нэгжээр бууруулж чадвал эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч бусад хүчин зүйлс тогтмол байхад 42%-ийн эдийн засгийн өсөлтийг бий болгож чадна гэсэн үр дүн гарч байна. Манай улсын хувьд 1995 оноос өнөө хүртэл уг индексийн утгыг 1 нэгжээр бууруулж чадаагүй 0.62-аар бууруулжээ. Тухайлбал, 2003 оноос 2004 оны хооронд индексийн утга -0.11-ээр өөрчлөгдсөн байна.

Тэгвэл эндээс, тухайн жилд өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс өөрчлөгдөөгүй байхад зөвхөн эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах замаар уг индексийг тодорхойлогч хүчин зүйлсийг дээрх хэмжээгээр өөрчлөхөд 4.6%-ийн эдийн засгийн өсөлтийг бий болгоно гэсэн дүгнэлтийг хийж болно.

Дээрх загварт эдийн засгийн эрх чөлөөний индексээр институцийн байдлыг төлөөлүүлж авч үзсэн. Харин сүүлийн үеийн судалгаанууд¹ институцийн маш олон хэлбэрийг эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан тогтоосон байдаг ба тэдгээрээс хамгийн өргөн агуулгатай, эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй институцийн талбар нь **хуулийн систем, компаниудын зохион байгуулалт болон санхүүгийн систем** гэж үздэг.

Хууль, шүүхийн систем

Хууль, шүүхийн систем болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал нь эрт үеэс улс төр, эдийн засгийн ухааны нэг судлагдахуун байсан. Адам Смит (1755) “шударга, сайн шүүхийн удирдлага нь энх тайван ба татварын бага түвшинтэй холбогдвол баян, элбэг дэлбэг байдлын өндөр түвшинг хангаж чадна” гэж тэмдэглэсэн байдаг. Үүнээс гадна Макс Вэбер мөн хууль, шүүхийн систем ба эдийн засгийн хөгжлийн хоорондын хамаарлыг нийгэм, эдийн засгийн онолын үүднээс судалсан байдаг. Яагаад хууль, шүүхийн систем эдийн засгийн төлөв байдалд нөлөөлдөг вэ? гэдэгт хоёр үндсэн шалтгаан, тайлбар байдаг.

Эдгээр нь өмчийн эрхийг хамгаалж ялангуяа засгийн газраас хянах, түүний

өөрийн хүчийг буруугаар ашиглах сонирхлыг хязгаарлаж байдаг.

Шүүхийн систем нь хувийн ашиг сонирхлын бүлгүүдийн хоорондын солилцоог дэмжиж, түүнийг хэрэгжих явцыг хялбар дөхөм болгож байдаг. (Хүснэгт 3.1.)

Улс төрийн төлөв байдлын үзүүлэлтүүд нь ерөнхийдөө эдийн засгийн эрх чөлөөтэй эерэг хамааралтай байна. Хэрвээ улс орон эдийн засгийн эрх чөлөөг сайн хангаж өгвөл төрийн албанд авилга, хээл хахууль багасаж, нийгэм дэх далд, хууль бус эдийн засгийн хэмжээ буурч байна. **Нөгөө талаас иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөт байдал нь эдийн засгийн эрх чөлөөтэй илэрхий шууд хамааралтай байна.**

Компаний зохион байгуулалт

Шинэ сонгодог үзэл баримтлалаар пүүсийн менежер нь орцын хэмжээ болон технологио сонгон улмаар гарцаа хамгийн их байлгаж чаддаг. Хэрвээ зах зээл нь төгс өрсөлдөөнтэй, мэдээлэл нь чөлөөтэй бол менежментийн ур чадвар хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Анх Роналд Коуз (1937) “трансакцийн зардал байхгүй байна гэж үзэх нь пүүсүүдийн оршин байх шалтгаан нь болохгүй юм. Бүх трансакци нь зах зээл дээр явагдана” гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Нөгөө талаас үйлдвэрлэл нь төгс төвлөрсөн

Хүснэгт 3.1. Эдийн засгийн эрх чөлөө ба эрх зүйн орчны хамаарал

	Үзүүлэлтүүд	Хамаарал	Тайлбар
Эдийн засгийн эрх чөлөө	Авилга, хээл хахууль	Сөрөг	Зохицуулалт, татвар болон тариф бага буюу эдийн засгийн эрх чөлөө илүү байх нь улсын албан хаагчдын хүрээн дэх хээл хахуулийг бууруулж байна.
	Улс төрийн эрх болон Иргэний эрх чөлөө	Эерэг	Улс төрийн эрх (ж-нь, чөлөөт, шударга сонгууль) болон иргэний эрх чөлөө (ж-нь, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх) нь эдийн засгийн эрх чөлөөтэй хүчтэй хамааралтай буюу нэг нь нөгөөгийнхөө шалтгаан, үндэс болж байна..
	Далд эдийн засаг	Сөрөг	Үнэлэгдсэн далд эдийн засгийн хэмжээ эдийн засгийн эрх чөлөө сайтай улсуудад илүү бага байна.

бус арга замаар буюу хувь хүмүүсийн хоорондын гэрээ, тохиролцоогоор хэрэгжиж болох ч энэ үед гарах трансакцийн зардлыг тооцсон үйлдвэрлэлийн зардал нь тэдгээр үйлдлийг зах зээлээр гүйцэтгүүлсэн үеийн үйлдвэрлэлийн зардлаас бага байх үед л пүүсүүд үйл ажиллагаагаа явуулж чадна.

Пүүсийн болон зах зээлийн трансакцийн харьцангуй зардал нь пүүсийн зах зээлд юуг үйлдвэрлэх, худалдах болон худалдан авахыг тодорхойлно. Мөн зардал өсч, нэмэлт дотоод үйлдлүүд зохион байгуулагдаж, хэрэгжсэнээр дээрх харьцангуй зардал өөрчлөгдөх ба энэ нь пүүсийн хэмжээг хязгаарлах гол хүчин зүйл нь байна. Нэгтгэн дүгнэвэл пүүсүүд зах зээлийн үйлдлийг бага зардалтайгаар явуулж, түүгээрээ хяналт, албадлага, хэрэгжүүлэлт зэрэг удирдах орчинг хангах цэг хүртэл үйл ажиллагаагаа явуулах буюу цар хүрээгээ тэлэх боломжтой байна.

Санхүүгийн систем

Капитал нь үйлдвэрлэлийн чухал хүчин зүйл бөгөөд түүнийг пүүс болон хувиараа аж ахуй эрхлэгчид ашиглах боломж нь тухайн улсын санхүүгийн систем хэр зэрэг ажиллаж байгаагаас хамаарч байдаг. Санхүүгийн систем ба эдийн засгийн өсөлт, хөгжлийн хоорондын харилцан хамаарлыг судалсан олон ажил байдаг ч дараахь ойлголтууд дээр нэгдсэн үр дүнд хүрсэн байдаг.

Санхүүгийн систем эдийн засгийн өсөлт, хөгжилд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Нэгдүгээрт, сайн ажиллаж буй санхүүгийн систем нь хадгаламжийг дэмжиж, хуримтлагдах таатай нөхцлийг бүрдүүлэн, хуримтлагдсан хөрөнгийг хамгийн үр ашигтай салбарт хуваарилах үүргийг гүйцэтгэнэ. Санхүүгийн сектор нь хадгаламжийн хүү болон хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж чадна. Өөрөөр хэлбэл санхүүгийн гүнзгийрлийг (financial deepening) бий

болгож чадна. Банк болон хөрөнгийн зах зээл дээрх санхүүгийн зуучлал нь илүү томрох, үйл ажиллагаагаа илүү үр ашигтай түвшинд хүргэх зорилготой яваа пүүсүүдийг хамгийн тохиромжтой нөөцтэй холбох, нэгтгэх үйл ажиллагааг явуулах ёстой. Эдгээр зуучлал нь мөн хөрөнгийн хөрвөх чадвараас шалтгаалан гарч ирэх урт хугацаатай төслүүдийг санхүүжүүлэх суваг болж өгдөг.

Хоёрдугаарт, мэдээллээр хангах болон төслүүдийг үнэлэх үйл ажиллагаа байна. Эдгээр үйл ажиллагааг хувь хүний түвшинд олж авах, ойлгоход өндөр зардалтай байдаг бол санхүүгийн зуучлагчдын хувьд өргөжилтийн үр өгөөж болон дадлага туршлагаасаа үр ашиг олж болох үйл ажиллагаа болдог тул аль аль талдаа ашигтай зүйл байдаг.

Гуравдугаарт, хөрөнгө оруулагчийн санхүүгийн нөөцийн боломж бага байсан ч гэсэн зөвхөн ганц-төслийн (single-project) хөрөнгө оруулалтад гарч ирдэг хувийн онцлогтой эрсдлээс хамгаалах, түүнийг шийдвэрлэх үүргийг гүйцэтгэх ёстой. Өөрөөр хэлбэл, эрсдэл нь өндөр үнэтэй, олон хэлбэртэй, харилцан үйлдэлтэй ч өндөр үр өгөөжтэй төслүүдийг санхүүжүүлж болно.

Эцэст нь, санхүүгийн зуучлал нь пүүсийн менежерийг хянаж, өөр эх үүсвэрийн өндөр зардалтай, шаардлагатай мэдээллийн асуудлыг нь шийдвэрлэж өгч байдаг.

Санхүүгийн системийн үүрэг гэсэн ойлголтод банк болон хөрөнгийн зах зээлийн харьцангуй давуу тал нэлээн чухал асуудал байдаг. Санхүүгийн хөгжлийн доод түвшинд санхүүгийн системийн хэлбэр нь тухайн хэлбэрийнхээ гадаад санхүүжилтэд нөлөөлж байдаг. Жишээ нь, үнэт цаасны зах зээл хөгжсөн байвал пүүсүүдийн хувьд урт хугацаат, тогтвортой гадаад санхүүжилтээр хөгжих хандлага ихсэж ирдэг. Ер нь үнэт цаасны зах зээл нь урт хугацааны

санхүүжилтэд илүү тохиромжтой байдаг бол банкны сектор нь богино хугацаатай санхүүжилттэй нягт холбоотой байдаг^m.

3.3 ИНСТИТУЦИЙН ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дуглас Нортын тодорхойлсноор институци нь “хүмүүс бий болгодог хязгаарлалтууд буюу... хүмүүсийн улс төр, нийгэм болон эдийн засгийн аль алиных нь солилцоог өдөөгч, дэмжигч бүтэц” (North 1990, хуудас 3) юм. Хязгаарлалтаар тодорхойлогдож байгаа институцийн энэ ойлголтод солилцоог хөнгөвчилж түүнд тусалдаг гэдэг нь хамгийн чухал байдаг.

Тэгвэл институци чухам юу хийдэг вэ? Ямар хэлбэрээр солилцоо болон өсөлтөд нөлөөлж байдаг вэ? Дараахь байдлаар институцийн гүйцэтгэдэг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлж Монгол Улсад эдгээр хүчин зүйлийн нөлөөг судлах болно.

3.3.1 Дүрэм, журмыг бий болгож, хэрэгжүүлэх

Хувь хүний төлөв байдал, шийдвэр гаргалт хамгийн үр ашигтай гарцад хүрч чадахгүй байгаа үед институци нь хувь хүний хувьд боломжтой сонголтуудын олонлогийг хязгаарласнаар хамгийн үр ашигтай гарцад хүрэхэд нь дэмжлэг үзүүлж чаддаг. Жишээ нь, олон тэнцвэр, нийгмийн бараа, дам нөлөө, “шоронгийн зарчим” гэсэн ойлголтуудаар тайлбарлагддаг нөхцлүүд үүнд хамаарна. Дүрэм, журмыг бий болгож, тэдгээрийг зөрчвөл илүү зардалтай учирна гэдгийг тодорхойлж байх нь институцийн гүйцэтгэвэл зохих хамгийн чухал үүрэг байдаг.

3.3.2 Мэдээлэл болон таашаалыг нэгтгэх

Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хангамж эсвэл хэрэглээ нь нийгмийн бараа болон

дам нөлөөг агуулдгаас маш олон ялгаатай шинж чанартай болдог. Энэ нь зах зээлийн механизм үр ашигтай гарцын хэмжээнд хүргэх явцыг хэцүү болгодог. Хувийн болон нийгмийн хожоо маш ядмаг хоршдог, мөн хувийн үзэл бодол, онцлог нь тэдгээрийн бодит таашаалыг илрүүлж тодорхойлох идэвх чармайлтад саад болдгоос дээрх үр дүн гарч байж болох юм. Энэ тохиолдолд институци нь мэдээллийг нэгтгэснээр ганц сонголтонд хүргэдэг. Үндэсний парламент, ерөнхий ассемблей зэрэг нь дээрх үүргийг гүйцэтгэх институци (байгууллага) юм.

3.3.3 Эрсдлийг хуваарилах ба тодорхой бус байдлыг бууруулах

Институци нь эрсдэл хуваарилдаг механизм гэдгээрээ хамгийн чухал ойлголт болдог. Институци нь өдөр тутмын харилцан үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ингэснээрээ тодорхой бус байдлыг бууруулж, бүлгүүд болон хувь хүмүүст олон чухал хэрэгцээтэй солилцоог хийх боломжит эх олонлог болон өргөжих боломжийг олгож байдаг. Тодруулбал институци нь бүлгийн гишүүдийн хооронд эрсдэл хэрхэн хуваарилагдахыг шийдвэрлэдэг гэсэн үг. Жишээ нь, нийгмийн халамж болон ажилгүйдлийн даатгалын системийг дурдаж болно.

3.3.4 Хүчин зүйлсийн ашиглалтыг оновчтой болгох

Институци нь хувь хүний хүчин чадлууд болон нөөцийг нэгтгэн, хувь хүмүүс ганцаараа хийх боломжит байдлыг нэмэгдүүлснээр нийгмийн үйлдвэрлэлийн хэмжээг өсгөдөг.

3.3.5 Нөөцийг дахин хуваарилах

Зах зээлийн гарцад оролцож чадахгүй байгаа нөөцийн хуваарилалтыг өөрчлөх зорилгоор институцийг бий болгож болдог.


Институцийн энэ үүрэг нь дээрх бүлгүүдэд анхаарах нийгмийн итгэл, үнэмшил, үзэл бодлоор илэрхийлэгддэг. Жишээ нь, тэтгэвэрт гарсан хүмүүс, ажилгүйчүүдийн тэтгэмжийн зохицуулалтыг дурдаж болно.

Институци нь албан ёсны болон албан бус гэсэн шинж чанартай байдаг. Албан ёсны хэлбэртэй институци нь тодорхой хязгаарт хэрэгжих өөрийн гэсэн хэллэгээр ойлгомжтой, нарийн тодорхойлогдсон дүрэм журмын олонлог байдаг. Тэгвэл нөгөө эсрэг туйлын хэлбэр албан бус институци нь нийгмийн дадал хэвшил, төлөв байдлыг хөгжүүлэх, тухайн нийгэм нийтээрээ даган биелүүлэх явдал байдаг.

Институци, байгууллага хоёрын ялгааг зөв тодорхойлж, ойлгох нь чухал. Байгууллага нь өөрийн гишүүдийн хүсэл сонирхол дээр тулгуурласан, маргаангүй тов тодорхой зорилготой байдаг бол институци нь ерөнхийлөн туслагч, үйлчилдэг механизм гэдгээрээ хамаагүй илүү өргөн утгатай ойлголт байдаг. Өөрөөр хэлбэл, корпораци нь байгууллага бол корпорацийн тухай хууль нь корпораци, засгийн газар болон хувь хүний сонирхлыг хөгжүүлэгч, амжилтанд хүргэгч институци байна.

Институци хэрхэн эдийн засгийн өсөлтөд нөлөөлдгийг Зураг 3.1. схемээр нэгтгэн харууллаа.

Зураг 3.1. Эдийн засгийн өсөлт дэх институцийн нөлөө (нэгтгэсэн байдлаар харуулав)



4. Монгол дахь институцийн хөгжил

Институци бүхэлдээ аливаа улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлдогийг бид дээрх бүлгүүдэд үзсэн байгаа. Эдийн засгийн эрх чөлөөтэй шууд холбоотой институцийн хөгжлийн үзүүлэлтүүд бол *засаглалын чанар ба зохицуулалтын дарамт, өмчийн эрх, гэрээний биелэлт, трансакцийн зардлууд юм.* Монголд бизнесийн үйл ажиллагааг явуулахад институцийн чанар үлэмж нөлөөтэй байгаа. Үүнд:

- төрийн зохицуулалтын дагуу ажиллах; эрх зүйн орчинд зохицсон үйл ажиллагаа явуулах;
- хувийн өмчтэй болох;
- бусад компани, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийх.

Үйл ажиллагааны шат болгонд бизнес зардал, чирэгдэл багатай, төрийн дарамтгүй, оновчтой зохицуулалтын бодлоготой, төрийн байгууллагуудын үйлчилгээ нь чанартай, шуурхай байвал хууль, журам чанд хэрэгжин бизнес, хувийн өмчийн эрх хамгаалагдаж, гэрээний биелэлтийн сахилга батыг баталгаажуулдаг трансакцийн зардал бага байвал хувийн хэвшил хөрөнгө, мөнгө, цаг, бололцоогоо зөвхөн бизнесээ хөгжүүлэх үйл ажиллагаанд төвлөрүүлж, тэр хэмжээгээр түүний өсөлт, хөгжил нь түргэн явагдах болно. Эсрэг тохиолдолд хувийн хэвшлийн өсөлт, хөгжил нь удааширч, тэр нь нийтдээ улс орны эдийн засгийн өсөлтийг сааруулах нь ойлгомжтой.

4.1 ТӨРИЙН ЗАСАГЛАЛ

Нобелийн шагналт эдийн засагч Д. Норт “Улс төр, институци нь өмчийн эрхийг хамгаалж, гэрээ, хэлцлийн биелэлтийг хэрэгжүүлэх гол арга зам, нөөц, боломжийг олгож... зах зээлийн үр өгөөжийг тодорхойлдог”¹ гэжээ. Төр муу бол зах зээлийн үр өгөөж буурах болно.

Аль нэг улсын институци гэдэг нь тухайн орны засгийн эрх хэрэгжүүлдэг байгуулал болон уламжлалт төрийн тогтолцоо ба үүнийг өргөн утгаар нь засаглал гэж тодорхойлдог. Энэ утгаар засаглал гэсэн ойлголтод төр, засгийн газрыг сонгох, хянах болон солих процесс, төр, засгийн газрын бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадвар, төрийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог хүндэтгэх, тэдгээрийн хоорондох эдийн засаг, нийгмийн харилцаанууд бүгд ордог. Иймээс засаглал гэдэг ухагдахуун нь төр, засгийн үйл ажиллагааны чанар, нээлттэй байдал, үр өгөөжийг харуулдаг.

Эдийн засаг дахь засаглалын нөлөө асар хүчтэй байдгийг Дэлхийн банкны судалгаа баталсан байдаг. Нэг хүнд ногдох бодит орлого болон засаглалын чанарын хооронд маш хүчтэй хамааралтай хэмээн тайланд тусгасан байна. Улс орнуудын практик ч үүнийг харуулж байгаа бөгөөд доогуур орлоготой, буурай орнуудын хувьд засаглалын чанар муу байдаг нь тогтоогджээ. Эсрэгээр, аль нэг улсын засаглалын чанар доод түвшнээс дундаж түвшинд хүрэхэд тухайн улсын хүн амын орлого 4 дахин өсөж, эрүүл мэнд болон боловсролын үзүүлэлтүүд нь сайжирна гэсэн дүгнэлт гарсан.

Сайн засаглал эдийн засгийн өсөлтийн суурь болдог нь богино хугацаанд ч харагддаг. Дэлхийн банкны судалгаагаар өнгөрсөн 10 жилд илүү сайн засаглалтай орнууд илүү өндөр хурдацтай өсч байсан нь батлагдсан.

Доорх зурагт тэдгээр 6 үзүүлэлт ба нэг хүнд ногдох орлогын (худалдан авах чадварын паритетээр хэмжсэн) хоорондох хамаарлыг харуулж байгаа ба бүх тохиолдолд хамаарал эерэг байгаа нь харагдаж байна. Ерөнхийдөө засаглалын индикаторын түвшин өндөр байх тусам нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ (худалдан авах чадвараар) өндөр байдаг. Жишээ нь, аливаа орон улс


төрийн хувьд тогтвортой, ардчилал хөгжсөн, хууль нь хэрэгждэг, төрийн үйл ажиллагаа чанар сайтай болон үр ашигтай, тухайн улсад авилга газар аваагүй тохиолдолд хүмүүсийн амьжиргааны түвшин өндөр байна гэсэн үг. (Зураг 4.1.)

Дэлхийн Банкнаас улс орнуудын засаглалын чанарыг илэрхийлэх зорилготой гаргадаг индикаторууд засаглалын чанарыг үндсэн 6 талбарт хэмждэг. Үүнд:

- Үг хэлэх эрх ба хариуцлагатай байдал нь улс төр, соёлын болон хүний эрхийг хэмждэг.

- Улс төрийн тогтворгүй байдал болон хүчирхийллийн талбар нь терроризм, хүчирхийлэлд өртөх эсвэл Засгийн газрын солигдох магадлалыг хэмждэг.
- Засгийн газрын үр ашиггүй байдал нь хүнд суртал болон төрийн үйлчилгээний чанарыг хэмждэг.
- Зохицуулалтын дарамт нь төрийн бодлогын зах зээлд учруулж буй дарамтыг хэмждэг. Хуулийн хэрэгжилтийн талбар нь шүүх, цагдаа, гэрээний хүчин төгөлдөр байдлын чанарыг хэмждэг.

Зураг 4.1. Засаглал ба хүн амын амьжиргаа



Эх сурвалж: Кауфман, Край, Лондо, Дэлхийн Банк, 1999. Хэвтээ тэнхлэг нь засаглалын үзүүлэлтийн хэмжээ, босоо тэнхлэг нь нэг хүнд ногдох ДНБ (худалдан авах чадвараар тооцсон)-ий өсөлтийн хувь.

- Авилгын талбар нь төрийн эрх мэдлийг хувьдаа завших байдлыг хэмждэг.

Засаглал бол эдийн засгийн өсөлтийн цорын ганц хүчин зүйл биш боловч түүнд хүчтэй нөлөөлж, хамгийн гол нь түүнийг өөрчилж, сайжруулж болдгоороо чухал юм. Үүгээрээ засаглал нь түүхий эдийн нөөц, газар зүйн байршил болон бусад байгалийн хүчин зүйлсээс ялгаатай юм. Монголын хувьд газар зүйн байршилыг өөрчлөх, далайд гарцтай болох нь хэцүү боловч засаглалыг сайжруулах замаар хүн амын амьжиргааг сайжруулах боломж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Гэтэл Монголын засаглалын үзүүлэлтүүд маш хурдацтай дордож байна.

Төрийн байгууллагад ажиллах хүмүүсийг чадвараар нь биш аль улс төрийн бүлэгт хамаарч байгаагаар нь томилж байгаа гаж үзэгдэл нэгэнт зуршил болжээ. Улс төрийн намууд өөрийн санхүүжүүлэгч компаниудад яам, албан газруудад зориулан албан тушаалуудыг шинээр бий болгож байна. Түүнээс гадна намууд томилсон сайдууд яам дотроо болон төрийн өмчийн байгууллагуудад өөрийн хүмүүсээ томилж байна.

Төрийн институци бэхжих боломж цаг хугацааны хувьд ч боловсон хүчний хувьд ч бүрдэхгүй байна. Зөвхөн дөрвөн жилтэй, ихэнхдээ түүнээс богино хугацаатай уралдаж хөлжих ажилтай тул урт болон дунд хугацааны бүх ажил бараг хийгдэхгүй байна. Үүний хамгийн сүүлчийн жишээ бол алт, зэс болон бусад байгалийн баялгийн олон улсын зах зээлийн үнийн өсөлтийн дүнд орж ирсэн орлогыг үнэ бага болоход хэрэг болохоор тооцон хүмүүсийн ирээдүйд, дэд бүтэц болон боловсролын чанарыг дээшлүүлэхийн оронд шинэ төрсөн хүүхэд, шинээр гэр бүл бологсод бэлэн мөнгө хэлбэрээр олгож байна. Төр засгийн газрын дарга, сайд нар, агентлаг, газрын дарга нар гэр бүлийн болон хамаатан садныхаа нэр

дээр ашигт малтмалын лиценз зөвшөөрлийг авах, дамлах ажил хэвийн үзэгдэл боллоо.

Монголын төрийн засаглалын чанар ийнхүү дордож байгааг Дэлхийн банкны засаглалын судалгааны дүнгээр батлаж болно. Хамгийн сүүлийн үеийн байдлаар “Governance Matters IV: Governance Indicators for 1996-2004” тайлан¹⁵ гарсан. Энэ тайланд дэлхийн 209 орны засаглалын нийт үзүүлэлтийг 1996, 1998, 2000, 2002, 2004 онуудаар хэмжин харуулсан. Талбар тус бүрт улс орнуудын засаглалын чанарыг хоёр индексээр харуулсан. Эхнийх нь үнэлэгдсэн индекс /estimate/¹⁶.

Монгол улсын хувьд засаглалын чанарыг хэрхэн хэмжигдсэнийг дараахь хүснэгтэд нэгтгэн харуулья. Уг үзүүлэлтийг Дэлхийн Банк 1996-2004 хооронд тооцоолсон байна. (Хүснэгт 4.1.)

Эдгээр үзүүлэлтийг авч үзэхэд засаглалын 6 үзүүлэлтээс Монголын 4 үзүүлэлт өнгөрсөн 8 жилд муудсан нь ихээхэн түгшүүртэй дүн юм. Монгол улсын хувьд засаглалын чанарыг 6 талбарт хэмжсэнээс хамгийн бага үнэлгээтэй нь 3-р болон 6-р талбар буюу **засгийн газрын үр ашиг, авилга** хоёр байна. Энэ индекс нь сөрөг гарсан байна. Мөн хуулийг дээдлэх ёс, засгийн газрын үр ашгийн үзүүлэлтүүд эрс буурсан нь харагдаж байна.

Энэ нь манай улсын төр үрэлгэн, үр ашиггүй, төрийн үйлчилгээний чанар муу, хүнд сурталжсан бөгөөд төрийн албаны бүх

¹⁵ Уг индексийг Дэлхийн Банк 1996 оноос эхлэн гаргасан бөгөөд голлон боловсруулагчид нь Д.Кауфман (Daneil Kaufmann), А.Край (Aart Kraay), М.Маструцци (Massimo Mastruzzi) нар юм. Эдгээр индексийн тооцоонд олон байгууллагын янз бүрийн өгөгдлийн эх үүсвэр ашиглагддаг.

¹⁶ Энэ нь хамгийн ихдээ +2.5 ба энэ утга руу дөхөх тусам засаглалын чанар сайн байгааг илтгэнэ. Харин -2.5 руу ойртох буюу ер нь сөрөг дүнтэй гарвал засаглалын чанар муудаж байгааг харуулах ба хамгийн муудаа -2.5 болно. Энэ индекс нь олон эх үүсвэрээс тооцсон дундаж индекс юм. Хоёрдугаарт нь засаглалын чанарын талбар бүрт авч буй утга нь бусад улс оронтой харьцуулахад ямар байгааг хувиар илэрхийлсэн /percentile rank/ индекс юм. Засаглалын чанар хамгийн сайн улс 100 оноо авах ба хамгийн муу үнэлэгдсэн улсын хувьд 0 байх юм. Энэ бол 100 улсын жагсаалтад эзлэх байр гэж үзэж болно.

Хүснэгт 4.1. Монгол Улс: Засаглалын үзүүлэлт

Үг хэлэх эрх ба Хариуцлагатай байдал <i>Voice and Accountability</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	0.38	0.62	0.73	0.44	0.45
Percentile Rank (0-100)	62.8	66	68.1	63.1	59.7
Улс төрийн тогтворгүй байдал ба Хүчирхийлэл <i>Political Stability</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	0.8	0.52	0.99	0.95	0.48
Percentile Rank (0-100)	74.4	66.7	80	80	61.2
Засгийн газрын үр ашигтай байдал <i>Government Effectiveness</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	-0.27	0.02	0.15	-0.19	-0.46
Percentile Rank (0-100)	48	60.7	60.2	54.2	36.5
Зохицуулалтын чанар, дарамт <i>Regulatory Quality</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	-0.57	0.27	0.37	-0.1	0.18
Percentile Rank (0-100)	24.3	56	64.7	50	57.6
Хуулийн хэрэгжилт <i>Rule of Law</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	0.48	0.02	0.22	0.34	0.18
Percentile Rank (0-100)	70.5	61.6	62	63.8	56.5
Авилгын Хяналт <i>Control of Corruption</i>	1996	1998	2000	2002	2004
Estimate (-2.5 to + 2.5)	0.37	-0.28	-0.21	0.11	-0.51
Percentile Rank (0-100)	66	53	50.5	59.7	39.9


Эх сурвалж: «Governance Matters IV: Governance Indicators for 1996-2004», Дэлхийн Банк

шатанд авилга, хээл хахууль газар авсан гэдгийг харуулж байгаа бөгөөд энэ явдал эргээд засаглалын чанарын бусад үзүүлэлтэд ч сөргөөр нөлөөлөх нь ойлгомжтой. (Зураг 4.2.)

Ерөнхий дүнгээр 6 талбарт хэмжиж нэгтгэсэн засаглалын чанар манай улсын хувьд сүүлийн жилүүдэд буурсан байгааг дээрх хүснэгтийн мэдээлэл илтгэж байна. Засгийн газрын үр өгөөж нь сүүлийн үед -0.27-оос -0.46 болж муудсан байна. Монгол улсын хувьд энэ байдал нь улс орны хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй.

Эдгээр үзүүлэлтийг харьцуулан үзэхэд Монгол Улсад хэрэгжиж байгаа бодлого, хуулиуд ерөнхийдөө зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж, бизнес, худалдаа, банк санхүүгийн салбарыг чөлөөтэй болгох хандлагатай байгаа боловч *нэгдүгээрт*, төрийн аппарат нь улс төрийн дарамтад орсон, үр ашиг муутай, хүнд сурталтай ажилладаг, *хоёрдугаарт*, хуулийн хэрэгжилт ихээхэн дордсон, авилга өссөн (хуулийн хэрэгжилт нь 0.48-аас 0.18 болж буурсан, авилгын байдал 0.37-оос бүр хасах тэмдэгтэй -0.51 болж ихээхэн муудсан) байдлаас болж

Зураг 4.2. Монгол Улсын засаглалын чанарын өөрчлөлт, 1996-2004



Эх сурвалж: Дэлхийн Банк

нийтдээ Монголын засаглал дордож байна гэсэн дүгнэлтэд хүрч болох юм. Үүнээс болж төрийн зохицуулалтын дарамт ихсэж байна.

Монгол Улсын хөгжилд хувийн хэвшил ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа тул цаашид төр засгаас аль болохоор бизнесийн харилцааг албан журмын дагуу явуулахыг хялбар болгох нь эдийн засгийн хөгжлийг түргэтгэх боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Бэрхшээлээс зайлсхийхийн тулд голдуу албан бус аргыг (хээл хахууль, танил тал г.м) ашигладаг байна. Энэ нь нэг талаас авилга бий болгож, нөгөө талаас өрсөлдөөнийг шударга бус болгож байна. Улс төрийн томилолтоор яам, агентлагт томилогдсон хүмүүс нэгэнт улс төрийн болон өөрийн хувийн бизнесийн даалгавартай

ирж байгаа учир өнгөн дээрээ төрийн ажил хийсэн дүр эсгэж, үнэн хэрэгтээ улсын нэрээр хувийн болон бүлэглэлийнхээ ашиг хонжоог хөөцөлдөх боллоо. Нэгэн компаний эзэн төрийн бодлого хэрэгжүүлэгч сайдынхаа компанитай өрсөлдөхөд хэцүү байдаг гэж олон улсын хурал дээр хэлж байна.

МҮХАҮТ-аас 2004 онд явуулсан Монголын эдийн засаг бизнесийн орчны судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 62,8 хувь нь засгийн газрын албан тушаалтнуудтай харьцах хамгийн дөт зам бол төрийн байгууллагад ажилладаг найз, нөхөд, хамаатан садныхаа туслалцааг авах, 21,6 хувь нь хариуцсан албан тушаалтанд хахууль өгөх, үйлчлэх,

тусламж үзүүлэх явдал гэсэн бол дөнгөж 15,7 хувь нь л албан ёсоор үйл ажиллагаа явуулах нь хялбар гэж хариулсан байна. Мөн “судалгаанд оролцогсдын 38.7 хувь нь татварын хяналт шалгалт их байдаг нь нилээд хүндрэл учруулдаг гэсэн бол 36.6 хувь нь татварын хураамж өндөр, 26.8 хувь нь татварын тоо төрөл олон байдаг нь хүндрэл учруулдаг гэжээ. Мөн 42.1 хувь нь татвартай холбоотой хууль тогтоомж байнга өөрчлөгддөг, 33.3 хувь нь татварын тайлан гаргах журам, зааврыг мөрдөхөд, 22.2 хувь нь өрсөлдөгчид нь шударга бусаар татварын хөнгөлөлт эдэлдэг нь бага зэрэг хүндрэл учруулдаг гэсэн байна.”

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс авсан санал асуулгаас харахад лиценз, зөвшөөрөл авах, зөвшөөрөл олгодог байгууллагын ажлын зохион байгуулалт нь тэдгээр аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн болон цаг хугацааны хувьд нэлээдгүй саад бэрхшээл учруулдаг гэжээ. Монгол улсын бизнесийн хөгжилд саад болж буй гол хүчин зүйлүүдэд татварын тогтолцоо, авилга, шударга бус өрсөлдөөн гэх мэтийг аж ахуйн нэгжүүд хамгийн их нэрлэжээ: “Судалгаанд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ихээхэн хамааралтай хууль тогтоомжууд аж ахуйн үйл ажиллагаанд хэр зэрэг хүндрэл бэрхшээл учруулдаг талаар тодруулан асууж зэрэглэн үзэхэд хамгийн хүндрэлтэй хууль нь татварын хууль тогтоомж гэж судалгаанд оролцогсдын 80.5 хувь нь, лиценз, тусгай зөвшөөрлийн талаар хууль тогтоомжийг 71.8 хувь нь, гаалийн хууль дүрмийг 63.3 хувь нь нэрлэсэн байна. Маш их хүндрэлтэй хуулийн тоонд судалгаанд хамрагсдын 15.4 хувь нь лиценз, тусгай зөвшөөрлийн, 12.2 хувь нь татварын хууль, 10.0 хувь нь гаалийн хууль гэсэн бол нилээд хүндрэлтэй хуулийн тоонд мөн л татварын (31.7%), лиценз, тусгай зөвшөөрлийн (23.1%), гаалийн (20.0%) хууль ордог байна.”

Татварын хураамж өндөр, хяналт шалгалт их, байцаагчдын харьцаа муу зэрэг татвартай холбоотой асуудлууд бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг болох нь судалгаагаар тогтоогджээ. Ихэнх хяналт, шалгалтыг явуулж буй байцаагчдын зорилго нь төрийн хууль, дүрэм журмын мөрдөлтийг хянахаасаа илүүтэйгээр цалин хөлсний нэмэгдэл, урамшууллаа өсгөхийн тулд төрийн эрх мэдэл бүхий байгууллагын албан хаагчид нэмэлт төлбөр, хураамж, торгуулийг оногдуулахыг эрмэлзэх нь түгээмэл байгаа билээ. Жишээ нь татварын нэгжүүд 1 жилийн дотор тийм хэмжээний татварын орлогыг төсөвт оруулна гэсэн төлөвлөгөөтэй ба төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн тохиолдолд шагналт цалин урамшуулал өндөр байдаг байна. Үүнийг бидний хийсэн жишээний судалгаа ч мөн харуулж байгаа юм.

4.2 МОНГОЛЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Монголын засаглалын чанарыг харуулсан өөр нэг индекс бол Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс юм. Энэ нь мөн олон төрлийн дэд индексийг агуулдаг бөгөөд нэг онцлог нь технологи, макро эдийн засгийн бодлогод анхаардаг ба тодорхой хэсэг нь төрийн байгууллагуудын индекс байдаг. Дэлхийн Эдийн Засгийн Форум (ДЭЗФ) хэмээх нэр хүндтэй олон улсын байгууллага анх 1971 онд Швейцар улсад байгуулагдсан бөгөөд олон улсыг хамарсан нийгэм-эдийн засгийн судалгаа хийдэг. ДЭЗФ мэдээллийн технологи, жендерийн байдал, Арабын орнуудын өрсөлдөх чадвар зэрэг сэдвээр судалгаа хийсэн бөгөөд хамгийн том нь Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан юм.

Анх 1979 онд уг судалгааг 16 улсыг хамруулан хийж эхэлсэн бөгөөд 2005 оны байдлаар 117 орныг хамарч байгаагийн дотор Монгол Улс анх удаа багтсан юм.

Уг судалгааг дэлхийн алдартай судлаач, эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэдэг бөгөөд 2005 оны тайланг бэлтгэхэд уг байгууллагын түнш болох дэлхийн 122 байгууллага оролцсон. Монгол улсаас энэхүү байгууллагын түнш байгууллагаар Нээлттэй Нийгэм Форум ажиллаж байна.

Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан эдийн засгийн өсөлт ба хөгжил цэцэглэлтийн гол бүтэц бүрэлдэхүүний талаарх бидний ойлголтыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж, аливаа эдийн засгийн давуу ба сул талуудыг тодруулж өгснөөрөө эдийн засгийн бодлого ба институцийн шинэчлэлийг сайжруулан томъёолоход тус дөхөм болохуйц нэг чухал арга хэрэгслийг бодлого боловсруулагчид, бизнесийн тэргүүлэгчдэд санал болгож байдаг.

2001 оноос хойш ДДӨЧ-ын тайлангийн арга зүй Дэлхийн Эдийн Засгийн Форумд зориулан Жеффри Сакс, Жон МакАртур нарын боловсруулсан Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс (ӨӨЧИ буюу GCI) хэмээх загварт тулгуурлаж байгаа. Өрсөлдөх чадвар сайтай эдийн засаг дундаас урт хугацаанд илүү хурдан өсөх магадлалтай гэж үздэг ба ӨӨЧИ нь өрсөлдөх чадварыг хэмжих хязгаарыг тодорхойлох зорилготой хэд хэдэн нэмэлт ойлголтыг нэгтгэдэг. Энэ загварт аливаа орны өсөлтийн өөрчлөлт, хөгжлийг тайлбарладаг хүчин зүйлсийг томъёолохдоо “гурван тулгуур” тогтоодог. Үүнд:

- *макро эдийн засгийн орчны чанар,*
- *тухайн улсын төрийн байгууллагуудын байдал,*
- *технологи ба шинийг санаачлахын ач холбогдлыг харгалзан технологийн бэлэн байдлын түвшин* гэсэн гурван үзүүлэлтэд тулгуурлаж байна.

ӨӨЧИ-д их, дээд сургуульд хамрагдалтын хувь, инфляцийн түвшин, төрийн санхүүгийн байдал, хөдөлгөөнт холбоо, интернет гэх мэт шинэ технологи нэвтрэлтийн түвшний

тогтсон тоон үзүүлэлтийг Дэлхийн Эдийн Засгийн Форумын Бизнесийн удирдлагаас авсан судалгааны тоон мэдээлэлтэй хослуулан ашигладаг. Энэхүү санал асуулгаар авсан тоон мэдээлэл нь голдуу тогтсон тоон үзүүлэлт байдаггүй боловч эдийн засгийн өсөлтийг бий болгогч хүчин зүйлсийг зохих ёсоор ойлгоход гол үүрэгтэй зарим ойлголтыг олж мэдэхэд тусалдаг. Ийм ойлголтын жишээнд шүүхийн хараат бус байдал, институцичилэгдсэн авилгын тархалт, эдийн засаг дахь төрийн үр ашиггүй оролцооны цар хүрээ гэх мэтийг оруулж болох юм.

Эдгээр янз бүрийн жижиг хэсгийг өөр өөр дэд индексүүдэд нэгтгэн оруулсан бөгөөд дор бүрнээ өсөлтийн үйл явцын өөр өөр талыг (тухайлбал, гэрээ, эрх зүйн ач холбогдол, макро эдийн засгийн орчны тогтвортой байдал гэх мэт) харуулахын зэрэгцээ тэдгээрийг өрсөлдөх чадварын нийт “индекс”-т нэгтгэн оруулдаг.

Бизнесийн өрсөлдөх чадварын индекс (БӨЧИ) нь улс орнуудын эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварын өнөөгийн тогтвортой түвшнийг тодорхойлдог микро эдийн засгийн далд хүчин зүйлсэд голлон анхаардаг бөгөөд улмаар дээр дурдсан ӨӨЧИ-ийн алс хэтийг харсан макро эдийн засгийн хандлагад нэмэлт болж өгдөг. Аливаа баялаг үнэн хэрэгтээ тухайн эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын түвшинд бий болдог учраас үндэсний өрсөлдөх чадварт микро эдийн засгийн хүчин зүйлс шийдвэрлэх үүрэгтэй гэсэн үзэл санаанд БӨЧИ тулгуурладаг. БӨЧИ нь аливаа эдийн засаг дахь бизнесийн микро эдийн засгийн орчинд нэн чухал үүрэгтэй компаниудын үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдал болон тэдний үйл ажиллагаагаа явуулж буй үндэсний бизнесийн ерөнхий орчны чанар гэсэн хоёр чиглэлийг онцгойлон хэмждэг.

Засаглалын ач холбогдлыг тогтоох шууд

арга бол пүүс компаниуд болон өрхүүдээс асуулга авах явдал юм. Үйлдвэрийн газруудын хувьд энэхүү судалгааны төгсгөлд орсон нийлмэл асуулгаар гол санааг гаргасан бөгөөд энэ нь 14 боломжит хүндрэл бэрхшээл бүхий урт жагсаалт байх ба тэдгээрийн үзүүлж буй дарамт шахалтынх нь ач холбогдлоор эрэмбэлэхийг санал асуулгад оролцогчдоос хүсдэг. Энэ асуултын үр дүнгээс үзэхэд ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын компаниудын бизнест хамгийн хүндрэлтэй асуудал нь хөдөлмөрийн зохицуулалтууд, хүнд суртал, татварын ачаалал байдаг бол шинээр төрөн гарч буй эдийн засагтай орнуудын компаниудад хамгийн хүндрэлтэй нь хүнд суртал ба авилгын дарамт байдаг байна.

Уг тайлангийн судалгаанд оролцсон Монголын бизнес эрхлэгчид Монгол улсад бизнес эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулдаг хүчин зүйлсийг дараахь байдлаар дүгнэсэн байна. Үүнд (нэрлэсэн дэс дараагаар):

- Засгийн газрын хүнд суртал
- Дэд бүтцийн хангамж сул
- Татварын хэмжээ
- Авилга
- Татварын зохицуулалт
- Санхүүжилт авах боломж
- Ажиллах хүчний боловсрол хангалтгүй
- Үндэсний ажиллах хүчний ёс зүй сул

Эдгээрийн дотроос засгийн газрын үр ашиггүй үйл ажиллагааг хамгийн ихээр бэрхшээл учруулдаг, мөн нөгөө талдаа бизнес эрхлэхэд саад тотгор учруулж байгаа гол хүчин зүйлийн нэг нь авилга байгаа нь Монголын засаглал хөнгөн шуурхай, шударга, ил тод бус байгааг илэрхийлж байгаа томоохон үзүүлэлт юм.

Өсөлтийн өрсөлдөх чадварын хувьд Монгол улс дэлхийн нийт 117 орноос 96

дугаар байранд орсон нь нэлээд чамлалттай үзүүлэлт болж байна. Үүнийг задалж авч үзвэл:

Макро эдийн засгийн орчин	105
Макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс	94
Засгийн газрын үргүй зардлын дэд индекс	109
Улсын зээлжилтийн зэрэглэлийн дэд индекс	97
Төрийн байгууллагууд	93
Гэрээ, эрх зүйн дэд индекс	81
Авилгын дэд индекс	96
Засгийн газрын албан тушаалтнуудын шийдвэрт тал тохой татах байдал	107
Өмчийн эрхүүд	83
Технологи	81
Шинийг санаачилгын дэд индекс	53
МХТ-ийн дэд индекс	81
Технологи шилжүүлэлтийн дэд индекс (92 үндсэн бус шинийг санаачлагчдаас)	55

Энэхүү тайлан дахь Монгол улсын сул талыг илэрхийлж буй үзүүлэлтүүдэд хууль сахиулах үйл явцын бизнест үзүүлэх нөлөө (117-р байр), хувьцаа эзэмшигчдийн цөөнхийн эрх ашгийг хамгаалж буй байдал (111-р байр), хууль эрх зүйн үр дүнтэй байдал (111-р байр), байгаль орчны зохицуулалтын хатуу чанга байдал (110-р байр), нүүс компаниудын ёс зүй (109-р байр) зэрэг орсон байна.

Бизнесийн өрсөлдөх чадварын индексээр 117 орноос 100 дугаар байранд орсон ба компаний үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдлаар 98, үндэсний бизнесийн орчны чанараар 102 дугаар байранд тус тус орсон байна. Ийнхүү Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс Монгол улсын эзэлсэн байрнаас мөн л засаглал,

түүний чанар, төр, засгийн газрын хувийн секторт явуулж буй бодлого таатай бус, бодит бус, тогтворгүй байгаа болон бизнес эрхлэгчид үүнд сэтгэл нилээд дундуур байгааг харж болох юм.

4.3 АВИЛГА

Авилга нь трансакцийн зардал буюу бизнесийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл юм. Учир нь ямар ч авилгагүй явагдах ёстой бизнесийн ажлыг хийхийн тулд авилгад нэмэлт зардал гаргах, хуулийг зөрчих шаардлагатай болдог. Төрийн зохицуулалт, шалгалтыг хэрэгжүүлэгчид авилгад хамрагдсан байдаг учир авилгад төлсөн хөрөнгө нь зардлыг өсгөж, үнийг хөөрөгдөнө, эсвэл бүтээгдэхүүний чанарт нөлөөлж хэрэглээний зардлын нэрлэсэн өртгийг нэмэгдүүлнэ. Хамгийн тодорхой жишээний нэг бол тэмдэглэлт ой, баяр наадам дөхөхөд ариун цэвэр, эрүүл мэнд, гал хамгаалалт, мэргэжлийн хяналт, нийгмийн даатгал, татварын шалгалтууд хорооны, дүүргийн, хотын, улсын, яамны, харьяа газрын агентлагаас бараг компани болгон дээр шил шилээ даран ирж “түрээсийн төлбөр”-өө авдаг явдал юм.

Түүнчлэн компаниуд тэмдэглэлт ойн баяраараа дээрх байгууллагуудын хамаарагчдад шагнал “хандивлаж” авилгачдыг найдвартай сайн түншээрээ баталгаажуулдаг байна. Нэгэнт авилга өгөөд амыг нь таглаж болох учир барилгын хайрганы оронд ухсан газрын шороогоор зуурмаг бэлтгэн, стандарт нь батлагдсан төмөр хийцийн оронд гэр хорооллын хашаанд хайлуулсан хуурамч төмрөөр тулгуур баганыг зангидах ч энүүхэнд болдог байна. Эцэст нь энэ бүгдийн үр дагаврыг хэрэглэгч бараг дангаараа үүрдэг нь нийгмийн түгээмэл үзэгдэл болсон.

Монгол дахь авилгын талаар сүүлийн үед хэд хэдэн судалгаа хийгдсэн бөгөөд тэдгээрээс товч танилцуулья.

ХБНГУ-ын Берлин хотноо төвтэй “Transparency International”(TI) байгууллага нь авилгатай тэмцэх зорилготой олон улсын хамгийн том төрийн бус байгууллага юм. Уг байгууллага нь Берлин хот дахь Олон Улсын Нарийн Бичгийн Дарга нарын Газар болон дэлхийн өнцөг бүр дэх 99 бие даасан Үндэсний Салбаруудаараа дамжуулан олон улсын ба үндэсний гэсэн хоёр түвшинд авилгын эрэлт, нийлүүлэлтийг хянаж, хязгаарлахын тулд ажилладаг.

Олон улсын хүрээнд TI нь авилгын хорт үр дагавар, бодлогын шинэчлэлийн дэмжлэг, олон улсын конвенцийн хэрэгжилт дэх анхаарлыг нэмэгдүүлэх, үүний дараа засгийн газар, пүүс компаниуд ба банкуудын даган мөрдөж байгаа байдлыг хянах үйл ажиллагаа явуулдаг. Үндэстний хүрээнд TI-ийн Үндэсний Салбарууд нь тухайн улсынхаа хариуцлагатай байдал болон ил тод байдлын түвшинг нэмэгдүүлэхийн тулд төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүнг хянах болон улс төрд хийх шаардлагатай шинэчлэлүүдийг хурдан шийдвэрлүүлэхийн төлөө ажилладаг.

TI-ийн үндсэн үйл ажиллагаа нь системийг хамгаалах болон шинэчлэхэд чиглэгддэг ба энэ зорилгодоо хүрэх гол арга нь иргэний нийгэм, бизнесийн нэгж болон засгийн газрыг хамтдаа хүчтэй глобал зөвшилцөлд хүрэх нөхцлийг хангах явдал гэж үздэг. Мөн авилгатай тэмцэх үндсэн арга нь мэдээлэл хүртэх, хэрэглэх байдал гэж үздэг.

TI нь ил тод байдал болон авилгын түвшинг тодорхойлох найдвартай тоон мэдээллээр хангахын тулд 1995 оноос эхлэн жил бүр “Авилгын индекс”-ийг тооцож ирсэн. Өнөөгийн байдлаар энэ индекс нь

ТИ байгууллагын хамгийн шилдэг аргачлал гэж тооцогддог ба дэлхийн 150 гаруй улс орныг хамарсан судалгаа болон өргөжсөн. Сүүлийн жилүүдэд ТИ нь СРІ(Авилгын индекс)-ийг сайжруулж “Хахууль өгөгчдийн индекс”-ийг тооцож эхэлсэн. Энэ индекс нь авилгын нийлүүлэлтийн талтай холбогдон, тухайн улс болон аж үйлдвэрийн салбарын эх үүсвэрээр түвшин нь тогтоогддог. Үүнээс гадна мөн “Дэлхийн авилгын хэмжүүр” гэсэн үзүүлэлтийг тооцдог болж байгаа ба энэ нь дэлхийн 60 гаруй улс орон дахь авилгыг нийгмийн зүгээс үзэх үзэл, туршлага дээрх судалгаанаас тооцогддог үзүүлэлт юм.

ТИ нь дээрх тооцоолол, судалгаа шинжилгээнүүд дээр үндэслэн жил бүр “Дэлхийн авилгын хэмжүүр” болон “Жилийн тайлан” зэрэг авилгын өнөөгийн байдал, олон улсын болон үндэстний хүрээнд ямар түвшинд байгаа, түүнтэй хэрхэн тэмцэх талаарх тайлан, бодлогын бичиг баримтуудыг хэвлэн гаргадаг.

Манай улсын хувьд ТИ-ийн Үндэсний Салбар^o байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 1999 онд анх уг байгууллагын аргачлалын дагуу гаргадаг авилгын индекс болох СРІ тодорхойлогдсоноос хойш 2004, 2005 онуудад дахин тооцогдсон байна. Уг индекс нь олон хүчин зүйлийг нэгтгэсэн нэгдмэл индекс юм. Жишээ нь 2005 оны СРІ нь 2003-2005 онуудын хооронд хийгдсэн, 10 бие даасан байгууллагын 16 судалгааны ажил^o, тоон өгөгдлүүдийг ашиглан тодорхойлсон. Эдгээр бүх эх сурвалж нь бүгд нэгэн адил “авилгын” гэсэн асуудал дээр төвлөрсөн байдаг.

СРІ-ийн зорилго нь улс орнуудад байгаа авилгын үнэн мөн чанарыг өргөн агуулгатайгаар илэрхийлэхэд шаардлагатай тоон өгөгдлөөр хангах явдал байдаг. Үүнийг тооцоход оролцдог эх сурвалжууд нь ялгаатай, олон учраас түүврийн бүтэц болон арга, аргачлал нь өөр өөр байдаг.

Бүх эх сурвалж нь авилгыг адилхан, нийтлэг нэг утгатайгаар тодорхойлох боловч төрийн ажилтан болон улс төрчдийн дунд байх авилгын “хэмжээ”-г тодруулах асуулт, хандлага нь ялгаатай байдаг. Сүүлийн үеийн тайлангуудад ашиглаж байгаа эх сурвалжууд дахь авилгын “тархалт-prevalence”, “нийтлэг байдал-commonness”, “давтамж-frequency”, “магадлал, илрэх боломж-likelihood”, “хурц асуудалтай-problematic”, “хүнд, хэцүү-severity” гэсэн нөхцөл, ойлголтууд нь бүгд хоорондоо хамааралтай, бүгдээрээ авилгын цар хүрээний тодорхой нэг хэлбэрийг илэрхийлж байдаг. Энэ нь авилга олон хэлбэр, эх үүсвэртэй юм гэдгийг баталж байгаа чухал ойлголт болдог.

Дээрх бүгдийг нэгтгэн, ерөнхийд нь “авилгын цар хүрээ” гэсэн ойлголтыг тодорхойлбол энэ нь хахууль өгөх давтамж болон хахуулийн хэмжээтэй холбогдсон ойлголт гэж болно. ТИ-ийн сүүлийн үеийн судалгааны үр дүнд хахуулийн давтамж болон хэмжээ нь өндөр зэргийн хамааралтай болох нь гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, улс орнуудад хахууль нийтлэг, давтамж ихтэй байна гэдэг нь компаниудын орлогын ихээхэн хэсэг нь хахууль болно гэдэгтэй нэг утгатай юм. Иймээс “авилгын цар хүрээ” гэсэн үзүүлэлт нь **хахуулийн давтамж** болон **хахуулийн төлбөрийн өртөг** гэсэн хоёр үзүүлэлтээр хувь тэнцүү илэрхийлэгдэнэ.

Өмнө дурдсанаар манай улсын хувьд 1999, 2004, 2005 онуудын СРІ-ийн утга тооцогдсон ба эдгээрийг Хүснэгт 4.2. -оор нэгтгэн харуулъя.

Дээрхээс харвал, ТИ-ийн аргачлалаар манай улсын авилгын цар хүрээ 1999 оноос хойш өссөн, улс орнуудын дунд эзлэх зэрэглэлээр эрс буурсан дүр зураг харагдаж байна. Судалгаанд хамрагдсан 150 гаруй орны дотор Монгол Улс 85-р байранд байгаа нь авилгын цар хүрээ өргөн, асуудал хүндэрсэн, муу нөхцөл байдалтай байгааг

Хүснэгт 4.2. Монгол Улсын CPI

Он	Улсын зэрэглэл (Country rank)	CPI-ийн оноо (CPI score)	Стандарт хазайлт & Итгэх интервал (Standart deviation & Confidence range)	Ашиглагдсан судалгааны тоо (Surveys used)
1999	43	4.3	1.0	3
2004	85	3.0	2.6 - 3.2	3
2005	85	3.0	2.4 – 3.6	4

илэрхийлж байна. Мөн 1999 оноос Монгол улсын авилгын зэргээр эзлэх байр эрс ухарсан байна. Өнөөгийн нийгэмд илэрч байгаа зарим авилгын гэмт хэргүүд, түүний мөнгөн хэмжээ, нийгэм дэх эсэргүүцэл тэмцэл нэмэгдэж байгаа зэрэг нь дээрх үр дүнг нэг талаараа баталж байна.

5. Монгол дахь трансакцийн зардал, гэрээний биелэлт, өмчийн эрх хамгаалагдсан байдал

5.1 ТРАНСАКЦИЙН ЗАРДАЛ – ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Институцийн эдийн засагт нөлөөлдөг өөр нэг чухал суваг нь зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг өсгөж, бууруулж чаддаг нь байдаг. Бизнесийн бүхий л талын ажиллагааг гэрээгээр зохицуулдаг ба гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой олон төрлийн зардал үүсдэг. Эдийн засаг, бизнесийн харилцаа, солилцоо, хамтын ажиллагаанд үүсдэг эдгээр зардлыг трансакцийн зардал (transaction cost) гэж нэрлэдэг.


Эдгээр зардлыг 2 төрлөөр ангилж болно:

- өмч, хөрөнгийн эзэмшил, ашиглалтыг бататгах, хамгаалах, эдлэхтэй холбоотой зардлууд,

- гэрээний биелэлтийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлууд

Бизнесийн гол зорилго нь ашигтай ажиллах байдаг бөгөөд түүний тулд бизнес эрхлэгч хөдөлмөрийн болон хөрөнгийн зах зээл дээр гэрээ хэлцлийн замаар үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг авч ажиллуулах, хөрөнгө оруулалт хийж хувийн эзэмшлийн хөрөнгөтэй болох, төрийн байгууллагуудтай байнга харьцан ажиллах шаардлагатай байдаг тул маш өргөн, олон төрлийн трансакцийн (харилцаа, солилцооны) зардал үүсдэг. Зарим нь шууд мөнгөөр илэрхийлж болох зардлууд байдаг бол зарим нь цаг хугацаа, алдагдсан боломжийн өртгөөр хэмжигддэг. Дээрээс нь хувийн өмч, бизнес, хувийн секторыг тойрсон нийгмийн ёс, үзэл бодол, түүнтэй

Зураг 5.1. Трансакцийн зардлын ангилал



холбоотой зардал, төрийн бодлого ба түүний хүрээ, хувийн секторт үзүүлж буй нөлөө, эдийн засаг дахь бусад тогтсон журам (тоглоомын журам гэж ярьдаг) зэрэг зүйлс бүгд л тодорхой хэмжээний зардал, эрсдэлд нөлөөлдөг.

1960 онд Роналд Коуз трансакцийн зардалгүй (transaction cost) орчинд үнийн тохиролцоо болон гэрээ хэлэлцээр нь зардалгүй байх ба өрсөлдөөнт зах зээлүүд нь нийт орлогыг хамгийн их байлгах шийдэлд хүрдэг гэж тодорхойлсон. Ийм нийгэмд институци огт хэрэггүй. Гэтэл харилцан үйлдлүүд нь ганцхан удаа болоод өнгөрдөг үед л дээрх нөхцөл хангагдахаас мэдээлэл бүрэн бус ба тэгш бус, эсвэл цаг хугацааны хувьд үргэлжилсэн, олон тоглогчид оролцоод ирэхээр солилцоо болон хамтын үйл ажиллагаа нь илүү хүнд, төвөгтэй болж ирдэг. Өөрөөр хэлбэл трансакцийн зардал нь мэдээлэл, үнэ ханшаа тохирох болон гэрээ байгуулах, эсвэл гэрээ хэлэлцээрийг шийдвэрлэх, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудаас бий болно. Энэ нөхцөлд институци нь чухал хүчин зүйл болдог.

Адам Смитийн үеэс л эдийн засагчид хөдөлмөрийн хуваарилалтын үр шимийг ойлгож эхэлсэн. Эдийн засгийн онолд хөдөлмөрийн хуваарь нарийсах тусам бүтээмжийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Уламжлалт эдийн засгийн онолд арилжаа, солилцоо нь ямар ч зардалгүй явагдана гэж үздэг байсан. Харин сүүлийн үед эдийн засагчид хөдөлмөрийн хуваарилалт болон төрөлжилтөөс бий болох үр өгөөж нь үнэгүй биш гэдгийг ухаарсан. Анх Нобелийн шагналт эдийн засагч Роналд Коуз “Пүүсийн мөн чанар (The nature of firm)” гэдэг алдарт өгүүлэлдээ “трансакцийн зардал”-ын үүргийг авч үзсэн. Өөрөөр хэлбэл арилжаа солилцоо хийгдэх зардал нь эдийн засгийн байгууллагуудын зах зээлийн бус хэлбэр болон зах зээлийн бүтцийг тайлбарлахад хамгийн чухал зүйл болсон. Трансакцийн

зардал гэдэг нь ерөнхийдөө хөдөлмөрийн хуваарилалт болон төрөлжилтийн үр ашгийн үед бий болох зардал юм.

Зах зээлийн үйл ажиллагаанд трансакцийн зардал байнга гардаг бөгөөд түүний хэмжээ нь улс орны хөгжлийн түвшинтэй шууд хамааралтай байдаг. Хөдөлмөрийн хуваарь нарийсах тусам, зах зээлийн цар хүрээ, үйл ажиллагааны төрөл, хэмжээ өргөжиж эдгээр зардал өсдөг. Тухайлбал АНУ-д 1870-1970 оны хооронд зах зээлээр дамждаг трансакцийн зардал ҮНБ-ийх нь 45 хүртэлх хувийг эзэлж байсан байна. Япон улсын түргэн хөгжлийн гол шалтгаан нь трансакцийн зардлыг хамгийн бага байлгаж чадсантай холбоотой гэж үздэг. Төрийн бодлого, үйл ажиллагаа нь ч үүнд чиглэгддэг. Энэ хэсэгт Монгол улсын хувьд энэ зардлыг тодорхойлон, ямар байгааг авч үзэн үнэлэлт дүгнэлт өгөх юм.

Эдийн засгийн үйл ажиллагаа бүр нь трансакцийн болон бусад зардлыг агуулдаг боловч эдгээрийг ялгаж салгасан тоо баримт байхгүй. Практикт трансакцийн зардлыг нарийн зөв тооцох нь бэрхшээлтэй гэж үздэг. Трансакцийн зардлыг тооцох анхны эмпирик оролдлогыг Уоллис, Норт нар (1986) АНУ-ын эдийн засгийн 1870-1970 оны тоо мэдээлэлд үндэслэн хийсэн юм. Тэд трансакцийн зардлыг илүү нарийвчлан “**Өмчлөх эрхийг арилжаалах зардал**”, “**Гэрээний биелэлтийг хэрэгжүүлэх зардал**” гэж авч үзсэн бөгөөд үүнийг тооцохын тулд трансакцийн салбарыг тодорхойлсон.

Энэ аргачлалын үндсэн санаа нь зардлаа ангилахын оронд⁹ эдийн засгийн үйл ажиллагааг ангиланг авч үздэг юм. Трансакцийн зардал нь арилжаа хийхтэй холбоотой зардал бөгөөд трансакцийн функцээр тодорхойлогдоно. Харин үйлдвэрлэлийн зардал нь орцыг гарц болгон хувиргахтай холбоотой бөгөөд үйлдвэрлэлийн функцээр тодорхойлогдоно. Аль аль функц нь эдийн засгийн нөөц

ашиглах бөгөөд нөөц нь хөдөлмөр, капитал, газар, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх чадвар юм. Тиймээс трансакцийн зардал нь арилжаа хийгдэхийн тулд шаардагдаж буй эдийн засгийн нөөцийн өртгөөр тодорхойлогдох юм. Өөрөөр хэлбэл трансакцийн салбар дахь хөдөлмөр болон капиталын зардлаар трансакцийн зардлыг хэмжиж болно гэсэн үг. Дараахь жишээн дээр трансакцийн зардлыг авч үзье.


Бараа үйлчилгээ, тухайлбал орон сууц худалдан авахаар хайж буй хэрэглэгчийн хувьд бараа үйлчилгээ нийлүүлэгчдэд шилжүүлээгүй бүхий л төлбөр нь трансакцийн зардал болдог. Эдгээрт орон сууц хайж олоход зарцуулж буй хугацаа, үнэ болон бусад хувилбаруудын талаарх мэдээлэл олж авах зардлууд орох юм. Түүнчлэн хууль зүйн зөвлөгөө авах, гэрээ байгуулах, нийлүүлэгч нь итгэлтэй эсэхийг шалгах (байр барьцаанд тавигдаагүй эсэхийг шалгах гэх мэт) зардлууд ч энд хамаатай. Трансакцийн зардлыг тодорхойлох гол шалгуур нь

худалдан авахад гарч буй зардлын нэг хэсгийг худалдагч хүлээн аваагүй явдал юм.

Орон сууцаа худалдаж буй (нийлүүлэгч) хүний хувьд ч трансакцийн зардал гарна. Жишээлбэл, зар сурталчилгааны зардал, эсвэл зуучлагч хөлслөх зардлууд, зарагдах хүртэл хүлээж буй цаг хугацаа, үл хөдлөх хөрөнгийн газрын үнэлгээ, даатгалын зардлууд байна. Энэ тохиолдолд ч гэсэн трансакцийн зардлыг гол тодорхойлж буй шалгуур нь эдгээр зардал нь хоёрдогч арилжааны (жишээлбэл, зуучлагч хөлслөх) үед гарч байгаа юм.

Зах зээлийн эдийн засагт өмчийн эрхийг шилжүүлэх, өргөн утгаараа харилцааны зохион байгуулалтыг дэмжих хамгийн гол зүйл нь гэрээ байдаг. Дараахь схемээр эдийн засгийн систем дэх үйлдвэрлэлийн болон трансакцийн зардлыг тодорхойлов. Орчин үеийн аливаа үйлдвэрлэл нь үр ашигтай байхын тулд төрөлжилтийг шаарддаг бөгөөд төрөлжилтөөс агентууд хоорондоо арилжаа хийдэг. (Зураг 5.2.)

Зураг 5.2 Эдийн засгийн хүчин чадал, төрөлжилт болон арилжааны эдийн засаг



Трансакцийн зардал нь худалдаа хийх үед нийлүүлэгч болон хэрэглэгчээс гарах зардлаар ч хязгаарлагдахгүй. Трансакцийн зардал нь үнэ ханш, чанар үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах гэх мэт арилжаа хийхээс өмнө гарахаас гадна арилжаа хийгдсэний дараа ч гардаг. Төлбөрөө олж авах, мониторинг хийх, гэрээний биелэлттэй холбоотой зардлууд нь ч үүнд хамаатай. Ерөнхийдөө трансакцийн зардлыг арилжаа хийхийн өмнө, арилжаа хийх үед, арилжаа хийсний дараа гарч байгаагаас нь хамааруулан “координаци хийх”, “гэрээ байгуулах”, “мониторинг хийх” гэж ангилдаг.

Трансакцийн зардлыг хэмжихтэй холбоотой гарч ирдэг дараагийн ойлголт нь “трансакцийн үйлчилгээ” юм. Энэ нь трансакцийн зардлын хэмжигдэхүйц (ажиглагдахуйц) элемент буюу зах зээлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг л хэмжиж (ажиглаж) чаддаг.

Трансакцийн зардлын зарим нь зах зээлийн үйл ажиллагаагаар үүсэн өртгөөр нь илэрхийлэгдэж болдог (жишээ нь өмгөөлөгч хөлслөх) бол зарим нь өртгөөр нь илэрхийлэгддэггүй цаг хугацаа (байр зарагдах хүртэл хүлээх), алдагдсан боломжийн зардлаар тодорхойлогддог. Тийм учраас трансакцийн зардлыг хэмжихдээ трансакцийн үйлчилгээгээр төлөөлүүлэн хэмждэг.

Трансакцийн зардал болон трансакцийн үйлчилгээ нь үндэсний орлогын тооцоолол дахь нийт орлого болон зах зээлийн орлого гэдэгтэй ижил жишээ юм. Үндэсний орлого нь нийгмийн гишүүдийн нийт орлого бус зөвхөн зах зээлийн процессоор бий болсон хүмүүсийн орлого байдаг. Үүнтэй адилаар трансакцийн үйлчилгээ нь зах зээлээр дамжин бий болдог трансакцийн зардлын нэг хэсэг юм.

Д.Норт эдгээр зардлын тухай ийнхүү тайлбарласан байдаг: “Аливаа зах зээлийн

үйл ажиллагаа бүхэн трансакцийн зардлыг шаардаж байдаг. Шинэ сонгодог онолд зах зээлүүд төгс төгөлдөр ажилладаг гэж үздэг тул харилцааны зардлыг тооцдоггүй боловч бодит амьдралд эдгээр харилцааны зардал аливаа зах зээлийн үйлдлийг дагадаг. Трансакцийн зардал өндөр байх тусам зах зээлийн үйл ажиллагаа бэрхшээлтэй тулгардаг. Жишээ нь, зах зээлийн субъектууд хоорондоо худалдаа, солилцоо хийхэд солилцоо нь тохиролцооны үндсэн дээр явагддаг. Гэвч тохиролцоо нь баттай хэрэгжих эсэх нь тодорхойгүй нөхцөлд солилцоо хэт эрсдэлтэй болж, бүтэхгүй байж магадгүй. Хэрэв тохиролцооны биелэлтийг хэрэгжүүлэх механизм байвал солилцоо илүү амархан явагдах болно”.

Институцийн эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлдэг гол нөлөөг дараахь байдлаар дүгнэж болно: “Эдийн засгийн өсөлт/хөгжлийн гол түлхүүр нь институци юм. Тогтвортой нийгэм - эдийн засгийн институци улс төр, бодлого боловсруулах болон эдийн засгийн зах зээл дэх трансакцийн зардлыг бууруулах замаар эдийн засгийн өсөлт, хөгжлийг түргэтгэж байгаа юм”⁵.

Эдийн засгийн аливаа нөөц хязгаарлагдмал байдаг тул нөөцөө хамгийн бүтээмжтэй, үр өгөөжтэйгээр хуваарилах нь тухайн улсын эдийн засгийн өсөлт, хөгжилтэй шууд холбоотой юм. Үйлдвэрлэлийн гол нөөц болох газар, капитал, хөдөлмөрийн зах зээлүүд зардал багатай, үр өгөөжтэй ажиллах тусам нөөцийн хуваарилалт оновчтой болж, эдийн засаг үйлдвэрлэлийн боломжит хэмжээнд үйлдвэрлэлээ явуулж чаддаг. Гэвч зах зээлүүд нь нэмэлт зардал, тухайлбал трансакцийн зардлуудыг шаардах тохиолдолд тухайн эдийн засаг өөрийн нөөцөө үйлдвэрлэлд бүрэн ашиглаж чадахаа больж, үр өгөөж нь багасч эхэлдэг. Тиймээс трансакцийн зардал өндөртэй эдийн засаг өөрийн боломжоо

бүрэн ашиглаж чадаагүйгээс өсөлт нь удаашралтай байх болно. Өөрөөр хэлбэл, **трансакцийн зардал нь бага байх нь зах зээлийн үйл ажиллагаа үр өгөөжтэй явагдах гол нөхцөл нь болж байна.**

Үүнээс харахад институцийн эдийн засагт үзүүлдэг нөлөө нь трансакцийн зардлаас хамаардаг ба түүний түвшинг тухайн улсын институци тодорхойлдог. Д.Нортын тэмдэглэснээр “Трансакцийн зардлыг дараахь байдлаар ангилж болно.

- өмчийн эрх,
- солилцооны хэмжүүр,
- гэрээ хэлцлийн биелэлттэй холбоотой зардлууд”¹ гэж үзсэн байдаг.

Зах зээлд эдийн засгийн агентуудын хооронд их хэмжээний арилжаа, солилцоо хийгддэг тул трансакцийн зардал байнга үүсдэг бөгөөд түүний хэмжээ, түвшин тухайн улсын эдийн засгийн хөгжлийн түвшинтэй ихээхэн хамааралтай байна. Хөдөлмөрийн хуваарь нарийн болж, зах зээлийн цар хүрээ, үйл ажиллагааны төрөл, хэмжээ өсөх тусам эдгээр зардал ихээхэн өсдөг ба зах зээлийн эдийн засагтай, хөгжилтэй орнуудад асар өндөр түвшинд хүрч болзошгүй байдаг. “Эдийн засгийн болон технологийн хөгжил нь эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой их хэмжээний зардлыг бий болгож байдаг. Орчин үеийн технологи, хөдөлмөрийн хуваарилалтын давуу талыг ашиглахын тулд нийгэм, эдийн засагт их хэмжээний трансакцийн зардлыг санхүүжүүлэх шаардлага тавигддаг. Жишээ нь, АНУ-д 1900-1970 онд нийт ажиллах хүч 29 саяас 80 сая болж өссөн. Аж үйлдвэрийн ажилчдын тоо дөнгөж 10-аас 29 сая болж өссөн байхад аж үйлдвэрийн бус салбарт ажиллагсдын тоо 5 саяас 38 сая болж өсчээ. Зах зээлийн үйл ажиллагаа нь АНУ-ын ҮНБ-ий 45 хүртэл хувийг эзэлсэн байсан” (Wallis and North, 1986).

Трансакцийн зардал, институци хэрхэн эдийн засгийн өсөлт, хөгжилд нөлөөлдөг тухай Р. Холл, Ч. Жонс (НБЕР, 1998) нар “Яагаад зарим улс нэг ажилчинд ноогдох бүтээгдэхүүнээрээ бусдаас илүү байдаг вэ?” гэсэн ажилдаа дараахь дүгнэлтэд хүрсэн байгааг дурдаж болно: “Нэг ажилчинд ногдох үйлдвэрлэл нь бүтээмжээс шалтгаалдаг бөгөөд бүтээмж нь нийгмийн дэд бүтэц буюу төрийн бодлого болон институциас шалтгаална. Төрийн бодлого болон институци нь бүтээмжийг дээшлүүлэх, шинэ бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хүмүүсийг чиглүүлж болох боловч нөгөө талаас авилга, нийгэм болон төрийн баялгийг завших, түүнийг ашиглан хууль бусаар баяжих сонирхлыг бас төрүүлж болно. Үүний нэг тод жишээ нь ашиг сонирхлын шинж чанартай улс төрийн лобби юм. Бүтээлч хугацаа, хөрөнгө, чадавхийг үйлдвэрлэлд бус засгийн газарт нөлөө үзүүлэхийн тулд зарцуулж, эдийн засгаа хөгжүүлэхийн оронд хууль бус, ёс зүйгүй баяжих зорилго давамгайлж байдаг эдийн засаг хөгжиж чадахаа больдог. Амжилттай хөгжсөн эдийн засаг ийм ашиг сонирхлын үйл ажиллагааг хязгаарлаж чадсан байдаг. Энэ хязгаарлалтыг дараахь байдлаар хэмжиж болно.

Засгийн газрын нөөцийн буруу ашиглалтын хязгаарлалтын бодлогын индекс (Нак, Кифер нарын 130 орны 1995 оны судалгаа) – үүнд 5 ангилал, 24 үзүүлэлт ордог ба тус индексийг Олон Улсын эрсдлийн хөтөч гэдэг тайланд харуулсан байдаг. Эдгээр 5 ангиллын Хууль ба дэг журам, засаглалын чадвар гэсэн хоёр ангилал нь институцитэй холбоотой юм. Энэ хоёр үзүүлэлт нь Засгийн газар хэрхэн өмчийн эрхийг хамгаалж байгаа, авилгад автах аюултай байгаа эсэх, мөн гэрээ, хэлцлийн биелэлтийг хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулж байгаа юм. Түүнээс гадна ашиг сонирхлын шинж чанартай лобби гадаад худалдааны тарифыг

Хүснэгт 5.1. Трансакцийн салбарын бүтэц: ДНБ-д эзлэх хувиар

	1990	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
<i>Дотоодын нийт бүтээгдэхүүн</i>	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Үүнээс:											
<i>Бөөний, жижиглэн худалдаа</i>	19.4	17.0	16.7	21.0	21.1	20.7	24.0	26.7	27.7	26.5	24.6
<i>Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа</i>	0.0	1.2	1.8	1.6	1.6	2.2	2.5	3.1	3.2	3.8	4.0
<i>Үл хөдлөх хөрөнгө, түрээс</i>	0.0	0.6	0.8	0.8	1.0	1.0	1.0	1.0	1.2	1.5	1.3
<i>Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал</i>	12.7	3.0	2.9	2.5	3.7	3.6	4.6	4.3	4.5	4.2	3.8
<i>Нийт хувь /%/</i>	32.1	21.9	22.1	25.9	27.4	27.6	32.1	35.1	36.6	36.0	33.7

Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхтгэл 2004

өндөрсгөх замаар ашиг олох сонирхол ихтэй байдаг учраас нийгмийн дэд бүтцийг хэмжихэд тухайн эдийн засаг дэлхийд хэр нээлттэй байгааг харуулах үзүүлэлтүүд орсон байдаг. Уг судалгааны талаар эцэст нь хэлэхэд нийгмийн дэд бүтцийн ялгаа (институцийн чанар) нь бүтээмжийг 25-38 дахин зөрүүтэй байдалд хүргэж байж болзошгүй юм. Энэ нь бидний анхны жишээ болох дэлхийн хамгийн баян улс болох АНУ ба хамгийн ядуу улс болох Нигерийн нэг ажилчинд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ буюу бүтээмжийн зөрүү 35.1 дахин ялгаатай байгаагаар харагдаж байна.”

5.2 МОНГОЛ ДАХЬ ТРАНСАКЦИЙН ЗАРДАЛ

Монгол улсын хувьд трансакцийн зардлыг тооцохын тулд Статистикийн төв газраас гаргадаг салбарын ангиллыг ашигласан (аргачлал нь Уоллис, Норт, 1986). Дараахь салбаруудыг трансакцийн үйлчилгээний салбар гэж тодорхойлсон. Үүнд:


- *Бөөний болон жижиглэн худалдаа.*

- *Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа.*
- *Үл хөдлөх хөрөнгө, түрээс.*
- *Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал.*

Трансакцийн үйлчилгээний салбарын ангилалд оруулсан гол шалгуур нь арилжаа, солилцоог хурдасгаж, хүмүүсийн харилцааг дэмжиж, тодорхой бус байдлыг бууруулдаг байх юм. Эдгээр салбарын нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар нь трансакцийн салбарын бүтцийг тодорхойлов. (Хүснэгт 5.1.)

Трансакцийн зардал хэр их байгааг харуулах дээрх мэдээллийг 1990 оноос эхлэн тооцлоо. Учир нь түүнээс өмнө Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой байсан ба хоёр системийг хооронд нь харьцуулах нь ач холбогдол багатай гэж үзсэн. Тэгээд ч хуучин тогтолцооны үед эдийн засгийн харилцааг нийтэд нь төрөөс зохицуулдаг байсан учраас трансакцийн зардал өндөр байсан гэж хэлж болно. Энэ байдал нь зах зээлд шилжсэн эхний жилүүдэд хадгалагдаж байсан нь хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал

Зураг 5.3. Трансакцийн салбарын ДНБ-д эзлэх хувь, 1990-2004 он



Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхтгэл 2004

1990-ээд оны эхэн үед төрийн удирдлагад батлан хамгаалах салбарын эзлэх хувь 10-аас өндөр байсан бөгөөд 1995 оноос эхлэн эрс буурсан байна. Харин үүний эсрэгээр үл хөдлөх хөрөнгө, түрээс болон санхүүгийн үйлчилгээний салбарын эзлэх хувь 1995 оноос эхлэн өссөөр байна.

Нийт трансакцийн салбарын эзлэх хувь шилжилтийн эхний жилүүдэд буурч байснаа буцаад өссөн байгааг дараахь динамикаас ч харж болно. (Зураг 5.3.)

Монгол улсын хувьд трансакцийн зардал нь 1995 онд хамгийн бага буюу ДНБ-ий 22 хувьтай тэнцүү байснаа өссөөр 2002 онд 36.6 хувьд хүрээд сүүлийн жилүүдэд буцаад буурах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн хэдэн жилд трансакцийн зардал нь дунджаар ДНБ-ий 35 орчим хувьтай тэнцэж байна.

Өөр нэг сонирхолтой үр дүн нь 2002 оноос трансакцийн салбарын эзлэх хувь буурч байгаа боловч энэ салбарт ажиллагсадын нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь (энэ үзүүлэлт нь трансакцийн зардлыг илэрхийлэхгүй) буураагүй харин өсөх хандлагатай байгааг Хүснэгт 5.2 -д харуулж байна.

Энэ үзүүлэлтийг бусад хөгжиж буй болон шилжилтийн орнуудтай харьцуулан үзэхэд дараахь байдал ажиглагдаж байна. Аргентин улсад трансакцийн зардлын ДНБ-д эзлэх хувь 1990 онд 34.5%, АНУ-д 62%, Японд 55%, Германд 47.6%, Францад 63.9% байсан.¹⁷ Польш улсад энэ хувь 1996-2002 онуудад 47%-иас 62.5% болж өссөн байна.¹⁸ Австралид энэ үзүүлэлт 1991 онд мөн ДНБ-ий 59.5% байсан байна. Ерөнхийдөө өндөр ДНБ-тэй, аж ахуйн бүтэц асар нарийн болсон хөгжингүй улсуудад трансакцийн зардал нь ДНБ-д өндөр хувь эзэлдэг.

Харин энэ трансакцийн зардал нь манай улсын эдийн засагтай ижил төстэй шилжилтийн эдийн засагтай орнуудад ямар байгааг харьцуулан үзье. Эдгээр улс орны трансакцийн зардлыг тооцсон ажил байхгүй тул өмнө нь хийсэн аргачлалаараа тооцоо хийж үзье. Үүний тулд үндэсний тооцооны

¹⁷ TRANSACTION COSTS IN ARGENTINA, Jos'e Maria Dagnino-Pastore y Paulo Enrico Farina, 1999, Argentine Catholic University, University of Buenos Aires.

¹⁸ Measuring the Transaction Sector in the Polish Economy, 1996 – 2002, Aleksander Sulejewicz, Patrycja Graca, Warsaw School of Economics, Paper presented at The 9th Annual Conference of International Society for New Institutional Economics Barcelona, 22-25 September, 2005

Хүснэгт 5.2. Трансакцийн салбар дахь ажил эрхлэлт

(мян.хүн)

	2001	2002	2003	2004
<i>Нийт ажил эрхлэлт</i>	832.3	870.8	926.5	950.5
Үүнээс:				
<i>Бөөний, жижиглэн худалдаа</i>	90.3	104.5	129.7	133.7
<i>Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа</i>	7.3	9.4	12.6	15.9
<i>Үл хөдлөх хөрөнгө, түрээс</i>	6.8	10.9	9.3	11.2
<i>Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал</i>	41.0	43.9	44.8	46.2
<i>Бүгд</i>	145.4	168.7	196.4	206.0
<i>Нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь /%/</i>	17.5	19.3	21.2	21.7

Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхтгэл 2004

Хүснэгт 5.3. Зарим шилжилтийн улс орнуудын трансакцийн салбарын ДНБ-д эзлэх хувь

Year	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Унгар	24.9	24.4	24.3	24.7	25.4	25.6	24.9	25.8	26.7	25.6
Эстони	-	-	-	-	-	35.8	36.5	37.3	37.7	38.3
Латви	28.5	30.7	32.3	33.9	37.9	39.3	39.3	40.2	39.6	40.3

дансны өгөгдөл шаардлагатай. Тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүнийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилсныг хавсралтаас харж болно. Эндээс дотоодын нийт бүтээгдэхүүнд трансакцийн салбарын эзлэх хувийг тодорхойлсон. Өмнө тодорхойлсны адилаар *бөөний болон жижиглэн худалдааны салбар, санхүүгийн зуучлалын салбар, үл хөдлөх хөрөнгө, түрээс болон төрийн үйлчилгээний салбарууд* нь трансакцийн салбарыг тодорхойлно. Энэ аргачлалаар улс орнуудын трансакцийн салбарыг тодорхойлон үзвэл Хүснэгт 5.3. байдалтай байна.


Унгар улсын трансакцийн салбар нь харьцангуй бага буюу 24.3-26.7 орчим хувьтай байна. Эстони улсын хувьд сүүлийн 5 жилийн дунджаар трансакцийн салбарын ДНБ-д эзлэх хувь 37 орчим байна. Харин

Латви улсын хувьд трансакцийн зардал 1995-1999 он хүртэл 28 хувиас 39 хувь болтлоо өссөн бөгөөд сүүлийн хэдэн жилд 40 орчим хувьтай байна. Эдгээр орны трансакцийн зардлыг Монгол улсын тоотой харьцуулан харвал сонирхолтой юм. (Зураг 5.4.)


Ерөнхийдөө манай орны трансакцийн зардал бусад шилжилтийн орнуудынхтай ойролцоо түвшинд байгаа нь харагдаж байна. 1995 онд манай улсын трансакцийн зардал хамгийн бага байгаа боловч аажим өссөөр сүүлийн жилүүдэд Унгартай харьцуулахад өндөр, Эстони улстай ойролцоо, Латви улстай харьцуулахад бага болсон байна.

Гэвч Монгол Улсын трансакцийн зардлын хувийг нэг хүнд ноогдох ДНБ-тэй харьцуулахад манайд орлого, ДНБ-ий түвшин харьцангуй бага мөртлөө түүнтэй

Зураг 5.4. Трансакцийн зардал, ДНБ-д эзлэх хувиар



Зураг 5.5. Трансакцийн зардал ДНБ-д эзлэх хувь ба нэг хүнд ногдох ДНБ



Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхтгэл, олон улсын статистикийн өгөгдлүүд

харьцуулахад трансакцийн зардал хэт их өндөр хувьтай байгаа юм. (Зураг 5.5.)

Ийнхүү манай улс ДНБ-ий түвшин харьцангуй бага байгаа мөртлөө нэг хүнд ногдох ДНБ-ээр Монголоос 5-10 дахин өндөр улсуудынхтай ижил түвшний трансакцийн зардалтай байгаа юм. 1995 оноос 2004 оны

хооронд Монголын ДНБ-д трансакцийн зардлын хувь нь 10 гаруй пунктээр өссөн байна.

Макро эдийн засаг дахь трансакцийн зардлын мэдээлэл нь дээрх хэлбэртэй байгаа бол микро орчинд буюу бизнесийн орчин дахь трансакцийн зардал Монгол Улсад

хэр их өндөр байдаг вэ? Дэлхийн Банкнаас явуулсан “Doing Business” судалгааг толилуулахад Монгол Улсад бизнес хийхэд дараахь зардал гардаг байна.

- Бизнесийг шинээр нээхэд 20 орчим ажлын өдрийг дунджаар шаардах 8 алхмыг хийх, түүний зардал нь нэг хүнд ногдох жилийн ҮНБ-ийн 6.2%-тай тэнцүү байх бөгөөд нэг хүнд ногдох жилийн ҮНБ-ийн 140%-тай тэнцэх хөрөнгийг банкинд хадгалж бизнесийн гэрчилгээ авах ёстой.
- Бизнесийн үйл ажиллагаа явуулахын тулд лиценз, зөвшөөрөл зэргийг авах ёстой бөгөөд түүнд 96 ажлын өдөр шаардах 18 алхмыг хийж, нэг хүнд

ногдох жилийн ҮНБ-ийн 58.8%-тай тэнцэх зардлыг гаргана.

- Дунд хэмжээний бизнесүүд татвар, хураамжийг төлөхдөө 43 төрлийн төлбөрийг төлж, нийтдээ цэвэр орлогын 45.3%-ийг төлдөг.

Эдгээр үзүүлэлтийг бусад орныхтой харьцуулахад, нийт дүнгээр Монгол Улс Дэлхийн Банкны судалгаанд хамрагдсан 155 орны дотор 61-р байрыг эзэлж байгаа юм. Харин зарим үзүүлэлтээр их доогуур орж байгаа ба жишээ нь татвар төлөх явцаар Монгол улс уг жагсаалтад 101-р байранд, гадаад худалдааны нөхцлөөр 133-т, бизнесийг хаахад 103-т байна.

Хүснэгт 5.4. Дэлхийн Улс орнуудын бизнесийн орчны үнэлгээ

Улс	Бизнес хийхэд амархан байдаг эсэх	Бизнесийг эхлэх	Лицензтэй ажиллах	Ажилд авах, халах	Үл хөдлөх хөрөнгийг бүртгүүлэх	Зээл авах	Хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах	Татвар төлөх	Гадаадтай худалдаа хийх	Гэрээний биелэлт	Бизнесийг хаах
Шинэ Зеланд	1	4	2	4	1	7	1	16	15	4	21
Сингапур	2	5	7	7	14	8	2	9	6	11	2
АНУ	3	3	17	6	12	15	7	30	17	10	17
Канад	4	1	21	24	27	10	3	12	13	34	4
Норвег	5	19	11	46	7	39	16	40	7	1	3
Австрали	6	2	12	14	34	3	26	14	22	12	15
Хонг-Конг, Хятад	7	6	77	3	70	2	4	2	26	16	14
Дани	8	15	6	17	31	22	18	61	1	2	25
Их Британи	9	9	29	15	23	1	9	81	21	30	10
Япон	10	81	5	20	36	18	14	50	12	3	1
Польш	54	92	120	64	75	88	22	106	34	104	23
Непал	55	30	39	69	18	87	90	51	106	73	78
Пакистан	60	38	80	91	43	72	20	127	103	134	36
Монгол Улс	61	49	22	54	21	69	..	101	133	51	103
Болгар	62	80	118	90	62	46	54	78	45	79	56

Хүснэгт 5.4-өөс Монголд бизнес хийхэд ямар үнэлгээтэй байгааг харж болно.

Эдийн засагч Де Сото трансакцийн зардлын талаарх судалгаандаа бизнесийг шинээр эхлэх, зөвшөөрөл авах, хахууль өгөх трансакцийн зардал нь чухал хэмээн үзэж Перуг судлахад тус улсад бизнес явуулах зардал нь асар өндөр гэж гарсан. Жишээлбэл, тус улсад 1989 онд АНУ-тай харьцуулахад машины эд ангийг авах үнэ нь 4 дахин өндөр, худалдан авах хугацаа нь 280 дахин урт (1 өдөр/41 долоо хоног) байсан байна. Аргентин улсад мөн л ижил эд ангийг худалдан авах үнэ АНУ-ынхаас 2 дахин өндөр, хүлээх хугацаа 30 дахин урт байжээ. Унгарт 1989 онд, эдийн засгийг либеральчлахын өмнө Баруун Европт үйлдвэрлэсэн тракторын эд ангийг олоход 30-48 долоо хоног шаардагддаг байсан бол эдийн засгийн либеральчлалын дараа уг хугацаа 2 долоо хоног болтол буурсан байна.

Хээл хахууль өгөлгүйгээр шинээр бизнесийг нээхэд 1989 онд Перу улсад 289 ажлын өдөр шаардагдсан байна, гэтэл АНУ-ын Флорида мужид яг ижил бизнесийг нээхэд ердөө л 2 цаг шаардагдсан байна. Хөдөө орон нутагт байгаа хүмүүст энэ зардал, хугацаа улам нэмэгддэг юм байна. Жишээ нь Танзани улсад нийслэлээс зайдуу газар оршдог бизнесчдийн компаниа бүртгүүлэх нийт зардал нийслэлд байгаатай харьцуулахад 5-10 дахин өндөр байсан байна.

Өөр нэг жишээ гэвэл “1990 оны эхээр бизнесийн хэрэгцээнд утасны шугам тавиулах зардлыг судалсан. Тэгвэл Малайзид 130 долларын зардалтай байхад Аргентинд уг зардал 6000 доллар хүрч, Египетэд утсыг тавиулах нь албан ёсоор 295 доллар ба “шуурхай” үйлчилгээ нь 885 доллартай тэнцэж байсан.”⁴

5.3 МОНГОЛ ДАХЬ ӨМЧИЙН ЭРХ (PROPERTY RIGHTS)

Хувийн өмч нь зах зээлийн эдийн засгийн амин сүнс билээ. Хувийн өмч дээр тулгуурлан ашиг, орлогоо нэмэгдүүлэх гэсэн эдийн засгийн агентуудын өрсөлдөөний үр дүнд эдийн засгийн нөөц хамгийн үр ашигтай хуваарилагдан, бүтээмж нэмэгдсэнээр улс орнууд хөгждөг. Гэхдээ Фридманы хэлснээр өмчлөх эрхийг авч үзэхгүйгээр хувийн өмчийн тухай ярих нь утгагүй юм. Өмч гэж байгаа нь өмчлөх эрхийн тухай л ярьж байгаа хэрэг. Хувийн өмч гэж хэлж байгаа нь өмчийг эзэмших ашиглах хувь хүний эрхийн тухай л ярьж байгаа юм. Мизэсийн хэлснээр хэрэглээний эд зүйлсийг ашиглах эрх бол угаасаа хувь хүмүүст байхаас аргагүй. Хувийн өмчид тулгуурласан нийгэм, эдийн засгийн тогтолцоо гэдэг нь үйлдвэрлэлийн хэрэгсэл нь хувь хүний мэдэлд байх тухай юм.

Өмчийн эрхийг эдлэх, бусдад шилжүүлэх үед зардал багатай, чирэгдэлгүй байх нь чөлөөт солилцоонд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн хамгийн чухал тулгуур шаардлагын нэг юм. Хэрэв энэ үйл ажиллагаа зардал, чирэгдэл ихтэй байвал, тэр хэмжээгээр солилцоонд гарч байгаа зардал нэмэгдэж, нийт эдийн засгийн үйл ажиллагаа нь бэрхшээлтэй тулгарч, эдийн засгийн хөгжил, өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх болно.

Энэ удаагийн тайлангийн гол санаа болох эдийн засгийн өсөлт хөгжлийн тулгуур нь институци юм гэж үзэж байгаа. Энэ нь өөрөө өмчлөх эрх дээр үндэслэдэг. Институцийн хөгжил сул байна гэдэг нь өмчлөх эрх баталгаажаагүй байна гэсэн үг. Ийм нөхцөл байдалд угаасаа зах зээл нь жам ёсоор ажилладаггүй байна. Тийм ч учраас эдийн засгийн эрх чөлөөний үндэс нь хувийн өмч, түүний халдашгүй дархан байдал. Хувийн өмч, түүний халдашгүй байдал дээр тулгуурлан чөлөөт өрсөлдөөний

нөхцөл бүрдүүлж чадсан эдийн засагтай улс орон амжилттай хөгжсөн жишээ хангалттай олон.

Монгол Улс 1990 оноос үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчид тулгуурласан зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг хийж байна. Шилжилтийн хүрээнд шат дараатай авч хэрэгжүүлсэн хувьчлал нь хуучин тогтолцооны үед дан ганцаар байсан улсын өмчийг задалж хувийн өмч бий болгоход чиглэгдэж байгаа билээ. Монгол Улсад хувийн өмчийг хуулиар баталгаажуулсан бөгөөд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр, өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин үндсэндээ бүрэлдсэн. Өмчийн эрхийг Монгол Улсад 2 төрлөөр салгаж авч үзэж болно. Нэг нь мал аж ахуй болон уламжлалт аж ахуй дахь өмчийн эрх; хоёр дахь нь үл хөдлөх хөрөнгө болон газрын өмчийн эрх. Социализмын үед нэгдэлжих хөдөлгөөнөөр мал аж ахуй дахь уламжлалт өмчийн эрх зөрчигдөж байсан боловч мал хувьчлалын дараа сэргэж, өнөөгийн нөхцөлд баталгаажсан гэж хэлж болно¹⁹.

Манай улсын хувьд эдийн засгийн шинэ харилцааг төлөвшүүлэх асуудлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэх явдал юм. Үл хөдлөх эд хөрөнгө, түүн доторх газрыг өмчлөх эрх нь зөвхөн зах зээлийн шилжилтийн дараа шинээр бий болсон үзэгдэл. Энэхүү харилцааг төлөвшүүлэх асуудлын гол цөм нь үл хөдлөх эд хөрөнгийг үнэлж бүртгэх үйл ажиллагаа билээ. 1997 онд Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийг УИХ-иас батлан гаргаснаар түүний хууль эрх зүйн үндэс бүрэлдсэн.

Үүний дараагаар “Эрхийн улсын бүртгэлийн алба /Үл хөдлөх хөрөнгийн

газар/” байгуулагдсан юм. Энэ газар нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийг баталгаажуулахын зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой бүх мэдээллээр хангадаг. Хуульд зааснаар иргэд болон аж ахуй нэгж өөрийн өмчлөлд байгаа эд хөрөнгийг энэ албанд бүртгүүлснээр уг үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч мөн болохыг гэрчилсэн гэрчилгээ олгох бөгөөд ингэснээр өмчлөх эрх хууль ёсоор баталгаажна. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулснаар худалдах, бэлэглэх, өвлүүлэх, арилжих, барьцаалж зээл авах, хөлслөх (хөлслүүлэх), түрээслэх (түрээслүүлэх) эрхийг эдэлдэг.

Үл хөдлөх хөрөнгө гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох барилга байгууламжийг ойлгодог. Газрын тухай хуулийн 34.1-д заасан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг эндээс олгох ба иргэдийн хувьд орон сууц болон амины сууц, өвлийн сууцаа бүртгүүлж өмчлөх эрхээ хуульчилдаг. Аливаа үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгүүлэхэд дээд тал нь 14 хоног шаардагддаг.

Олон улсын түвшинд харьцуулж үзэхэд, Дэлхийн Банкны “Doing Business” хэмээх зуу гаруй орон хамрагдсан судалгаанаас үзэхэд Монголд үл хөдлөх хөрөнгийн өмчлөл дараахь байдалтай байна. Монголд өмчийг (үл хөдлөх өмчийг голлон) бүртгүүлэхэд, дараахь хэд хэдэн алхмуудыг хийх ёстой болдог байна:

- Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газраас нотариатаар баталгаажуулсан бичгийг болон бусад шаардлагатай материалыг цуглуулж бэлдэнэ, үүнд 1-3 өдөр зарцуулж, 5-10 мянган төгрөгийн хураамжийг төлнө.
- Өмчийг худалдаж авсан гэрээг нотариатаар батлуулна. Өмчийг

¹⁹ Changing Property Rights Systems in Western Mongolia: Private Herd Ownership and Communal Land Tenure in Bargaining Perspective, MAX PLANCK INSTITUTE FOR SOCIAL ANTHROPOLOGY, WORKING PAPERS, Working Paper No.3, PETER FINKE, 2000

худалдан авсан гэрээг нотариатаар 1 сая төгрөгийн өмч байвал гэрээний 0.5%, түүнээс дээш үнэтэй гүйлгээний тохиолдолд 10-200 мянган төгрөгөөр баталгаажуулна.

- Үл хөдлөх хөрөнгийн татварыг төлнө. Татварын хэмжээ өмчийн 2% -тай тэнцэнэ. Үүнд бас 1 өдөр шаардана.
- Өмчийн өргөдлийг Үл Хөдлөх Хөрөнгийн бүртгэлийн газарт өгч 13 000 төгрөгийн бүртгэлийн хураамж болон 21-55 мянган төгрөгийн үйлчилгээний хураамжийг төлнө. Өмчлөлийн бичиг 7 хоногийн дотор бэлэн болно.

Хуулийн этгээд газрыг өмчлөх эрхгүй бөгөөд газар нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн хамт шилжих тул, газар ашиглалтын эрхийг шилжүүлэх шаардлагатай болно. Үүнд мөн 7 өдөр, гэрчилгээний хураамж болох 7000 төгрөг шаардагдана. Гэрчилгээг дүүргийн газар ашиглалтын газар гаргаж, шинэ эзэмшигчтэй гэрээ байгуулна.

Нийтдээ ийнхүү хувийн өмчийг бүртгүүлэхэд 5 алхам, 11 өдөр, өмчийн үнийн дүнгийн 2.3%-тай тэнцэх зардал гарах юм байна. Энэ бол харьцангуй доогуур үзүүлэлтүүд юм байна. Жишээ нь өндөр хөгжилтэй орнуудад дунджаар өмчийн үнийн 4.8% -тай тэнцэх зардлыг гаргах шаардлагатай болдог байна. Гэвч Монголд энэ ажил илүү их чирэгдэлтэй. Азийн болон өндөр хөгжилтэй орнуудад дунджаар 4.6, 4.7 янз бүрийн алхмуудыг хийж байхад Монголд 5 өөр алхмыг хийж өмчөө бүртгүүлнэ. Энэ үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан 100 орноос Монгол Улс 83-р байранд орсон байна. Хөгжиж буй болон хөгжилтэй орнуудад энэ зардал нилээд ялгаатай байдаг. Жишээ нь, “Каир хотод байр худалдаж авсан хүн байрны зардлын 12%-тай тэнцэх зардлыг нэмж гаргах шаардлагатай байдаг: 6%-ийг татварт, 6%-ийг тус наймааг бүртгүүлэх хуульчдад төлөх ёстой. Мөн үл

хөдлөх хөрөнгийн зуучлагчийн үйлчилгээ борлуулсан үнийн 1.5%-тай тэнцдэг байхад АНУ-ын Сент Луис хотод яг ижил наймаа борлуулалтын үнийн 1.5%-тай тэнцэж, зуучлагчийн хөлс (хэрэв хөлсөлсөн бол) 6%-тай тэнцүү байдаг юм байна. Мөн үүнтэй ижил наймаанд Египетэд АНУ-аас 8 дахин их зардалтай байна”.

Харин үл хөдлөх эд хөрөнгө устаж үгүй болсон тохиолдолд өмчлөх эрхийн улсын бүртгэлийг хаах бөгөөд энэ нь нэг сарын дотор шийдэгддэг. **Учир нь эрхийн бүртгэлийг хаах тушаал нь сардаа нэг удаа л гардаг.** Тиймээс түүнийг хүлээхээс өөр аргагүй болдог. Өмчлөх эрх нь баталгаажсан эд хөрөнгө арилжаалагдах болбол арилжих гэрээг (мэдүүлэг гаргаж) эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх эрхийн гэрчилгээ авснаар шинэ өмчлөгчийн эрх баталгаажна. Мөн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад бэлэглэх тохиолдолд гэрээг зайлшгүй бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэний дараа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн албанд бүртгүүлсэнээр гэрээ хүчин төгөлдөр болно. Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалж аль ч банк болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хувь хүнээс зээл авах эрхтэй. Барьцааны гэрээгээ нотариатаар гэрчлүүлж тус байгууллагад бүртгүүлсэн тохиолдолд байгуулсан гэрээ нь сая хууль ёсны хүчин төгөлдөр байна. Хэрэв энэ шаардлагыг биелүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бус болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн газар нь мэдэээлийн сантай бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж авах, барьцаалан зээл олгохдоо өмчлөгч болон хамтран өмчлөгч хэн болохыг, урьд нь барьцаалагдсан эсэхийг тодруулах шаардлагатай бол лавлагаа өгдөг.

Газар нь сонгодог утгаараа үл хөдлөх хөрөнгө юм. Үүнийг хуульчлахын тулд эхлээд тус эрхийг Үндсэн хуульд 1992 онд баталгаажуулан, 1994 онд иргэний хуулинд өөрчлөлт оруулж, Газрын тухай хууль

гаргасан юм. Өнөөдөр Монгол Улсад газрын харилцааг дээрх хуулиудаас гадна

- “Хамгаалалттай газрын хууль” (1995)
- “Газрын түрээсийн хууль” (1997)
- “Газар хувьчлалын хууль” (2003)
- “Ойн тухай хууль” (1995)
- “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” (1995)
- “Үл хөдлөх хөрөнгийн хууль” (1997)
- “Ашигт малтмалын хууль” (1997)
- “Газрын кадастрын хууль” (1999)
- “Үл хөдлөх хөрөнгийн татварын хууль” (2000)

болон бусад холбогдох хууль, тогтоол зохицуулж байгаа юм. Үүнд:

- Газар зохион байгуулалт хийх журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт/.
- Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ /ЗГ-ын 2003 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт/.
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал.
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгахад төлөх хураамжийн хэмжээ /ЗГ-ын 2003 оны 205 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт/.
- Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт/.
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт/.
- Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт/.

- Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/.
- Газрын тухай.
- Газрын төлбөрийн тухай.
- Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай.
- Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай.
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээ /ЗГ-ын 2003 оны 103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/.
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт/.
- Аргачлал, үнэлгээ батлах тухай /ЗГ-ын 2003 оны 103 дугаар тогтоол/.
- Геодези, зураг зүйн тухай.
- Аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд хэмжээ /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт/.
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай.
- Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал /ЗГ-ын 2003 оны 103 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт/.
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай.
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай.
- Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам /ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт/.

- Хураамжийн хэмжээг тогтоох тухай /ЗГ-ын 2003 оны 205 дугаар тогтоол/.
- Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол/.
- Төрийн албаны тухай.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай.

Монгол Улсад хувь хүмүүс биш өрх газрыг өмчилж болно. Мөн өрх болон бизнесийн нэгжүүд газрыг 15-60 жилээр түрээсэлж болно. Гадаадын нэгжүүд газрыг зөвхөн түрээслэх эрхтэй.

Гэвч газар болон үл хөдлөх хөрөнгийн өмчийн асуудал эцэслэн цэгцлэгдээгүй байгаа болохоор үл хөдлөх хөрөнгө болон газрын зах зээл удаан хөгжиж, хот төлөвлөлт болон гэр хорооллын тохижуулалтын асуудлууд шийдэгдэхгүй удаж байна. Зөвхөн 2006 онд нийслэлийн захиргаа аж ахуйн зориулгатай зарим газрыг анх удаа дуудлагын худалдаанд оруулав. Гадаадын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Монголын үл хөдлөх хөрөнгө болон газрын өмчлөлийн хуулиуд олон бүрхэг зүйлтэй байгаагаас болж хэрэгжилт нь тууштай биш, мөн газрын маргааныг шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.²⁰ Түүний нэг жишээ нь малын бэлчээр ашиглалтын асуудал мөн. Энэ асуудал шийдэгдээгүй байгаа учраас бэлчээрийн даацаас илүү ихээр ашиглах асуудал сүүлийн үед гарч байна.

Мөн ашигт малтмалтай холбоотой маргаанууд нинжа хэмээх хувиар олборлогчид, орон нутгийн засаг захиргаа ба ордын ашиглалтын лиценз авсан компаниудын хооронд ихээр үүсэх боллоо. Газар хувьчлал болон зам, дэд бүтэц сайтай, ус, худагтай, байгалийн үзэсгэлэнтэй

газруудын төлөөх өрсөлдөөн, маргаан дэгдэх боллоо.

Үүнээс болж Херитэж сангийн индекст Монгол Улс өмчийн эрхийн үзүүлэлтээр доогуур үнэлгээ авсан байсан.²¹ Тус судалгааг Монгол Улсад хувийн өмчийг хамгаалах хуулийн үйлчлэл, албадлага султай, шүүхийн үйл ажиллагаанд арилжааны зарчмуудыг баримталдаггүй, үүнээс гадна бизнесийн үр ашгийг алдагдуулж байдаг авилга нэмэгдэж байгаа зэрэг хуулийн зохицуулалт сул байгааг тэмдэглэсэн байгаа. Энэ нь нэг талаас өмчийн эрхийн хамгаалалтыг дурдсан дүгнэлт боловч нөгөө талаас ерөнхийдөө Монголын хууль дээдлэх байдал, албан журам, хуулийн биелэлтийг шүүмжилсэн хэрэг мөн.

Үүнийг харуулсан баримт ч хангалттай олон байна. Тухайлбал “Монгол Улсын Шүүхийн Шийдвэрийн Эмхтгэл (Иргэний хэрэг)”-ийн цуврал 2-т дурдагдсан “эзэмших, өмчлөх эрхтэй холбоотой шүүхийн шийдвэр” 41 ширхэг байгаагаас 16 нь өмнөх шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 9 нь өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгожээ.

Иргэн Б. Баянгол дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ манай байгууллага 1999 онд татан буугдаж надад байгууллагын зүгээс урьд нь ажиллаж байгаад гарсан Ж-ийн байрыг хуваарилсан юм. 1999 оны 6-р сард уг байрыг хувьчлан авч, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ миний нэр дээр олгогдсон. Миний өмчлөх эрхийн гэрчилгээтэй дээрх байранд М. нь ямар нэгэн өмчлөх эрхийн гэрчилгээгүй өнөөг хүртэл хууль бусаар амьдарч байна. Иймд дээрх байрнаас М.-ийг нүүлгэн гаргаж өгнө үү гэжээ.

Хариуцагч М. шүүхэд гаргасан хариу тайлбартаа би 1994 оны 9-р сард орон сууцыг Ж.-ээс тухайн үеийн 2 өрөө байрны ханшаар

²⁰ Property Rights and Land Privatization: Issues for Success in Mongolia, Dr. Gregory Myers, Land Tenure Specialist, USAID/Washington, EGAT/LRMT, Peter E. Hetz, Land, Environment and Natural Resources Specialist, ARD, Inc., Burlington, Vermont, December 2004

²¹ Херитэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индекс 2006

1.5 сая төгрөгөөр худалдан авсан. Байранд засвар хийгдээгүй байсан тул зайлшгүй засвар хийж орсон. Иймд надад учирсан бодит хохирол 7 094 800 төгрөгийг Ж.-ээс гаргуулж өгнө үү гэжээ.

Баянгол дүүргийн шүүх Иргэний хуулийн 262 дугаар зүйлд зааснаар орон сууцнаас хариуцагч М-ийг нүүлгэн гаргуулж, Иргэний хуулийн 229 дүгээр зүйлд зааснаар гуравдагч этгээд Ж-ээс 3 375 250 төгрөг гаргуулан хариуцагч М-д олгох, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 3 719 055 төгрөгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Харин Нийслэлийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгож, буцаахаар шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэгч Б. магадлалыг эс зөвшөөрч УДШ-д хяналтын журмаар гаргасан гомдолдоо миний нэхэмжлэлийг дүүргийн шүүх бүтэн нэг жил хянан шалгасны үндсэн дээр зөв шийдвэр гаргасныг Нийслэлийн шүүх 20 минутын хуралдаанаар хууль зөрчиж хүчингүй болгосон гэж үзэж байна гэжээ.

УДШ гомдлыг хянан үзээд Нийслэлийн давж заалдах шатны шүүх гуравдагч этгээд Ж-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг шүүх шийдвэрлээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн гэж шийдвэрийг хүчингүй болгосон нь үндэслэлгүй болжээ гэж дүгнээд магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэжээ.

Өмчийн хамгаалалт нь сайн биш байгааг олон улсын судлаачид тэмдэглэсэн байна. Тухайлбал АНУ-ын Элчин сайдын яам жил бүр хэвлэн гаргадаг “Country Commercial Guide”-ын 2005 оны илтгэлдээ Монголын тухай ингэж бичсэн байна: “...Маш олон шүүгч арилжааны зарчмыг үл ойшоодог хэвээрээ. Тэд энэхүү концепциудыг гэрээний үнэт зүйл гэж үзэн орхигдуулдаг. Энэ нь хуулийг буруу тайлбарласнаас үүдэлтэй асуудал юм. Хэд хэдэн тохиолдолд

шүүх нь түрээслэх болон зээлийн гэрээтэй холбоотой зүйлийг буруу тайлбарласан. Шүүгчид нь өөрсдийн шийдвэртээ гэрээний нөхцлийг байнга үгүйсгэдэг. Хэрэв хэн нэгэн зээлээ төлж чадахгүйд хүрвэл шүүх зээлдүүлэгчийн аливаа алдагдлыг нөхөн төлөхийг шаардахгүйгээр хөрөнгийг нь буцаачихдаг...” гэж бичжээ. Энэхүү баримтад үндэслэсэн тайлан, илтгэлүүдэд манай улсын эдийн засгийн эрх чөлөөг энэ салбарт хангалтгүй байгаа хэмээн дүгнэсэн байдаг.”

5.4 ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Энэ хэсэгт бид Монголын нөхцөлд хуулийг дээдлэх ёс, бизнесийн эрх зүйн орчин мөн институцийн эдийн засгийн чухал ойлголт болох гэрээний биелэлт ба түүнтэй холбоотой асуудлуудыг авч үзэх болно.

Эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой ихэнх зөрчлийг Монгол Улсад иргэний хуулиар хэлэлцдэг бөгөөд түүнд компани хоорондын маргаан, гэрээний биелэлтийн асуудал зэргийг оруулсан байдаг. Ийм төрлийн хэргүүдийн 2002-2004 оны статистик Хүснэгт 5.5. байдалтай байна.

2002-2004 онуудын эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хэргүүдийг авч үзэхэд, нийт хэргийн тоо 2002-2004 онуудад буурсан байхад газар өмчлөлийн хуулиар шийдэгдсэн хэргийн тоо 24%-иар, компаний тухай хуулиарх 2 дахин, даатгалын хуулиарх 3 дахин өссөн. Зах зээлийн эдийн засаг хөгжих тусмаа бусад бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төрлийн хэргийн тоо эрс өссөн байна. Үүнд хууль хэрэгжилтийн байдал чухал ач холбогдолтой болж байгаа юм. Өөрөөр хэлбэл хэрэг үүсч, түүнийг хуулийн дагуу шийдвэрлэсэн ч шүүхийн байгууллагын шийдвэр хэрэгжүүлэх үйл явц нь их төвөгтэй байгааг Дэлхийн Банкны “Бизнесийг

Хүснэгт 5.5. Монгол улс дахь гэмт хэргийн төрөл 2002-2004

№	Гэмт хэргийн төрөл	2002		2003		2004	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Албан тушаалын гэмт хэрэг	36	0.4	19	0.3	19	0.3
	Иргэний хэрэг	24100		23407		23290	
2	Хөдөлмөрийн хуулиар	920	3.82	819	3.50	591	2.54
3	Газар өмчлөлийн хуулиар	33	0.14	58	0.25	41	0.18
4	Компаний тухай хуулиар	6	0.02	24	0.10	11	0.05
5	Нийгмийн даатгалын хуулиар	40	0.17	242	1.03	122	0.52
6	Төрийн албаны	11	0.05	20	0.09	-	
	Захиргааны хэрэг					116	
7	Татварын хуулиар	-	-	-	-	13	11.2
8	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	-	-	-	-	6	5.2
9	Ашигт малтмалын тухай хуулиар	-	-	-	-	6	5.2
10	Газрын тухай хуулиар	-	-	-	-	20	17.2
11	Эд хөрөнгө өмчлөх эрх, улсын бүртгэлийн тухай хуулиар	-	-	-	-	6	5.2

хэрхэн хийдэг вэ” гэсэн судалгаа харуулж байгаа юм. Тэр судалгаагаар Монгол Улсад гэрээний биелэлтийг хэрэгжүүлэх нь харьцангуй хэцүү бөгөөд зардал өндөртэй байдаг байна.

Шинэ Зеландад гэрээний хэрэгжилт 50 өдрийн дотор 19 алхмыг хийж, гэрээний өртгийн дөнгөж 4.8%-тай тэнцэх хэмжээний зардлыг гаргадаг байна. АНУ-д энэ үйл ажиллагаанд 250 өдрийг зарцуулдаг хэдий ч 17 алхмаар гэрээний өртгийн 1.5%-тай тэнцүү хэмжээний зардлыг гаргадаг байна. Гэтэл Монголд гэрээг хэрэгжүүлэхэд 314 өдөр шаардагдах 26 алхмыг хийх ба үүнд гэрээний өртгийн 22.6%-ийг зарцуулдаг байна. Энэ үзүүлэлтээр Монгол нилээд доогуур, Беларусь зэрэг улстай ижил байна. Иймээс уг зардлыг бууруулж, цаг хугацаа хэмнэхийн тулд албан ёсоор хуулийн байгууллагуудад хандалгүйгээр хуулийн бус хүрээнд шийдвэрлэх явдал

түгээмэл байдаг ба зарим тохиолдолд энэ нь асуудлыг улам ээдрээтэй хүндрэлтэй болгодог байна.

Үүний нэг жишээ бол 2004 онд Хятадын хөрөнгө оруулалттай Монгол барилга компани Монгол улсын иргэн У-аас Улаанбаатар хотод байршилтай хоёр давхар албан конторын зориулалт бүхий барилгыг түрээслэн үйл ажиллагаа явуулж байжээ. Дээрх хоёр талын хувьд түрээсийн гэрээг хуулийн дагуу хийж баталгаажуулсан ба Монгол барилга компани сүүлийн хоёр сарын түрээсийн төлбөрөө хугацаанд нь хийгээгүйгээс зөрчил үүссэн байна. Гэрээнд зааснаар төлбөрийг хийх хугацаанаас 10 хоног хэтэрсэн тохиолдолд эхлээд алданги тооцохоор заасан байсан ба нэхэмжлэгч тус компаниас алдангитайгаа нийлээд 3200 америк доллар буюу тухайн үеийн дундаж ханшаар 3 сая 616 мянган төгрөг нэхэмжлэх

ёстой болсон байна. Гэрээнд заасны дагуу иймэрхүү асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх байсан боловч түрээслүүлэгч өөрийн зүгээс арга хэмжээ авч түрээслүүлж буй барилгын цахилгааны шугамыг салгуулснаас зөрчил үүссэн байна.

Иргэн У. яагаад гэрээнд заасны дагуу хуулийн байгууллагад хандсангүй вэ? Мэдээж энэ нь трансакцийн зардалтай холбоотой юм. Учир нь энэ гэрээний биелэлтэд гарсан зөрчлийг шийдвэрлүүлэхийн тулд маш их хугацаа, зардал гаргах байсантай холбоотой юм. **Иймэрхүү хэргийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргахад хэрэг нь анхан шатны шүүхэд хамгийн багадаа 45 хоногоос хойш шийдвэрлэгдэх ба нэхэмжилсэн хөрөнгийг сайн дураар барагдуулах хугацаа нь бас 45 хоног байх ба хэргийн ачаалал зэргээс хамаарч үүнээс ч илүү хойшилдог байна. Мөн сайн дураараа барагдуулах хугацаандаа төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд төлөлтийн хугацаа үүнээс ч илүү сунжирна. Харилцан тохиролцоогүй тохиолдолд ахин 2 шатны шүүхэд хэргийг дахин хянуулах ба энэ тохиолдолд тухайн жил дотроо ч хэрэг шийдвэрлэгдэхгүй байх магадлалтай. Мөн нэхэмжлэгч нэхэмжилж буй мөнгөн хөрөнгийн тодорхой хувийг буюу энэ тохиолдолд $30000+36624=66624$ төгрөгийг нэмж улсын тэмдэгтийн хураамжид төлөх шаардлагатай болно. Үүнээс гадна бусад явдал чирэгдлийн зардалтай нийлээд нэхэмжлэгч өөрийн хүссэн хэмжээний мөнгөө олж авч чадахгүйгээс болж дээрх шийдвэрийг гаргасан байна. Жишээ нь уг хэрэг тухайн жилд шийдвэрлэгдэж амжихгүй бол энэ оны инфляцийн түвшин 11% байсныг тооцвол нэхэмжилсэн мөнгөн хөрөнгийн жилийн дараахь бодит өртөг нь хамгийн багаар бодоход 3 сая 258 мянган төгрөг болно гэвэл зөвхөн үүний алдагдсан боломжийн өртөг нь 358 мянган төгрөг болж байна.**

Гэтэл бас энэ тохиолдолд түрээслэгч компани цахилгааныг тасалж үйл ажиллагааг

нь алдагдуулсан хэмээн нэхэмжлэл гаргаж болох боловч анхны нэхэмжлэгчийн хариуцагчийн зүгээс гарсан түрээсийн төлбөрийг барагдуулахтай холбоотой шүүх үйл ажиллагааны зардлыг төлөхөөс татгалзан мөн л хуулийн бус хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн байна.

Дээрх компаниудаас авсан санал асуулгуудаас харахад ч бас гэрээний биелэлттэй холбоотой зөрчлүүдийг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээс өөрсдийн хүчээр шийдвэрлэхийг илүүд үздэг нь харагдаж байна. Зарим нь гэрээний биелэлтийг хангахын тулд гэмт хэргийн бүлэглэлүүдэд ч хандах тохиолдол гардаг байна.

Жишээ нь иргэн Б. 2003 оны 10 дугаар сард бизнесийн үйл ажиллагаа явуулах нэрээр банкнаас зээл авахын тулд найз Ч-ийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байрыг зээлийн барьцаанд тавьжээ. Зээл төлөлтийн хугацаа болоход зээлийн эргэн төлөлтийг хийгээгүйгээс иргэн Ч-ийн байр банкны зээлийн барьцаанд хураагдах болсон байна. Мөн л шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхэд чирэгдэл ихтэй, зардал өндөртэй гэж үзэн таньдаг хүмүүсийн зөвлөсний дагуу “рекетлэгч” гэгдэх хэсэг залууст хандсан байна. Тэдний ажлын хөлс нь хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх зардлаас бага байсан ба үүнээс өөр трансакцийн зардал бараг үүсэхгүй, цаг хугацаа хэмнэх тул ийм шийдвэр гаргасан байна.

Гэтэл нөгөө талаар шүүх байгууллагад танилтай хүмүүс харин иймэрхүү хэргийг нэг сарын дотор ч шийдвэрлүүлээд хөрөнгөө гаргуулж авах тохиолдол байдаг байна. Уг нь ямар ч тохиолдолд хууль, дүрэм нь зөвхөн танил талын хүрээнд бус нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхийн тулд, трансакцийн зардлыг хамгийн бага байлгахын тулд зохиогддог баймаар. Гэтэл хууль, эдийн засаг гэсэн ойлголт нь салангид явдаг, хүмүүсийн эдийн засгийн

сонирхолд хуулийн заалтууд нь нийцэхгүй байгаа зэргээс далд эдийн засаг хүчээ авах, хээл хахууль, авилга өргөжин улмаар энэ нь нийгмийн хэвийн үзэгдэл мэт болж байна.

Авсан санал асуулгуудаас харахад гадаадын хөрөнгө оруулалттай, гадаадын иргэдийн эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд гэрээтэй холбоотой зөрчлүүд ихээр гардаг байна. Монголд үйл ажиллагаа явуулдаг ихэнх гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг ба түрээсийн гэрээтэй холбоотой зөрчлүүд дийлэнх нь байдаг байна. Энэхүү зөрчлүүд нь гэрээг биелүүлэх явцад талууд гэрээг зөрчсөнөөс, зайлшгүй тусгагдах заалтуудыг орхигдуулснаас, гэрээний талаар бүрэн дүүрэн мэдлэг мэдээлэл байдаггүйгээс болдог байна. Мөн хоёр улсын хуулийн ялгаатай заалтаас, үг хэллэгийн буруу орчуулгаас хүртэл зөрчил үүсдэг байна. Жишээ нь Хятадын хөрөнгө оруулалттай нэгэн компанийн гэрээг орчуулахдаа “алданги” гэсэн утгатай үгийг “торгууль” гэж орчуулснаас болж нэхэмжлэх мөнгөн хөрөнгийнхөө дөнгөж арван хувийг л шүүхийн шийдвэрээр гаргуулж авсан байна. Учир нь Монгол Улсын холбогдох хуулиар торгуулийг ганцхан удаа л төлдөг гэсэн заалттай байдаг байна.

Гэрээний биелэлттэй холбоотой хэргүүдийг шүүхээр хянан шийдвэрлэсэн явцыг харахад нилээд олон тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх цуцалсан байна. Цуцалсан гол шалтгаан нь баримт мэдээллийг доод шатны шүүх сайн хянаагүй, хэргийн бүрдүүлэлт дутуу байсан гэсэн шалтгаанууд байгаа нь доод шатны байгууллагууд хэрэг бүрдүүлэлт, шийдвэрлэлтэд хөнгөн хуумгай ханддаг болон үүнийхээ төлөө ямар нэгэн хариуцлага хүлээдэггүйтэй холбоотой байж болох юм. Энэ байдал нь цөөн тоотой байдаг дээд шатны шүүх байгууллагуудын ажлын ачааллыг нэмэгдүүлж хэрэг шийдвэрлэлтийн

үйл явцыг удаашруулж алдагдсан боломжийн өртгийг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна.

Гэрээний биелэлтэд гарч байгаа бусад түгээмэл зөрчил нь хувь хүмүүс хууль дүрэм, журмаа мэдэхгүй байгаагаас үүсч байна. Жижиг аж ахуйн нэгжүүдээс авсан ярилцлагаас харахад зөрчил үүсэхэд ихэвчлэн хэнд хандахаа мэдэхгүйгээс болоод үйл ажиллагаагаа чирэгдэл ихтэй болгож трансакцийн зардлаа хиймлээр өсгөдөг нь тодорхой байна. Харин томоохон нэгжүүдийн хувьд энэ асуудал бараг гардаггүй нь хувийн хуулийн зөвлөлтэй байдагтай нь холбоотой. Мөн бизнес эрхлэгчдийн хувьд зохицуулалтын дарамтын нэг хэлбэр бол хууль, журмын тухай мэдээллийг олж авахад бэрхшээлтэй байдаг гэж үзсэн хүмүүс харьцангуй олон байдаг юм байна: “2002 онд судалгаанд хамрагдагсдын 26.6 хувь нь бизнесийн холбогдолтой хууль, тогтоомжийг олж авахад ихэнх тохиолдолд хялбар байдаг, 42.0 хувь нь дундаж түвшинд байдаг гэж үзэж байсан бол 2004 онд 23.4 хувь нь ихэнх тохиолдолд хялбар, 34.0 хувь нь дундаж түвшинд байна гэж үзсэн байна. Түүнчлэн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийг олж авахад хүндрэлтэй гэж үзэх нь 2002 оныхоос 19.4 нэгжээр өссөн нь хэдийгээр Соросын сан болон бусад олон улсын байгууллагын санхүүжилтээр төр засгийн газрын байгууллагуудын WEB хуудсуудыг интернэтэд байршуулан хууль тогтоомжуудыг агуулсан мэдээллийн санг бий болгосон боловч түүнийг нийтэд таниулах талаар анхаарах хэрэгтэй гэдгийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 8.9 хувь нь бизнесийн үйл ажиллагаатай нь холбоотой хууль, дүрэм, журамд өөрчлөлт орох эсэхийг бүрэн мэдэх бололцоотой, мөн 8.9 хувь нь ихэнх тохиолдолд мэдэх бололцоотой гэж тус тус үзсэн бөгөөд 28.9 хувь нь ямар нэг хэмжээгээр урьдчилан мэдэх бололцоотой

гэсэн бол 26.7% нь ихэнх тохиолдолд урьдчилан мэдэхэд хэцүү, 20.0 хувь нь мэдэх боломж бараг байхгүй гэж хариулсан байна.”

Бизнес эрхлэгчдийн хүсч буй зүйл нь хуулийг ил тод байлгах, хуулийн зөвлөгөө өгдөг газрууд нь энэ чиглэлээр ч бас үйлчилж баймаар байна гэсний дагуу хуулийн зөвлөгөө өгөх төвүүдээс асуухад өөрсдийнх хүссэний дагуу бүх л чиглэлээр зөвлөгөө өгдөг гэсэн хариултыг өгсөн нь иргэд, байгууллагууд өөрсдөө энэ талаар лавлахаас төвөгшөөн бүх л зүйлийг бэлэнчлэх гэсэн сэтгэгдэл нь асуудлыг улам төвөгтэй болгодгийг харуулж байна.

Эндээс харахад Монголд эрх зүйн орчин нь харьцангуй баталгаажсан мэт боловч хэрэгжилт нь тааруу байгаа нь харагдаж байна. Үүнээс болж Монголын бизнесийн үйл ажиллагаа ихээхэн эрсдэлтэй бөгөөд илүү их өндөр зардалтай болж байгаа юм. Аливаа бизнесийн үйл ажиллагааг гэрээний дагуу явуулахдаа Монголын бизнесийн байгууллагууд гэрээнд тусгасан боловч хуулийн хэрэгжилт муу байгаагаас бараа үйчилгээний 22.6%-тай тэнцүү хэмжээний зардлыг, бараг бүтэн жилийн хугацаатай алдахад бэлэн байх ёстой гэсэн үг. Уг эрсдлээс хамгаалахын тулд компаниуд бараа үйчилгээний үнээ нэмэхэд хүрч байгаа юм. Үүний нэг жишээ нь зээлийн өндөр хүү юм. Зээл авахдаа зээлдэгчид үл хөдлөх хөрөнгөө барьцаанд тавьдаг боловч зээлийг төлөхгүй байх нөхцөлд зээлийн хүүд эрсдлийн хувь өндөр байдаг. Эсрэгээр, найдвартай зээлдэгч байгууллагад банкууд бага зээлийн хүүгээр үйлчилдэг. Тэгэхээр хуулийн хэрэгжилт, хуулийг дээдлэх ёс зүй хөгжсөн нөхцөлд бизнес дэх трансакцийн зардал буурах боломж бий.

5.5 МОНГОЛ ДАХЬ ИНСТИТУЦИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА: КОМПАНИУДЫН ЖИШЭЭ

Харилцагч талууд хүлээсэн үүргээ биелүүлдэг, гэрээ хэлэлцээрийн журмыг мөрддөг байх нь нэгэн төрлийн институци. Хүн бүр үүргээ биелүүлдэг байхыг зорьж, шаардлагатай нөхцөл байдалд гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хэрэгжүүлдэг механизм байхгүй бол дээрх институци нь сул байх ба эдийн засгийн эрх чөлөө амьдралд хэрэгжих боломжгүй.

Тиймээс хувийн өмчийн эрхийг тодорхойлох, бизнес эрхлэгчдийн эрх зүйн байдлыг хуульчлах, гэрээ хэлэлцээрийн мөрдөлтийг баталгаажуулах хуулийн тогтолцоо буюу институци нь улс орны хөгжил, дэвшилд хамгаас чухал. Илүү сайн хууль, эрх зүйн орчин нь төр засгийн бодлого амжилттай хэрэгжих үндэс суурь болох бөгөөд төрийн сайн бодлого, үйл ажиллагаатай хамтраад эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангах чадвартай билээ. Иргэд нь нийгмийн дүрэм, журмаа сахидаг, хуулиа биелүүлдэг байх нь чөлөөт зах зээлийг төгөлдөржүүлэх, эдийн засгийн өндөр өсөлтийг хангахад чухал үүрэгтэй юм.

Одоогийн байдлаар Монгол Улсад бизнесийн үйл ажиллагааг явуулахад цэвэр аж ахуйн зорилгоор гарах зардлаас гадна институцийн хөгжлийн дутагдалтай байдал, трансакцийн зардал өндөр байгаагаас болж Монголын бизнесүүд их хэмжээний нэмэлт зардалтай тулгарч, тэр хэмжээгээр Монголын бизнесийн, эдийн засгийн хөгжил удааширч байна.

Түүвэр болгон гоо сайхны үйлчилгээ эрхэлдэг-1, нийтийн хоолны-2, хүнсний бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг-2 (дүрмийн сан нь дунджаар 3 сая төгрөг) аж ахуйн нэгжээс авсан судалгаанд эдгээр байгууллага нь ямар нэгэн хэмжээгээр төрийн үйлчилгээний байгууллагын

дарамтад байнга байдаг ба үүнээс гарахын тулд авилга өгдгөө хүлээн зөвшөөрсөн байна. Учирч буй дарамт нь мэргэжлийн хяналтын байгууллага, татварын болон цагдаагийн байгууллагын зүгээс учирдаг байна.

Судалгаанд хамрагдсан 5 аж ахуйн нэгжийн төлөөлөл нийтээрээ бизнес дэх төрийн оролцоо өндөр байдаг боловч үйлчилгээний чанар муу гэсэн бөгөөд хүнсний худалдаа эрхэлдэг нэг байгууллага нь хүнд суртал их байгааг онцолсон бол өрсөлдөөн ихтэй, ашиг өндөртэй гэж тооцогддог салбар болох нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг 2 байгууллага нь анх үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө авахын тулд таньдаг хүнээрээ дамжуулан авилга өгсөн гэжээ. Эдгээр 2 байгууллагын нэг нь баарны үйл ажиллагаа давхар эрхэлдэг ба түүний хэлснээр гол дарамт нь мэргэжлийн хяналтын байгууллагын байцаагч нарын зүгээс үүсдэг ба тэд харилцааны соёл муутай, ямар нэгэн үндэслэлгүйгээр торгууль оноох нь элбэг байдаг гэж хариулсан.

Мөн үйл ажиллагааг нь зохицуулдаг хууль дүрэм маш олон байдаг нь трансакцийн зардлыг өсгөдөг тул үүнтэй холбоотой харилцааг танил талаараа дамжуулан хийлгэх нь илүү үр дүнтэй байдаг гэжээ. Энэ мэтчилэн ажлаа хийх нэрийдлээр төрийн анхан шатны байгууллагууд нь хүртэл төрийн үйлчилгээг гуйвуулдаг нь авилгын хөрсийг бүрэлдүүлж байна.

Харин 600-800 сая төгрөгийн хөрөнгийн дүрмийн сантай 4 аж ахуйн нэгжээс дээрх судалгааг авахад нэг нь авилга өгөх шаардлага гардаггүй гэсэн бол, нөгөө нь аль болохоор өгөхгүй байхыг хичээдэг гэжээ. Харин үлдсэн хоёр нь авилга өгсөн гэсэн хариулт өгчээ. Эндээс томоохон нэгжийн хувьд мэдээлэл цуглуулах, хууль эрх зүйн орчныг судлах зэрэг трансакцийн зардлын хувь доогуур байдаг нь аливаа зохицуулалтын дарамтад оруулахгүй ч байх боломжтойг харуулж байна.

Жишээ 1.

Хүнсний жижиглэн худалдааны дэлгүүр. Байгуулагдаад 4 жил болж байна.

- Үйл ажиллагаа явуулах газрын зөвшөөрөл авахад 3 сар
- Барилга байгууламжтай болоход 2 долоо хоног
- Бусад үндсэн хөрөнгөтэй болоход 8 сар шаардагдсан.

Анх газрын алба, татварын алба, эрүүл мэндийн хяналтын алба гэсэн шат дамжлагыг дамжин бүртгүүлсэн. Үүсгэн байгуулалтын зардал 1200000 орчим төгрөг болсон. Эдгээрт:

- Хороо, дүүргийн ЗДТГ-тай холбоотой зардлууд
- Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой
- Татварын албадтай холбоотой
- Бусад төрлийн үйлчилгээний байгууллагатай холбоотой зардал
- Бусад явдал чирэгдлийн зардал

Үйлдвэрлэл эрхэлж буй барилга, өмч хөрөнгөө түрээслэдэг бөгөөд түрээслэгчтэй үл ойлголцох бэрхшээл их гардаг. Түрээсийн гэрээгээ биелүүлэх тал дээр хангалтгүй. Тухайлбал дүүргээс ирж хаах тухай асуудал гардаг.

Бизнес эрхлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Татварын дарамт, шахалт, хүнд суртал их байна. Ер нь төрийн оролцоо аль ч салбарт их байна гэж үзжээ.

Жишээ 2.

Гоо сайхан, үйлчилгээ эрхэлдэг ба байгуулагдаад 3 жил болжээ. Түрээсээр ажилладаг. Компани бүртгүүлэхэд дараах шат дамжсан.

- Дүүргийн мэргэжлийн хяналтын алба
- Татварын алба
- Бусад

Ер нь бизнесээ анх эхлэхэд маш хэцүү байсан. Учир нь олон тооны бичиг баримт, зөвшөөрөл, гарын үсэг зуруулахтай холбоотой.

Компани үүсгэн байгуулалтын нийт зардал 100000 төгрөг болсон. Үүнээс:

- Хороо дүүргийн ЗДТГ-тай холбоотой зардлууд буюу зөвшөөрөл авахад 30000 төгрөг
- Улсын бүртгэлийн албатай холбоотой буюу патентын зардал 30000 төгрөг.
- Бусад зардал явдал чирэгдэл 40000 төгрөг болсон.

Жишээ 3.

2002 онд байгуулагдсан Зоогийн газар, баар. Үйл ажиллагаа явуулах газрын зөвшөөрөл авахад 1 сарын хугацаа шаардагдсан. Барилга байгууламжтай болоход 3 сар болсон. 2-3 барилгын компани сольж өөрсдөө барилга бариулсан. Энэ нь манай өөрсдийн өмч гэдэгт бүрэн итгэлтэй байдаг.

Компани үүсгэн байгуулалтын зардал харьцангуй бага боловч нааш цааш явах, олон дахин оочер дугаарт зогсох шаардлага их гарч байсан. Мэргэжлийн хяналтын газраас жилд 2 удаа шалгалт явдаг.

Ерөнхийдөө төрийн оролцоо их байдаг ч үйлчилгээний чанар нь муу. Тиймээс төрийн үйлчилгээний мэргэжилтэнд авилга өгөх шаардлага гарч байсан бөгөөд хүсэлтийг 100 хувь биелүүлсэн гэж үзэж байна.

Санал: Зоогийн газар, үйлчилгээний байгууллагын журамд жижиг том газар гэсэн ангилал зааг гаргаж өгмөөр байна. Ер нь энэ журамд амьдрал дээр хэрэгжих боломжгүй зүйл олон байдаг. Мөн улсын мэргэжлийн хяналтын газрын байцаагч нар харьцааны соёл муутай, элдэв хууль дүрмийн заалтыг хэлэхгүйгээр мөнгөн торгууль тавьдаг. Торгуулийн хуудас олгодоггүй. Ямар хуулийн ямар заалт журмыг зөрчсөн эсэх бодит баримт үлдээдэггүй.

Жишээ 4.

2006 оны 8 сарын 18-нд байгуулагдсан. Эрхэлдэг үйл ажиллагаа нийтийн хоол. Компания үүсгэн байгуулахад дараах хугацаа шаардагдсан.

- Үйл ажиллагаа явуулах газрын зөвшөөрөл авахад 7 хоног
- Барилга байгууламжтай болоход 10 хоног
- Хөрөнгө оруулалт татахад 23 хоног
- Ажилчид сонгоход 45 хоног

Компания бүртгүүлэхэд эхлээд өөрсдөө татварын алба, улсын бүртгэлийн газраар яваад бүтээгүй. Дотор нь ажилладаг таньдаг хүндээ 1100000 төгрөг өгч бүх бичиг баримтаа бүрдүүлсэн. Өөрсдөө эхэлж явахад анхны мэдлэггүй, олон хоног шаардлагатай болсон учир шууд татварын хүнд хандсан. Түрээсийн гэрээтэй. Гэрээтэй холбоотой асуудал үүсдэггүй.

Төрийн үйлчилгээтэй холбоотой бэрхшээл гэвэл олон өдөр чирэгдүүлдэг. Иргэдэд бүртгэл, татвартай холбоотой мэдээлэл өгөх тал дээр анхаарах хэрэгтэй. Хууль, дүрэм зохицуулалт хэт олон. Авилга өгч байсан. Төрийн үйлчилгээний хэлтсийн даргад. Хүсэлтийг 100 хувь биелүүлсэн.

Жишээ 5.

Түрээсээр ажилладаг ТҮЦ. 4 сар ажиллуулж байна. Жижиглэн бараа худалддаг. Түрээслүүлсэн эзэн нь зөвшөөрөл авсан байв. Сар бүрийн 25 гэхэд түрээсээ төлсөн байх ёстой. Ямар нэгэн гэрээ байгуулаагүй. Түрээсээ л төлж байвал ямар нэгэн маргаан үүсдэггүй. Мэргэжлийн хяналтын газар, мөн хогны асуудал хэцүү байдаг.

Жишээ 6.

Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг компани. 1997 оноос хойш үйл ажиллагаа эрхэлж байгаа. Компани үүсгэн байгуулахад 1.5 сар шаардагдсан. Үндсэн хөрөнгөтэй болоход 12-15 сар шаардагдсан. Компани байгуулах нийт зардал 200000 төгрөг. Нийт хөрөнгийн хэмжээ 690 сая төгрөг.

Компаний зөвшөөрөл авахад дүүргийн татварын алба, Улсын бүртгэлийн алба, нотариатын газруудад бүртгүүлсэн.

Худалдаж авсан хөрөнгөө өөрийн өмч гэдэгт бүрэн итгэлтэй байж чаддаггүй. Үүний шалтгаан нь хөрөнгө зээлийн барьцаанд байдаг. Түрээстэй холбоотой зардал хааяа үүсдэг.

Хороо, дүүргийн захиргаа, цагдаагийн байгууллага, өмчийн албатай холбоотой бэрхшээл үүсдэг. Гэрээний биелэлттэй холбоотой бэрхшээлүүд байдаг.

Төрийн үйлчилгээний байгууллагын мэргэжилтэн болон цагдаа, хамгаалалтын байгууллагад авилга өгсөн боловч бусад албаны хүмүүсээс хамаарч 70%-ийн биелэлттэй байсан. Төрийн оролцоо нь бизнесийн үйл ажиллагаанд саад учруулдаггүй боловч түүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэггүй гэж үзсэн.

Жишээ 7.

1991 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн зочид буудал, зоогийн газар, хүнсний дэлгүүр эрхэлдэг. Нийт хөрөнгийн хэмжээ 715 сая төгрөг. Үүний 695 сая төгрөг нь барилгын үнэлгээ. Хөрөнгийн 70%-ийг 1993 оны өмч хувьчлалаар, үлдсэн хэсгийг нь хөрөнгийн биржээр авсан. Хөрөнгөө өөрийнх гэдэгт бүрэн итгэлтэй байдаг. Учир нь хөрөнгө нь хувьцаагаар бүрдсэн.

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахад хагас сар зарцуулсан. Өөрийн гэсэн барилгатай болоход 2 жил зарцуулсан. Компани бүртгүүлэхэд 5-6 үе шат дамжсан.

Өрсөлдөөн ихтэй салбарт үйл ажиллагаа явуулдагтай холбоотой бэрхшээл үүсдэг. Мөн чадварлаг боловсон хүчин дотоодын зах зээлд ховор тул ажиллагсадтай холбоотой асуудал үүсдэг.

Авилга өгөх шаардлага бага байдаг.

Төрийн оролцоо бага гэж үзсэн.

Жишээ 8.

Энэ оноос эхлэн барилгын материалын бөөний худалдаа эрхэлж эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалттай. Компани байгуулахад 91 сая төгрөгийг зарцуулсан ба үүний 90% нь засвар үйлчилгээ болон үндсэн хөрөнгө худалдан авалтын зардал байсан.

Түрээсийн хугацаатай холбоотой түрээслэгчдийн зүгээс бэрхшээл үүсдэг.

Гааль татварын байгууллагын зүгээс дарамт учирдаг. Ажиллагсадтай холбоотой болон гэрээний биелэлттэй холбоотой бэрхшээл үүсдэг.

Төрийн үйлчилгээний албаны ажилтанд авилга өгсөн. Авилга авсан хүн хүсэлтийг 100% биелүүлсэн.

Төрийн оролцоо их биш боловч үйлчилгээ үзүүлдэггүй. Ялангуяа ихэнх үйл явц танил тал, хахуулиар гүйцэтгэгддэг.

Хуулийн биелэлтэд тавих хяналт муу гэж хариулсан.

Жишээ 9.

2000 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Үйл ажиллагааны зөвшөөрөл авахад 2 хоног шаардагдсан. Хөрөнгөтэй болох болон хөрөнгө оруулалт татахад 2 сар шаардагдсан. Бүртгүүлэхэд 3 шаг дамжсан. Компани байгуулах нийт зардал 95000 төгрөг ба нийт хөрөнгийн хэмжээ 800 сая төгрөг.

Хөрөнгөө өөрийн өмч гэдэгт бүрэн итгэлтэй байдаг. Газар нь одоохондоо өмчлөгдөөгүй тул эзэмшигчийн статустай.

Татвартай холбоотойгоор 2 өөр тайлан гаргадаг. (Монголын бизнесийн нэгжүүдийн 90% нь 2 тайлантай байдаг)Худалдан авагчидтай холбоотой бэрхшээлүүд үүсдэг. Гэрээний биелэлттэй холбоотойгоор түншлэгчдийн зүгээс асуудлууд үүсдэг.

Авилгыг аль болохоор өгөхгүйг хичээдэг.

Төрийн оролцоо үйл ажиллагааных нь 70%-д үйлчилдэг. Төрийн зүгээс хууль дүрмээ зах зээлд нь тохируулж цэгцлэх шаардлагатай гэж үзсэн.

Эдгээр жишээний судалгаанаас дараахь зүйлс харагдаж байгаа юм.

Томоохон бизнесийн нэгжүүд нь бизнес явуулах трансакцийн зардлын олох ашгийн түвшинд нь эзлэх хувь бага байдгаас урт хугацаанд үр ашигтай байх боломжтой байдаг байна. Гэтэл жижиг нэгжүүдийн хувьд трансакцийн зардлын түвшин харьцангуй өндөр учраас үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад хүндрэлтэй байдаг байна. Санал асуулгад оролцсон зоогийн газар, баарны үйлчилгээ эрхэлдэг гэгдэх нэг жижиг нэгж “Зоогийн газар, үйлчилгээний байгууллагын журамд жижиг том газар гэсэн ангилал зааг гаргаж өгмөөр байна...” гэсэн нь компаний хэмжээ бизнес явуулахад хэр чухлыг илтгэж байна.

Үүнийг дээрх компаниудаас авсан судалгаанаас харж болно. Судалгаанд хамрагдсан жижиг бизнесийн нэгжүүдийн үүсгэн байгуулалтын албан бус нийт зардал нь дунджаар 200 мянгаас 1 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 10-30% байхад томоохон нэгжүүдийн үүсгэн байгуулалтын албан бус нийт зардал нь 2 саяас 100 сая буюу нийт хөрөнгийн 0.3-12.5%-тай тэнцүү байна.


Санал асуулгад оролцсон жижиг аж ахуйн нэгжүүд бүгд төрийн дарамт өндөр, хууль дүрэм, зохицуулалт ихтэй гэсэн хариултыг өгсөн байсан бол томоохон 4 аж ахуйн нэгжийн нэг нь л хууль дүрэмтэй холбоотой дарамт байдаг гэж хариулжээ. Мөн томоохон гэгдэх 4 компани бизнес дэх төрийн оролцоог өндөр биш гэжээ. Гэвч төрийн зүгээс оролцоо бага, саад учруулдаггүй гэсэн боловч бизнесийг хөгжүүлэх ямар нэгэн хөшүүрэг байдаггүй, төр үйлчилгээгээ үзүүлдэггүй гэж хариулснаас үзэхэд бизнесийн нэгжүүд эрх зүйн орчны дутагдалтай хэсгийг өөрсдийн хүчээр нөхдөг гэсэн дүгнэлтэд хүрч байна. (Зураг 5.6.)

Монголын хувьд трансакцийн зардлын түвшин нь аж ахуйн нэгжийн хэмжээнээс ихээхэн хамаарч байгааг өмчийн эрхийн хамгаалал болон гэрээний биелэлттэй холбоотой асуудлууд дээр гарч ирж байна. Үүнийг дээрх байдлаар зургаар үзүүлж болно. Компаний хэмжээ жижиг байх тусмаа компани үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах, зохицуулалтын дарамттай нөхцөлд ажиллахад ихээхэн бэрхшээлтэй байдаг. Үүнийг эдгээр компани өөрсдийн түвшинд

хахуулиар нөхөж ажилладаг ба эдгээрийн хувьд нэгдүгээрт төрийн оролцоо их байна, хоёрдугаарт, тэр нь голдуу сөрөг талаас байдаг гэсэн сэтгэгдэл төрдөг байна. Харин том хэмжээний компанид эдгээр зардал харьцангуй бага байдаг болохоор бэрхшээл болдоггүй байна. Гэвч том компаниуд өөрсдийн аргаар хуулийн цоорхой эсвэл түүний хэрэгжилтийг нөхдөг байна. Үүний нэг жишээ нь улс төрийн оролцоо юм. Өөрийн компанид ашигтай тендер авах, том

захиалгыг авах, төрөл бүрийн хөнгөлөлтийг эдлэхэд томоохон компаниуд улс төрийн холбоо болон төр засгийн хүчийг дайчилж чаддаг. Үүний нэг жишээ нь САПУ захын хохирогчдын мөнгийг компани нь төрөөс гаргуулж чадсан байхад, яг ижил нөхцөлд хохирсон ХЗХ-ны хөрөнгө оруулагчдад төрөөс хохирлыг барагдуулаагүй. Гэтэл аль ч тохиолдолд төрийн зүгээс хуулийн болон журмын хэрэгжилтийн хяналт нь дутуу байснаас ийм байдал үүссэн гэж хэлж болно.

Зураг 5.6 Компаний хэмжээ ба трансакцийн зардал Монголд



6. Дүгнэлт

Энэхүү тоймын ерөнхий судалгааны хүрээ, концепцийг дараахь байдлаар дүгнэж болно. Эдийн засгийн эрх чөлөө эдийн засгийн өсөлт, хүний хөгжилд ихээхэн ач холбогдолтой болох нь олон судалгаагаар тогтоогдсон байдаг. Тоймд эдийн засгийн эрх чөлөөний ач холбогдлыг авч үзэж, Монголын эдийн засгийн эрх чөлөөний өнөөгийн байдлыг дүгнэж гаргасан. Монгол улс 1990 оноос хойш төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийг даван туулан эдийн засгийн өсөлтийн үе рүү шилжиж, нийгмийн анхаарал эдийн засгийн өсөлтийг түргэтгэх замаар ядуурал, ажилгүйдэл, хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд хандаж байна, гэвч түүний эдийн засгийн эрх чөлөөний байдал төдийлөн сайжрахгүй байна.

Сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн орчин тогтворжиж, эдийн засгийн өндөр өсөлт ажиглагдаж байгаа боловч ядуурал буурахгүй, орлого улам бүр тэгш бус хуваарилагдсаар байна.

Судалгаанаас үзэхэд эдийн засгийн өсөлтийн бүтэц нь маш жигд бус, түүхий эд голлох цөөн хэдэн салбарын өргөжилт болон гадаад хүчин зүйлсийн үр дүн болох нь харагдаж байна.

Нэгэнт зах зээлийн тогтолцоо руу эргэлт буцалтгүй орсон Монгол орны хувьд цаашид хөгжихийн тулд зах зээлийн системээ боловсронгуй болгох, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж эдийн засгийн өсөлтийн өндөр хувьд хүргэх нь чухал боллоо.

Эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйлс болох хөдөлмөр, капитал, технологи, байгалийн нөөц баялгийг бүрэн ашиглахын тулд эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлэх, зах зээлийг үр өгөөжтэй ажиллуулах, өөрөөр хэлбэл институцийн хөгжлийг сайжруулах

асуудал зүй ёсоор тавигдаж ирлээ. Тиймээс эдийн засгийн эрх чөлөөний 2006 оны тойм нь Монгол улсын институцийн хөгжлийг чухалчлан авч үзэж байна.

Судалгааны багууд Монгол дахь өнөөгийн институцийн хөгжлийг судлан, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг нь нэг нэгээр авч үзэж, Монголын институцийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг хэрхэн түргэтгэх боломж байгааг загварын хүрээнд тогтоож, шинээр Монголын трансакцийн зардлыг (Уоллис Нортон аргачлалын дагуу) тогтоож, судалгааг гүйцэтгэсэн. Монгол Улсын хувьд трансакцийн зардал нь өөрийн хөгжлийн түвшинд зохих хэмжээнээс хамаагүй өндөр байгаа нь тогтоогдсон. Ийнхүү трансакцийн зардал нь өндөр байгаад нь өмчийн эрх, гэрээний биелэлтийн асуудлууд, бизнесийн салбар дахь зохицуулалтын дарамт, засаглалын чанар муудаж байгаа зэрэг хүчин зүйл нөлөөлж байгаа бөгөөд энэ байдлыг Монголын институцийн хөгжлийн талаарх хийгдсэн сүүлийн үеийн нилээд олон судалгаа давхар нотолж байгаа билээ. Үүний зэрэгцээ өнөөдөр манай улсын эдийн засгийн гол хөдөлгүүр нь хувийн секторын үйл ажиллагаа болсон боловч бизнес эрхлэгчдэд төрөл бүрийн саад бэрхшээл тулгарсаар байна. Ялангуяа төрийн зүгээс хэт их зохицуулалт, авилга газар авсан явдал ажиглагдаж, бизнесийн хууль, эрх зүйн орчин боловсронгуй бус байгаа нь хувийн хэвшлийн хөгжлийг сааруулж, үр дүнд нь нийт эдийн засгийн өсөлт, хөгжил удааширч байгаа юм.

Энэ судалгааны нэг чухал үр дүн нь хувийн хэвшлийн хөгжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөг өргөтгөх, институцийн хөгжлийг сайжруулахын тулд бид хуулийг дээдлэх ёсыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийсэн явдал юм. Монголын институцийн судалгааны нийтлэг зүйл нь Монголд хуулийг дээдлэх ёс маш

ихээр дутагдаж байгааг харууллаа. Үүнийг Монголын нөхцөлд ажиллаж байгаа компаниуд өөрийн аргаар зохицуулж эхэллээ. Авилга болон бизнес улс төрд оролцох явдал Монголын институцийн системийн дутагдал, хуулийн хэрэгжилт муу байгаагийн гол үр дагавар гэж үзэж болно. Энэ нь асар их илүү зардлыг бий болгож, Монголын хувийн хэвшлийн өсөлтийг удаашруулж байна.

Институцийг хөгжүүлснээр бид өнөөгийн үйлдвэрлэлийн орцын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр илүү өндөр ДНБ-д хүрэх боломж байгаа нь харагдлаа. Энэ нь зах зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар нөөцөө бүрэн дүүрэн ашиглах, үр өгөөжтэй эдийн засгийг бий болгох, үр ашиггүй зардлаас салах замаар гарч ирсэн нийгмийн нөөц, боломжууд юм.

Хууль эрх зүйн орчноор баталгаажсан нийгэм илүү өндөр хурдтай хөгжиж, ард иргэд нь сайн сайхан амьдралтай болдгийг олон зуун жилийн түүх баталж байна. Улс орнуудын туршлагаас харахад амжилттай хөгжихөд нөлөөлсөн гол зүйл нь институцийг бүрэлдүүлж, эдийн засгийн эрх чөлөөг бизнесийн салбарт олгосон явдал байжээ. Ингэснээр бизнес эрхлэх явцад үүсэх тодорхой бус байдал буурч, эрчимтэй хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдсэн байна.

Фрейзер Институтээс явуулсан 1980-2000 оны 20 жилийн үзүүлэлтэд тулгуурлан хийсэн судалгаанд эдийн засгийн эрх чөлөө нь хөрөнгө оруулалт, өсөлт, орлогын түвшинд хэрхэн нөлөөлдөг талаар “Эдийн засаг нь чөлөөтэй улс хурдан хөгждөг, илүү их хөрөнгө оруулалтыг татаж чаддаг, бүтээмж нь өндөр байдаг” гэсэн. Тэгвэл өнөөдөр манай улсад буй эдийн засгийн эрх чөлөөг ил ба далд аргаар боосон олон төрлийн хүнд суртал, дүрэм журам, төрийн олон шатны авилга нь улс орны хөгжлийг удаашруулж, эдийн засгийн нөөцийн үр

ашиггүй хуваарилалтыг бий болгож байгаа гол шалтгаан юм.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, хөгжлийг түргэтгэх гол арга зам нь бидний үзэж байгаагаар Монголын институцийн хүрээг сайжруулах замаар хувийн хэвшил, бизнесийн нэгжийн бүтээлч үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, урамшуулах орчинг бий болгох, бодлогыг хэрэгжүүлэх явдал юм. Иймээс эрх чөлөөг эдлэхийн тулд хуулийн хүрээнд л үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ёстой. Хуулийг дээдлэх нь хувийн хэвшлийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зардлыг ихээхэн бууруулах замаар Монголын эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, Монгол Улсыг боломжит эдийн засгийн өсөлт рүү ойртуулах болно.

7. Бодлогын зөвлөмж

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хувьд бэрхшээлтэй зүйл их бий. Түүний дотор далайд гарцгүй, Европ, Америк зэрэг томоохон зах зээлээс алслагдсан, байгаль, цаг уурын нөхцөл нь их хэмжээний нэмэлт зардлыг шаарддаг зэрэг байгалийн хүчин зүйлс байдаг. Нөгөө талаас, хэдийгээр Монгол Улс хүн ам цөөтэй, эдийн засгийн чадавх нь сул, хөгжлийн түвшин харьцангуй доогуур байгаа ч зах зээлийн шилжилтийн 15 жилийн явцад эдийн засгаа зах зээлийн системд шилжүүлэх, эрх чөлөөтэй болгох талаар олон бодлогыг амжилттай хэрэгжүүлж, эрчимтэй өсч буй хувийн хэвшлийг хөгжүүлж чадсан ба Монголоос илүү их эдийн засгийн нөөц, боломжтой орнуудаас ч энэ үзүүлэлтүүдээр дээгүүр явж байгааг олон улсын байгууллагууд хүлээн зөвшөөрдөг. Ядуурал, бүс нутгийн тэгш бус хөгжил, ажилгүйдэл зэрэг асуудал байгаа боловч эдийн засгийг бүхэлд нь зах зээлийн систем рүү шилжүүлж, дагалдах эрх зүйн орчинг бүрдүүлэн, макро эдийн засгийн хүрээнд тогтворжуулалтыг бий болгож улмаар өсөлтийн шат руу орсон зэрэг нь Монголын хувьд томоохон амжилт. Энэ нь институцийн хөгжил байгалийн хүчин зүйлсээс илүү нөлөөтэйг харуулж байгаагийн нэг илрэл гэж хэлж болно. Тэгвэл Монгол Улсын хувьд цаашид эдийн засгийн өсөлтөө түргэтгэх, дээр дурдсан асуудлуудыг шийдэхэд институцийн ямар өөрчлөлт, хөгжил хэрэгтэй вэ?

2006 оны Эдийн Засгийн эрх чөлөөний тоймын гол сэдэв нь институцийн хөгжил эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөөний судалгаа болохоор эдгээр зөвлөмж институцийг боловсронгуй болгосноор эдийн засгийн өсөлтийг хурдасгах ямар боломж байгааг харуулах юм.

Өнөө үед Монголын хөгжил, эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр нь хувийн хэвшил болсон тул Монголын цаашдын эдийн засгийн өсөлт, хөгжил хувийн

хэвшлийн өсөлт, хөгжилтэй салшгүй холбоотой болж байгаа нь ойлгомжтой. Иймээс гол зөвлөмжүүд институци хувийн хэвшлийн үйл ажиллагааг хэрхэн идэвхжүүлж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх талд илүү анхаарч байгаа юм.

Судалгааны дүнг нэгтгэж дараахь зөвлөмжийг гаргаж байна:

1. Засаглалын чанарыг сайжруулах: засаглал эдийн засгийн өсөлт хөгжилд нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Өндөр хөгжилтэй гэгдэх улс орнууд хөгжлийнхөө өнөөгийн түвшинд хүрэхэд нь сайн засаглалын гүйцэтгэсэн үүрэг их. Засаглалын чанар муу байгаагаас хөгжихгүй байгаа улс орнууд ч цөөнгүй. Засаглалыг сайжруулахдаа ялангуяа засгийн газар, төрийн үр ашигтай үйл ажиллагаанд анхаарах нь чухал. Үүнд төрийн аппарат улс төрийн дарамтаас мөн танил талын сүлжээнээс чөлөөтэй байх явдал бас орж байгаа юм. Ингэснээр бизнес, улс төр хоёр хутгалдах явдал багасч, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого аливаа нэг хувь хүн, бизнесийн бүлэглэлийн сонирхолд үйлчлэх бус, нийт нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглэсэн бодлогыг боловсруулж, хууль журмыг дээдэлж, эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөөн илүү нээлттэй болно. 2004 оны байдлаар Монгол дахь засаглалын үзүүлэлтүүдийн дийлэнх муудсан байсан нь түгшүүрийг бий болгож байгаа юм. Судалгаанаас үзэхэд Монгол улсын бизнесийн хөгжилд саад болж буй гол хүчин зүйлүүдэд татварын тогтолцоо, авилга, шударга бус өрсөлдөөн гэх мэтийг аж ахуйн нэгжүүд хамгийн их нэрлэжээ.
2. Хуулийн хэрэгжилтийг сайжруулж, авилгатай тууштай тэмцэх, өмчийн

эрх, хуулийг сахих байдал, гэрээний биелэлтийг сайжруулах. Үүгээр бизнесийн эрсдлийг бууруулж, бизнесийн трансакцийн зардлыг багасгана. Ингэснээр хувийн хэвшилд урьд нь хүнд суртлаас болж алдаж байсан цаг, мөнгө, хахуульд өгч байсан хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх нэмэлт нөөц гарч ирнэ. **Үүнд гол анхаарах зүйл нь өмчийн эрх болон гэрээний биелэлт байна.** Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр, өмчийн эрхийг баталгаажуулах, хамгаалах эрх зүйн орчинг бий болгосон бөгөөд энэ нь зах зээлийн эдийн засагт төрийн гүйцэтгэх үндсэн үүргийн нэг юм. Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн шинж нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн (нөөцийн) хувийн өмчид тулгуурладаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед энэ нь улсын мэдэлд байсан бөгөөд манай улс зах зээлд шилжих хамгийн эхний алхам нь улсын үйлдвэрүүдийг хувьчлахаас эхэлсэн гэж хэлж болно. Хувь хүмүүс өмч хөрөнгө нь гэмт халдлагаас хамгаалагдсан, өөрсдийн өмчөө чөлөөтэй сайн дураараа арилждаг, өрсөлдөөний нөхцөл бүрдсэн үед л эдийн засаг нь эрх чөлөөтэй байна гэж үздэг тул хувийн өмчийн халдашгүй эрх буюу өмчлөх эрх нь эдийн засгийн эрх чөлөөний суурь юм. Тиймээс ч өмчийн эрхийг эдлэх, бусдад шилжүүлэх үед зардал багатай, чирэгдэлгүй байх нь солилцоонд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн хамгийн чухал тулгуур шаардлагуудын нэг билээ.

Монголд аж ахуй, бизнестэй холбоотой хэргийг гэмт хэрэг, захиргааны хэрэг, иргэний хуулиар шийдэх хэрэг гэж олон ангилдаг. Жишээ нь Улсын Дээд Шүүхийн 2005 оны тайлангаас үзэхэд, Газар

өмчлүүлэх тухай хуулиар 33, Дампуурлын хуулиар 6, Компаний тухай хуулиар 15, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн хуулиар 16, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар 18 хэргийг хянан шийдвэрлэсэн ба хахууль авсан хэрэгт 4 хүн, зуучилсан 1 хүнийг эрүүгийн хуулиар шийтгэсэн байна. Мөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн 7, эд хөрөнгө өмчлөх эрхийн тухай хуулиар 6, газрын тухай хуулиар 73, ашигт малтмалын тухай хуулиар 19, татварын ерөнхий хуулиар 25-ыг шийдвэрлэсэн байна²². Ийнхүү хуулиуд болон дагалдах баримт бичгийг нь боловсруулан гаргасан байгаа боловч манай улсын хувьд өмчийн эрхийн хамгаалал нь хангалтгүй байгаа гэсэн гадныхны дүгнэлт тайлан илтгэлүүдэд дурдагдсан байна (Херитэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний тайлан г.м). Иймээс энэ тал дээр анхаарч, арилжааны зарчимд тулгуурласан хууль, шүүхийн тогтолцоог бий болгох хэрэгтэй гэж үзэж байна.

3. Гэрээний биелэлт, түүнийн сахилга батыг хуулиар бататгах, хэрэгжүүлэхэд анхаарах нь нэн чухал болж байгаа юм. Аливаа бизнесийн, эдийн засгийн үйл ажиллагааг гэрээгээр зохицуулдаг өнөөгийн нөхцөлд Монгол дахь гэрээний биелэлтийн ерөнхий байдал тун муу байгаа нь илт байна. Иргэд нь хууль, журмаа сахидаг, хүлээсэн үүргээ биелүүлдэг институци нь эдийн засгийн эрх чөлөө, өндөр өсөлтийг хангах боломжтой юм. Харамсалтай нь манай улсын хувьд хэдийгээр сайн хуулиудтай гэгддэг боловч хэрэгжилт дээрээ тун ч хангалтгүй байдаг. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь гэрээний биелэлт ч хангалтгүй байгааг илэрхийлнэ. Гэтэл зах зээлийн эдийн засагт өмчийн эрхийг шилжүүлэх, өргөн утгаараа харилцааны зохион байгуулалтыг

²² Улсын Дээд Шүүхийн 2005 оны тайлан

дэмжих хамгийн гол зүйл нь гэрээ байдаг. Тиймээс хууль сахиулах институцийг төгөлдөржүүлэхэд төрийн бодлого чиглэгдэх ёстой гэсэн үг юм.

4. Зах зээлийн үйл ажиллагаа, сайн дурын арилжаа, хувийн сонголтыг орлуулах төрийн аливаа зохицуулалт, засгийн газрын хэрэглээ, татвар нь эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж байдаг. Эдгээр хязгаарлалт нь ажил хөдөлмөр эрхлэх болон бизнесийн үйл ажиллагаанд саад болсноороо эдийн засгийн эрх чөлөөг боогдуулдаг байна. Хөдөлмөр, бизнесийн зах зээлийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгож дарамтыг бууруулах нь илүү чухал. Энэ нь авилгатай тэмцэхтэй шууд холбоотой бөгөөд шинээр бизнес нээх ажлыг хөнгөлж, төрөл бүрийн нэмэлт төлбөрийн дарамтыг устгах нь чухал. Үүгээр бизнесийн нэмэлт зардлыг багасгаж, хөрөнгө оруулалтад илүү чиглүүлэх боломж гарна.
5. Авилгатай тууштай тэмцэх явдал. Авилгын уламжлалт тодорхойлолтын (төрийн албан тушаалыг хувийн ашиг хонжооны зорилгод буруугаар ашиглах гэсэн) цаана улс төрчид, өндөр албан тушаалтнууд, хүнд сурталтнуудын ашиг тусын төлөө пүүс компаниудаас авилга нэхэж алгаа тоссон асар урт гар мэт ховдог шунахай төрийн дүр төрх оршиж байдаг. Олон пүүс компани харилцан ашигтай байхын тулд улс төрчидтэй хуйвалддаг нь нотлогдсон учраас хувийн компаниудын гүйцэтгэх чухал үүргийг харгалзах замаар авилгад тавих анхаарлыг тэнцвэржүүлэх шаардлагатай. Үүнээс улбаалан хөрөнгө оруулалтын уур амьсгалын тухай уламжлалт үзлийг ч бас эргэн

харах нь туйлын чухал. Нэн ялангуяа бодлогын ба институцийн үр дүнгүүд, түүний дотор зохисгүй нөлөө үзүүлэхэд улс төрийн санхүүжилтийн гүйцэтгэх үүрэг талаас нь авч үзвэл, бизнесийн ба улсын салбаруудын хоорондын харилцааны амин судас нь улс төр дэх мөнгө болж байна.

Дээр дурдсан 5 зөвлөмж нийт Монголын институцийн хөгжлийн тулгуур хүчин зүйлүүдийг хамарч байгаа бөгөөд эдгээр дутагдлыг арилгаж чадвал Монголын хувийн хэвшил цаашид улам эрчимтэй өсөх, илүү үр өгөөжтэй ажиллах нь тодорхой юм. Хуулийг дээдлэх орчин, институцийг бүрэлдүүлж, эдийн засгийн эрх чөлөөг бизнесийн салбарт олгосноор бизнесийн явцад үүсэх аливаа харилцаа, солилцооны зардал буурч, хувийн сектор эрчимтэй хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх нөхцөл бүрддэг. Эдгээр зардлыг бууруулахад төрийн бодлого, үйл ажиллагаа чухал ач холбогдолтой.

8. Ҳавсрапт

1. Хавсралт: «Transparency International» байгууллагын «Corruption Perception Index - CPI» индексийг тооцох аргачлал

Стандарчлал. Эх үүсвэр бүр өөрийн гэсэн хэмжилтийн систем ашигладаг учраас тухайн нэг улсын дундаж утгыг тодорхойлоход эхлээд өгөгдлүүдийг стандарчлах шаардлага гарна. Стандарчлах процесс хоёр алхамтай.

Алхам 1.

Өмнөх жилийн тайланд орсон хуучин эх үүсвэрүүд стандартчилагдсан учраас дараа жилийнхээ тайланд адилхан утгатайгаар орно. Харин шинэ эх үүсвэрүүдийг 100 тэнцүү бүлэг болгон хуваах аргаар (matching percentiles) стандарчилна. Улсуудын зэрэглэл (оноо биш) нь эх үүсвэр бүрээс гарч ирэх мэдээллийн процесс, өөрөөр хэлбэл, өмнөх жилийн CPI болон шинэ эх үүсвэрийн стандартчилагдсан утгуудын аль нэгээр тодорхойлогдоно. Жишээ нь, 2005 онд шинэ эх үүсвэрээр Их Британи-4.2, Сингапур-3.9, БНХАУ-2.8, Малайз-2.7, БНЭУ-2.4 гэсэн оноо тогтоожээ. Эдгээр таван улсын 2004 оны CPI-үүд нь харгалзан 8.6, 9.3, 3.4, 5.0, 2.8 байсан. Тэгвэл 100 тэнцүү хэсэгт хуваах аргаар, энэ хоёр мэдээллийг нэгтгэвэл Их Британи хамгийн сайн 9.3, удаахад нь Сингапур-8.6, БНХАУ-5.0, Малайз-3.4, БНЭУ-2.8 гэсэн зэрэглэлтэй болно.

Энэ арга нь ялгаатай тархалттай индексүүдийг нэгтгэхэд хамгийн тохиромжтой арга байдаг гэж үздэг. Кардинал мэдээлэл ашиглагдахгүй зөвхөн ординал мэдээлэл оноог тодорхойлдог. Стандарчилалын өөр сонголтод аргуудыг ашиглаж болох боловч тэдгээрийн зарим нь хүчтэй таамаглал оноодгоороо бодит бус байх хандлагатай байдаг. 100 тэнцүү хэсэгт хуваах арга нь ч гэсэн эх үүсвэрүүдийн оноог бус зэрэглэлийг ашиглан зарим боломжит мэдээллийг хаядаг боловч түүний бүх үр дүнгээ [0;10] интервалын утгуудаар илэрхийлэх чадвартай байдгаараа давуу талтай.

Алхам 2.

Дээр тэмдэглэсэн интервалд тодорхойлогдсон стандартчилагдсан утгуудыг олж авсны дараа эдгээрийн энгийн дунджийг тооцох боломжтой болно. Үүний үр дүнд гарч ирэх индекс өмнөх жилийн CPI-ийн стандарт хазайлтаас бага стандарт хазайлттай байна. Хоёр дахь зохицуулалтыг хийхгүй бол индекс нь тасралтгүй буурах эсвэл өсөх хандлагатай болдог. Жишээ нь, Финлянд өмнөх жилийнхээ оноог давтсан гэвэл энэ нь бүх эх үүсвэрээс хамгийн сайн нь байна гэсэн үг. Хэрвээ энэ оноо нь эх үүсвэрүүдийн дунд хоёрдахь нь байсан бол 100 тэнцүү хэсэгт хуваах арга болон нэгтгэх үйлдлийн дараа үүний стандартчилагдсан утга нь өнөөгийн утгаас бага утга авна. Эх үүсвэрүүдийн дунд тархалтын ялгаатай байдал зайлшгүй байх учраас Финланд Улсын оноо зайлшгүй муудах болно. Тиймээс энэ тасралтгүй хандлагаас зайлахын тулд хоёр дахь стандартчлалыг хийдэг.

Энэ зорилгод хүрэхийн тулд илүү хүнд стандартчлалын процесс “бета-шилжүүлэг (beta-transformation)”-ийг ашигладаг. Энэ монотон хувиргалтын гол санаа нь [0;10] хэмжээсийг хадгалан, өмнөх жилийн утгын стандарт хазайлтыг нэмэгдүүлэх явдал байдаг. Тодруулбал, утга бүрийг дараахь функцээр шилжүүлнэ.

$$10 \cdot \int_0^1 \left(\frac{X}{10}\right)^{\alpha-1} \left(1 - \frac{X}{10}\right)^{\beta-1} dX$$

Хамгийн чухал зүйл нь α, β параметруудыг олох явдал бөгөөд үүний үр дүнд индексийн дундаж болон стандарт хазайлт урьдчилан тодорхойлсон интервалд өмнөх жилийн харгалзах үзүүлэлтүүдээс өсөж гардаг. Тухайлбал, 2005 оны CPI-ийн тооцоололд $\alpha=1.135, \beta=1.165$ байна.

Товч нэгтгэвэл хамгийн эхлээд алхам 1-ээр стандартчилагдсан бүх утганд “бета-шилжүүлэг”-ийг хийнэ. Үүний

дараа шилжүүлсэн утгуудын дунжийг тодорхойлбол энэ нь тухайн улсын оноо болно.

Итгэх хэмжээ. 2001 оноос эхлэн, улс орнуудын дундаж онооны стандарт хазайлтын тодорхойлолтыг ашиглан 95%-ийн итгэх интервалыг тодорхойлж ирсэн. Энэ арга нь дараахь таамаглалууд хангагдаж байхыг шаарддаг. Үүнд:

- Эх үүсвэрийн утгуудад тодорхой бус, тохиромжгүй байдал байхгүй байх
- Эдгээр утга нь бие биенээсээ хамааралгүй байх
- Санамсаргүй алдаанууд нь хоорондоо хамааралгүй байх

Статистикийн хувьд эхний хоёр таамаглал хангагдсан байх нь хүндрэлтэй, боломжгүй

байдаг боловч нормал тархалт болон ямар ч тархалтын хувьд үнэн байдаг тестүүдийг ашигласнаар энэ асуудлыг шийдэж болдог.

Одоо ашиглаж байгаа стандартчлалын техник болон бусад аргачлалын хоорондын ялгааг харуулахын тулд эрдэмтэд бүрэн параметрын бус аргачлалыг хэрэглэн илүү боловсронгуй болгох судалгаа, шинжилгээг хийж байгаа.

2. Хүснэгт 3. Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний утга

Херитэж Сан болон Уолл Стрийт Журналын хамтран 1995 оноос эхлэн жил бүр эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” тайлан дахь Монгол Улсын индексийн утгууд

Үзүүлэлт	Он											
	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Худалдаа	4.5	3.5	3.5	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.5	1.5	1.5	2.5
ЗГ-ын санхүүгийн дарамт	4.0	5.0	3.8	3.9	3.8	4.1	3.8	4.3	4.6	4.5	3.5	3.3
ЗГ-ын оролцоо	5.0	5.0	2.5	3.5	3.0	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5
Мөнгөний бодлого	5.0	5.0	5.0	5.0	5.0	4.0	4.0	3.0	3.0	2.0	2.0	2.0
Гадаадын хөрөнгө оруулалт	2.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	2.0
Банк	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	2.0
Цалин ба үнэ	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	2.0	2.0	2.0	2.0
Өмчийн эрх	2.0	2.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	4.0
Зохицуулалт	3.0	3.0	3.0	3.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0
Албан бус сектор	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	4.0
Ерөнхий	3.5	3.6	3.3	3.1	3.2	3.1	3.0	3.0	3.0	2.9	2.8	2.8

Эх сурвалж: <http://www.heritage.org/research/features/index/downloads.cfm#scores>

3. Хавсралт: Монгол Улсын институцийн хөгжлийн онолын шинжилгээ

Хүснэгт 1. ДНБ болон Ажиллагсад

Он	ДНБ (2000 оны үнээр, тэрбум төг)	Ажиллагсад (мянга)
1995	886366.08	767.6
1996	907222.03	791.8
1997	943496.07	788.3
1998	976824.18	809.5
1999	1008236.01	813.6
2000	1018885.68	809.0
2001	1029342.42	832.3
2002	1070990.94	870.8
2003	1130411.85	926.5
2004	1249958.10	950.5

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 1995-2004

Капиталын тооцоо.

$$K_t = (1 - \rho)K_{t-1} + I_t$$

гэсэн ялгаварт тэгшитгэл нь t үеийн капиталын хэмжээ нь $t-1$ үеийн капитал r гэсэн түвшингээр элэгдсэний дараахь капитал дээр t үеийн хөрөнгө оруулалтыг нэмсэнтэй тэнцүү байна гэсэн хөрөнгө оруулалт, капиталын хоорондын хамаарлыг илэрхийлнэ. Тэгвэл уг тэгшитгэлийн хоёр талаас натурал логарифм авбал дараахь үр дүн гарна.

$$\begin{aligned} \ln K_t &= \ln \left[\sum_{i=0}^{t-1} (1-\rho)^i I_{t-i} + (1-\rho)^t K_0 \right] \\ &\approx \ln 2 + \frac{1}{2} \left[\ln \sum_{i=0}^{t-1} (1-\rho)^i I_{t-i} + \ln (1-\rho)^t K_0 \right] \\ &= \ln 2 + \frac{1}{2} \ln \sum_{i=0}^{t-1} (1-\rho)^i I_{t-i} + \frac{t}{2} \ln (1-\rho) + \frac{1}{2} \ln K_0 \end{aligned}$$

Энд,

K_0 - капиталын анхны өртөг.

Дээрх үр дүнг гаргахад дараахь дөхөлтийг ашигласан.

$$\ln(x+y) \approx \ln 2 + \frac{1}{2} \ln(x+y) + \frac{1}{8} (\ln x + \ln y)^2 + \dots$$

Энд, $x = \sum_{i=0}^{t-1} (1-\rho)^i I_{t-i}$, $y = (1-\rho)^t K_0$ байна.

Капиталын натурал логарифмыг тооцох дээрх томъёоллоо ашиглан тооцоход дараахь үр дүн гарч байна.

Хүснэгт 2. $\ln K$ -ийн тооцоолсон үр дүн

Он	1995	1996	1997	1998	1999
$\ln K$	12.16	12.53	12.74	12.88	12.99

Он	2000	2001	2002	2003	2004
$\ln K$	13.05	13.10	13.14	13.18	13.21


Эх сурвалж: Судлаачийн өөрийн тооцоолол

Хүснэгт 3. 1-р загварын үнэлгээний үр дүн

Dependent Variable: LNY
Method: Least Squares
Date: 06/18/06 Time: 22:40
Sample: 1995 2004
Included observations: 10

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
YEAR	-0.037030	0.013783	-2.686601	0.0362
LNK	0.146357	0.067504	2.168113	0.0733
LNL	1.898711	0.178580	10.63224	0.0000
INS	-0.197986	0.172771	-1.145946	0.2955
R-squared	0.933194	Mean dependent var		13.83256
Adjusted R-squared	0.899791	S.D. dependent var		0.103182
S.E. of regression	0.032663	Akaike info criterion		-3.715969
Sum squared resid	0.006401	Schwarz criterion		-3.594935
Log likelihood	22.57984	F-statistic		27.93742
Durbin-Watson stat	1.744183	Prob(F-statistic)		0.000636

Хүснэгт 4. 1-р загварын үлдэгдлийн нормаль тархалтын тест



Хүснэгт 5. 2-р загварын үнэлгээний үр дүн

Dependent Variable: LNY

Method: Least Squares


Date: 06/18/06 Time: 23:46

Sample: 1995 2004

Included observations: 10

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	15.16389	0.211856	71.57622	0.0000
INS	-0.423147	0.067185	-6.298210	0.0002
R-squared	0.832171	Mean dependent var		13.83256
Adjusted R-squared	0.811192	S.D. dependent var		0.103182
S.E. of regression	0.044835	Akaike info criterion		-3.194814
Sum squared resid	0.016081	Schwarz criterion		-3.134297
Log likelihood	17.97407	F-statistic		39.66745
Durbin-Watson stat	1.242839	Prob(F-statistic)		0.000233

Хүснэгт 6. 2-р загварын үлдэгдлийн нормаль тархалтын тест



4. Хавсралт: Монголын эдийн засгийн өсөлтийн эх үүсвэрүүд: салбараар ба хэвшлээр

Монголын эдийн засгийн өсөлт 1997-2005 онуудад салбарын бүтцээр

Дараахь тэмдэглэгээг хийе.

- $C_1^{96}, C_2^{96}, \dots, C_{15}^{96}$ – ДНБ-ий 15 салбарын 1996 оны хэмжээ
- $g_1^{97}, g_1^{97}, \dots, g_{15}^{97}$ – ДНБ-ий 15 салбарын 1997 онд өссөн өсөлтийн хувь
- $g_1^{98}, g_1^{98}, \dots, g_{15}^{98}$ – ДНБ-ий 15 салбарын 1998 онд өссөн өсөлтийн хувь
- ...
- $g_1^{05}, g_1^{05}, \dots, g_{15}^{05}$ – ДНБ-ий 15 салбарын 2005 онд өссөн өсөлтийн хувь
- $G_{97}, G_{98}, \dots, G_{05}$ – 1997-2005 онуудын нийт эдийн засгийн өсөлтийн хувь
- Y_{96} – 1997 оны ДНБ-ий хэмжээ
- ...
- Y_{05} – 2005 оны ДНБ-ий хэмжээ

1996 оны хувьд дараахь тэнцэтгэл биелэнэ.

$$C_1^{96} + C_2^{96} + \dots + C_{15}^{96} = Y_{96}$$

1997 онд салбарууд нь харгалзах хувиар өссөн гэвэл:

$$C_1^{96} (g_1^{97} + 1) + C_2^{96} (g_2^{97} + 1) + \dots \\ \dots + C_{15}^{96} (g_{15}^{97} + 1) = Y_{97} = Y_{96} (G_{97} + 1)$$

1998 онд салбарууд мөн харгалзах хувиар өссөн гэвэл:

$$C_1^{96} (g_1^{97} + 1)(g_1^{98} + 1) + C_2^{96} (g_2^{97} + 1)(g_2^{98} + 1) + \dots \\ \dots + C_{15}^{96} (g_{15}^{97} + 1)(g_{15}^{98} + 1) = Y_{98} = \\ = Y_{96} (G_{97} + 1)(G_{98} + 1)$$

Энэ мэтчилэн 2005 хүртэл бичвэл:

$$C_1^{96} \prod_{i=97}^{05} (g_1^i + 1) + C_2^{96} \prod_{i=97}^{05} (g_2^i + 1) + \dots \\ \dots + C_{15}^{96} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1) = Y_{05} = Y_{96} \prod_{i=97}^{05} (G_i + 1)$$

1996-2005 оны хоорондох нийт өсөлтийн хувийг тооцвол:

$$\frac{C_1^{96} \prod_{i=97}^{05} (g_1^i + 1)}{Y_{97}} + \frac{C_2^{96} \prod_{i=97}^{05} (g_2^i + 1)}{Y_{97}} + \dots$$

$$\dots + \frac{C_{15}^{96} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1)}{Y_{97}} = \frac{Y_{05}}{Y_{96}} = \frac{Y_{96} \prod_{i=97}^{05} (G_i + 1)}{Y_{96}}$$

$$\left(\frac{C_1^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_1^i + 1) + \frac{C_2^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_2^i + 1) + \dots \right)$$

$$\dots + \frac{C_{15}^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1) \Big) = \frac{Y_{05}}{Y_{96}} = \prod_{i=97}^{05} (G_i + 1)$$

Дээрх илэрхийллээс 1996-2005 оны хоорондох эдийн засгийн нийт өсөлтийн хувийг 15 салбар хэрхэн бүрдүүлсэн, ямар хэмжээтэйг бий болгосныг 1996 оны салбар тус бүрийн ДНБ-д эзлэх хувийн жинг өсөлтийн хувиудын үржвэрээр үржүүлэн тодорхойлж болохоор харагдаж байна.

Холбогдох тоон өгөгдлүүд дээрх аргачлалаа ашиглан тооцвол дараахь үр дүн гарч байна.

№	Салбар	$\prod_{i=97}^{05} (g_j^i + 1)$	1996 оны салбарын бүтэц, $\left(\frac{C_j^{96}}{Y_{96}} \right)$	$\frac{C_j^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_j^i + 1)$
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	0.952	0.4378	0.4168
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	1.817	0.1040	0.1889
3	Боловсруулах үйлдвэр	1.066	0.0594	0.0633
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	1.310	0.0223	0.0292
5	Барилга	1.772	0.0276	0.0488
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	2.244	0.1670	0.3746
7	Зочид буудал, зоогийн газар	1.513	0.0090	0.0136
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2.742	0.0740	0.2030
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1.676	0.0177	0.0297
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	2.262	0.0078	0.0177
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	1.078	0.0286	0.0308
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	1.079	0.0343	0.0371
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.233	0.0257	0.0316
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	3.549	0.0021	0.0074
	Дэд нийлбэр $\left(\sum_{j=1}^{14} \frac{C_j^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_j^i + 1) \right)$			1.4926
15	Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ			-0.0277
	$\prod_{i=97}^{05} (G_i + 1)$			1.4649

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн

Үр дүнгээ өмнөх илэрхийлэлд оруулбал:

$$\sum_{j=1}^{14} \frac{C_j^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_j^i + 1) + \frac{C_{15}^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1) = \prod_{i=97}^{05} (G_i + 1)$$

$$1.4926 + \frac{C_{15}^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1) = 1.4649$$

$$\frac{C_{15}^{96}}{Y_{96}} \prod_{i=97}^{05} (g_{15}^i + 1) = -0.0277$$

Санхүүгийн шууд бус үйлчилгээний салбарын 1996-2005 оны хооронд нийт эдийн засгийн өсөлтийн хувийг 2.77 пунктээр бууруулжээ.

Дээрх хугацаанд эдийн засаг нийтдээ 46.5 хувиар өсчээ. Энэ хүснэгтээс энэ 46.5 хувийн хичнээн пунктийг нь тухайн салбар бий болгосныг харах боломжгүй харин эдийн засаг нийтдээ 1.4649 дахин өссөний хичнээнийг нь тухайн салбар бий болгосныг харж болж байна. Тухайлбал, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 0.4168 байгаа нь 1.4649-ийн ийм хэмжээтэйг уг салбар бий болгосныг илтгэнэ. Тэгвэл гол зорилго цэвэр өсөлтийн хувь буюу 0.4649-ийн хичнээнийг нь тухайн салбар бий болгосныг тодорхойлох явдал учир дээрх харьцааг ашиглан пропорцлон тодорхойлъё. Үр дүнг дараахь хүснэгтэнд харуулав.

№	Салбар	
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	0.1323
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	0.0600
3	Боловсруулах үйлдвэр	0.0201
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.0093
5	Барилга	0.0155
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	0.1189
7	Зочид буудал, зоогийн газар	0.0043
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	0.0644
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.0094
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	0.0056
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	0.0098
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	0.0118
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.0100
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.0023
15	Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-0.0088
	НИЙТ	0.4649

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн

Үр дүнгээс харвал 1996-2005 оны хооронд эдийн засаг нийтдээ 46.5 хувиар өссөний 13.23 пунктыг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, 11.89 пунктыг нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээний салбар, 6.44 пунктыг нь тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбар, 6 пунктыг нь уул уурхай, олзворлох үйлдвэрлэлийн салбар гэх мэтчилэн бий болгожээ.

Хувийн хэвшил

Өмнөх хэсэгт тодорхойлсон аргачлалаа зөвхөн хувийн хэвшлийн үйлдвэрлэлд оруулан 1999-2005 оны хооронд хувийн хэвшлийн үйлдвэрлэл, салбараар нийт эдийн

засгийн өсөлтөд ямар нөлөө үзүүлснийг тодорхойлж болно. Өмнөх хэсгээс ялгаатай нь тоон өгөгдлийн боломжоос шалтгаалан хамрах оных байгаа учраас 1999-2005 оны хооронд нийт эдийн засаг хичнээн хувиар өссөнийг эхлээд тодорхойлох хэрэгтэй. Тооцох аргачлалын хувьд адилхан.

Өмчийн хэлбэрээр тооцож байх үед аргачлалын тэнцэтгэл биш зөвхөн нэг хэсгийг нь төлөөлөх болно. Өөрөөр хэлбэл улсын болон хувийн хэвшлийн гэж ангилсан үед зөвхөн аль нэгийг илэрхийлнэ. Тэгвэл уг илэрхийлэл хувийн хэвшлийн үйлдвэрлэлийг илэрхийлж байгаа гэж үзвэл өмнөхтэй яг адилхан тооцоо хийнэ.

№	Салбар	1999 оны хувийн хэвшил ДНБ-д эзлэх хувийн жин, $\frac{C_j^{99}}{Y_{99}}$		
		$\prod_{i=0}^{05} (g_j^i + 1)$	$\frac{C_j^{99}}{Y_{99}}$	$\frac{C_j^{99}}{Y_{99}} \prod_{i=0}^{05} (g_j^i + 1)$
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	0.8391	35.64	0.2991
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	1.8335	4.83	0.0885
3	Боловсруулах үйлдвэр	1.3874	4.46	0.0618
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	1.1031	0.00	0.0000
5	Барилга	1.8891	2.21	0.0418
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	2.3945	16.63	0.3983
7	Зочид буудал, зоогийн газар	1.6220	1.12	0.0182
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	3.5702	3.76	0.1342
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	7.4697	0.62	0.0466
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	2.8174	0.79	0.0221
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	1.0000	0.00	0.0000
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	0.9323	0.47	0.0044
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.8037	0.11	0.0032
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	3.6722	0.12	0.0045
	НИЙТ			1.1227
	$\prod_{i=0}^{05} (G_i + 1)$			1.3181

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн

$$\sum_{j=1}^{14} \frac{C_j^{99}}{Y_{99}} \prod_{i=0}^{05} (g_j^i + 1) + \frac{C_{15}^{99}}{Y_{99}} \prod_{i=0}^{05} (g_{15}^i + 1) + \left(\begin{array}{c} \text{Улсын өмчийн үйлд-} \\ \text{вэрлэлийн нөлөө} \end{array} \right) = \prod_{i=0}^{05} (G_i + 1)$$

$$1.1227 + \frac{C_{15}^{99}}{Y_{99}} \prod_{i=0}^{05} (g_{15}^i + 1) + \left(\begin{array}{c} \text{Улсын өмчийн үйлд-} \\ \text{вэрлэлийн нөлөө} \end{array} \right) = 1.3181$$

$$\frac{C_{15}^{99}}{Y_{99}} \prod_{i=0}^{05} (g_{15}^i + 1) + \left(\begin{array}{c} \text{Улсын өмчийн үйлд-} \\ \text{вэрлэлийн нөлөө} \end{array} \right) = 0.1954$$

1999-2005 оны хооронд Монголын эдийн засаг нийтдээ 31.81 хувь бувуу 1.3181 дахин өсчээ. Үүний 12.27 пункт буюу 1.1227-г нь нийт хувийн хэвшлийнхэн бий болгожээ. Салбар бүрийн хувийн хэвшил яг ямар хэмжээг нь бий болгосныг өмнөх хэсэгт хэрэглэсэн пропорцын аргаар тодорхойлъё. (хүснэгт)

Үр дүнгээс харахад дээрх онуудад эдийн засаг нийтдээ 31.81 хувь өссөний 27.1 пунктийг нь хувийн хэвшил бий болгожээ.

Үлдсэн нь санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ салбарын хувийн хэвшил болон улсын өмчийн үйлдвэрлэлээр бий болсон байна. 27.1 пунктын 9.61-ыг нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээний салбар, 7.22-ыг нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар, 3.24-ыг нь тээвэр, агуулахын аж ахуй, тээврийн салбар, 2.14-ыг нь уул уурхай, олзворлох салбар гэх мэтчилэн бий болгожээ.

№	Хувийн хэвшил 1999-2005 онуудад Монголын эдийн засгийн өсөлт оруулсан хувь нэмэр, салбараар	Цэвэр өсөлтийн хувь
1	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	0.0722
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	0.0214
3	Боловсруулах үйлдвэр	0.0149
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.0000
5	Барилга	0.0101
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	0.0961
7	Зочид буудал, зоогийн газар	0.0044
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	0.0324
9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.0112
10	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	0.0053
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	0.0000
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	0.0011
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.0008
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.0011
НИЙТ		0.2710

Эх сурвалж: Албан ёсны тоон өгөгдлүүдийг ашиглан судлаачийн тооцсон үр дүн

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТРАНСАКЦИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ХАВСРАЛТ

Хүснэгт: Унгар улсын ДНБ /өнөөгийн үнээр, сая крон/, эдийн засгийн үйл ажиллагаагаар

Он	1995	1996	1997	1998	1999
ДНБ	3,500,407	3,950,839	4,377,215	4,763,578	4,886,168
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	150,372	164,915	168,352	173,922	165,871
Загас агнуур	1,528	1,665	1,596	1,676	1,633
Уул уурхай олборлох үйлдвэр	60,652	64,425	66,385	65,916	60,600
Боловсруулах үйлдвэр	1,251,099	1,427,629	1,658,549	1,829,273	1,852,250
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	218,745	245,364	238,169	253,924	261,882
Барилга	338,345	398,646	424,166	447,925	449,302
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	318,324	352,883	375,017	404,800	426,244
Зочид буудал, зоогийн газар	74,305	86,696	95,654	103,956	100,637
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	283,921	309,387	351,771	380,054	392,014
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	92,456	108,426	116,309	142,648	143,801
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	353,875	390,088	439,388	488,293	511,930
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	106,148	113,777	131,614	138,927	161,085
Боловсрол	77,307	89,858	89,686	92,354	101,887
Эрүүл мэнд, нийгмийн халамж	89,190	96,586	107,050	111,900	116,772
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	83,930	100,242	113,273	127,798	140,042
Private households with employed persons	210	252	236	212	218

Эх сурвалж: Hungarian Central Statistical Office <http://portal.ksh.hu>

Хүснэгт: Унгар улсын ДНБ /өнөөгийн үнээр, сая крон/, эдийн засгийн үйл ажиллагаагаар

/үргэлжлэл/

Он	2000	2001	2002	2003	2004
ДНБ	5,378,966	5,874,003	6,033,167	6,385,402	7,042,977
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	174,757	187,479	173,775	171,613	185,769
Загас агнуур	1,574	1,539	1,690	1,785	1,767
Уул уурхай олборлох үйлдвэр	60,463	64,613	66,078	64,147	72,748
Боловсруулах үйлдвэр	2,119,831	2,379,653	2,357,003	2,396,941	2,787,711
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	260,428	294,734	300,760	307,326	328,275
Барилга	458,507	485,653	523,991	570,180	612,084
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	503,879	522,375	555,110	600,129	643,094
Зочид буудал, зоогийн газар	103,540	105,020	104,753	112,471	119,678
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	439,961	483,105	506,930	571,691	610,733
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	136,764	157,328	171,252	183,379	199,448
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	564,770	600,177	632,092	704,428	743,582
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	171,950	180,873	198,181	218,797	218,534
Боловсрол	105,898	117,656	126,032	140,032	146,303
Эрүүл мэнд, нийгмийн халамж	122,152	134,399	149,132	159,301	170,984
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	154,242	159,143	166,065	182,811	201,844
Private households with employed persons	250	256	323	371	423

Эх сурвалж: Hungarian Central Statistical Office <http://portal.ksh.hu>

Хүснэгт: Эстони улсын ДНБ /өнөөгийн үнээр, сая крон/, эдийн засгийн үйл ажиллагаагаар

Он	2000	2001	2002	2003	2004
ДНБ	95,491	108,218	121,372	132,904	146,693
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	3,883	4,248	4,213	4,070	4,714
Загас агнуур	267	292	300	282	265
Уул уурхай олборлох үйлдвэр	1,006	1,045	1,172	1,306	1,374
Боловсруулах үйлдвэр	15,206	17,825	19,558	20,942	22,317
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	2,721	3,114	3,596	4,283	4,601
Барилга	4,780	5,440	6,345	7,326	8,445
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	10,510	12,652	14,874	16,811	18,924
Зочид буудал, зоогийн газар	1,354	1,513	1,649	1,713	1,974
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	12,480	13,227	14,073	15,125	16,073
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	3,480	3,709	4,505	4,592	5,118
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	14,915	17,526	19,662	21,754	24,731
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	5,246	5,580	6,232	6,902	7,448
Боловсрол	4,398	4,884	5,356	5,695	6,162
Эрүүл мэнд, нийгмийн халамж	2,594	2,784	3,028	3,681	4,118
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2,398	2,856	3,352	3,852	4,330
Бүтээгдэхүүн дэх цэвэр татвар	10,246	11,517	13,449	14,565	16,092

Эх сурвалж: National Statistical Office of Estoni <http://www.stat.ee>

Хүснэгт: Латви улсын ДНБ /өнөөгийн үнээр, сая лат/, эдийн засгийн үйл ажиллагаагаар

Он	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
ДНБ	2,580	3,076	3,562	3,903	4,224	4,751	5,220	5,758	6,393	7,421
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	194	194	160	131	137	180	198	228	229	286
Загас агнуур	9	8	6	9	12	16	14	10	7	8
Уул уурхай олборлох үйлдвэр	3	4	5	5	5	5	9	11	16	19
Боловсруулах үйлдвэр	456	512	635	554	521	584	652	711	759	876
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	112	131	142	164	151	151	162	169	179	201
Барилга	103	116	137	212	243	262	262	287	321	388
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	230	379	460	521	601	713	818	923	1,023	1,258
Зочид буудал, зоогийн газар	22	27	36	38	43	49	58	62	80	108
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	327	420	480	516	522	598	721	786	877	983
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	115	140	137	110	170	209	207	261	282	337
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	230	233	310	402	498	596	659	720	783	922
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	161	191	242	289	334	348	369	410	443	475
Боловсрол	124	146	157	190	204	224	237	257	322	347
Эрүүл мэнд, нийгмийн халамж	104	109	120	136	142	143	150	154	169	190
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	75	100	119	130	153	173	185	198	223	263
Бүтээгдэхүүн дэх татвар	315	360	421	494	486	498	518	570	677	759

Эх сурвалж: National Statistical Office of Latvia <http://www.csv.lv>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- a Фрейзер Институцийн индекс
- b Aghion & Howitt (1998)
- c Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ гэсэн салбарын хувийн хэвшлийн эзлэх хувь гэсэн үзүүлэлт статистикийн эмхтгэлд байхгүй байгаа учраас уг салбарын хувийн хэвшлийн үзүүлсэн нөлөөллийг тооцох боломжгүй байлаа. Уг салбар нь үргэлж сөрөг үйлдвэрлэлтэй байгаа учраас нийт эдийн засгийн өсөлтийн хувьд сөрөг нөлөөлөл үзүүлэх нь тодорхой юм. Тооцогдсон хувийн хэвшлүүдийн нийт өсөлтийн хувьд эзлэх пунктын нийлбэр болон нийт эдийн засгийн өсөлтийн хувийн хоорондын зөрүү нь дээрх салбарууд дахь улсын эзэмшлийн үйлдвэрүүд болон дээр дурдсан тооцох боломжгүй нэг салбарын нийт нөлөөллийн нийлбэр байна. Нэг салбар тооцогдоогүй нь бусад салбарын нөлөөллийн тооцоонд огт хамааралгүй учраас ач холбогдолтой ямар нэгэн асуудал үүсгэхгүй юм.
- d “The Evolution Of Efficient Markets In History” By Douglass C. North, Washington University, St. Louis
- e Фрейзер институт, Эдийн Засгийн эрх чөлөөний тайлан, 2004, Бүлэг I
- f Фрейзер институт, Эдийн Засгийн эрх чөлөөний тайлан, 2004, Бүлэг I
- g “The Evolution Of Efficient Markets In History” by Douglass C. North, Washington University, St. Louis
- h Дуглас Норт, Institutional Competition.
- i Economic Performance Through Time: The Limits to Knowledge, 1996, Douglass C. North, Washington University, St. Louis
- j Adam Smith, The Wealth of Nations, 1776
- k Adam Smith and Free Trade, Roy Douglas, 13th International Conference on Land Value Taxation and Free Trade. September 1973
- l Aron (2000), Rodrik (2000), Tavares & Wacziarg (2001)
- m Demirguc-Kunt & Maksimovic (1996)
- o Transparency International Mongolia, Sumati Luvsandender, Chairperson, Central POB-659, Ulan Bator 13,
- p The methodology of the TI Corruption Perception Index 2005
- q Эдийн засгийн агентууд нь трансакцийн зардлыг бусад зардлаас ялгахгүй, цэвэр үр ашгаа л хамгийн их байлгана. Цэвэр үр ашиг нь нийт үр ашиг болон нийт зардлын зөрөө бөгөөд нийт зардал нь трансакцийн зардал болон бусад зардлаас бүрдэнэ.
- r Wallis & North нар “трансакцийн функц” болон “трансформацийн функц” гэдэг ойлголтыг хэрэглэсэн.
- s Some Fundamental Puzzles In Economic History/Development By Douglass C. North*, Washington University, St. Louis
- t Institutions, Organizations And Market Competition*, Douglass C. North, Washington University, St. Louis
- u Measuring Transaction Costs and Institutional Change in the U.S. Commercial Banking Industry By Margaret M. Polski, Institute for Development Strategies, Indiana University, 2000
- v The Costs of Exchange, Alexandra Benham and Lee Benham, The Ronald Роналд Коуз Institute and Washington University in St. Louis
- w Херитэж Сангийн “Эдийн Засгийн Эрх Чөлөөний Индекс-2005”
- x МҮХАҮТ “Монголын эдийн засаг бизнесийн орчин”, 2004

